		• (Photo Resolution) 24MP / 20MP / 16MP / 12MP / 10MP / 8MP / 5MP / 3MP / 2MP Видео нягтрал (Video Resolution): • 2K / 1080P / 720P Цэнэглэдэг 3000mAh батарей Видео формат • (Video Format):MP4 Зургийн формат • (Image Format):JPG Micro-SD карт, 64GB PC / HDMI гаралт (PC/HDMI View) IR алсын удирдлага (IR Remote) Хамгийн ихдээ 5 метрийн зайд ажиллана • Компьютерийн үйлдлийн системийн дэмжлэг (PC Operating System) Windows XP, Windows 7, Windows 8.1, Windows 10, Windows 11, macOS 10.6.5 ба түүнээс дээш Гэрлийн эх үүсвэр • (Light Source) 12 LED гэрэл 2 хажуугийн гэрэл Зургийн нягтрал сонгох: • 2MP – 24MP Видео нягтрал сонгох: • 2K / 1080P / 720P • Экспозиц: +3.0 – -3.0 LCD дэлгэцийн гэрэлтүүлэг: • 10% – 100% Cross line (төвийн шугам): асаах / унтраах Цахилгаан давтамж: 50Hz / 60Hz Формат: бүх өгөгдөл устгах / форматлах			
41		Төрөл • 55" Narrow Bezel (0.88mm - 1.8mm), 500-700 nits brightness, 24/7 operation grade. Видео хананы нийт хэмжээгээр (жишээ нь 110" - 150") хийгдсэн, 20-40 цэгээр зэрэг мэдрэгчтэй рам.	Багц	1	

		CPU i7 (13th Gen), GPU RTX 4060/4070 (Олон дэлгэцийн нягтаршил даах), 32GB RAM. Дүрсийг олон дэлгэц рүү хуваах, 4K/8K оролт дэмждэг процессор. Дэлгэц хоорондын ирмэг (Bezel) маш нарийн байх (Нийлбэр нь 1.8мм-ээс ихгүй). Ирмэг бүдүүн байвал текст уншихад саадтай. Мэдрэгчийн хариу үйлдэл үзүүлэх хугацаа (Touch Latency) 10ms-ээс бага байх. Дэлгэцийн бэхэлгээ нь "Pop-out" механизмтай байх. Ингэснээр аль нэг дэлгэц эвдрэхэд ханыг бүхэлд нь буулгахгүйгээр засварлах боломжтой.			
42		Ерөнхий • 360° хэвтээ, 90° босоо эргэх боломжтой, бат бөх металл их бие. Дотор нь өндөр нягтаршилтай дэлгэц агуулсан. Чадал • 4к 60fps дүрс дамжуулах өргөн өнцгийн камер. Тасралтгүй тэжээлийн кабель (PoE) болон хамгаалалтын утас.	ШИРХЭГ	2	
43	Augmented Reality (AR) Элсэн хайрцаг /интерактив/	Төрөл • Short Throw Projector Laser Light Source, Ерөнхий • 4,000 - 5,000 Lumens, WXGA эсвэл Full HD. Ойрын зайнаас том дүрс гаргах чадвартай • 3D Depth Sensor Microsoft Kinect v2 эсвэл Intel RealSense D435/D455. Элсний өндөр нам, хөдөлгөөнийг 3D-ээр мэдрэгч. Процессор PC CPU: • Intel i5/i7 (12-р үеэс дээш), GPU: NVIDIA RTX 3060/4060 (График боловсруулалтад чухал), 16GB RAM. • Металл эсвэл бат бөх модон хийцтэй хайрцаг. Проектор	ШИРХЭГ	2	

		болон мэдрэгчийг дээрээс нь бэхлэх гар (Arm) бүхий суурь. • Цагаан өнгийн, нарийн ширхэгтэй, тоос багатай цахиурлаг элс (Проектор дээрээс нь тусахад өнгө тод харагдах зориулалттай). • Нээлттэй эх сурвалжтай (UC Davis AR Sandbox) эсвэл арилжааны тусгай лицензтэй программ. Мэдрэгчийн нарийвчлал: • 3D мэдрэгч нь элсний 1см хүртэлх өндрийн өөрчлөлтийг мэдрэх чадвартай байх. • Проекторын тод байдал: Музейн ерөнхий гэрэлтүүлэгт элсэн дээрх өнгө уусаж харагдахгүй байхын тулд дор хаяж 4,000 ANSI Lumens байх шаардлагатай. Бат бөх байдал: Хүүхдүүд элсээр тоглох тул компьютер болон цахилгаан эд ангиуд элсний тоос орохоос бүрэн хамгаалагдсан, хаалттай хайрцагт байрлах.			
44	AR Static Viewer (Суурин AR нүдний шил)	Ерөнхий • 360° хэвтээ, 90° босоо эргэх боломжтой, бат бөх металл их бие. Дотор нь өндөр нягтаршилтай дэлгэц агуулсан. Дэлгэцийн чадал • 4к 60fps дүрс дамжуулах өргөн өнцгийн камер. Тасралтгүй тэжээлийн кабель (PoE) болон хамгаалалтын утас.	ШИРХЭГ	10	
45	Чихэвч	• Sennheiser HD 280 pro дүйцэх Төрөл: • Closed-back, арын тийш нь битүүсэн динамик стерео чихэвч (around-the-ear) Загвар: • Хөдөлгөөнд эвтэйхэн, эвхэгддэг дизайнтай, эргэж чаддаг чихний бөөрөнүүдтэй	Ширхэг	10	

		Давтамжийн хариу: • 8 Hz – 25 000 Hz -өргөн давтамжийн хүрээтэй, студийн хяналтад сайн тохирно Хэвлэлийн даралт • (SPL): ~102 dB – 113 dB (хамгийн их гарц) • Импеданс (Impedance): 64 Ω — ихэнх аудио төхөөрөмжтэй нийцнэ • Максимум хүчин чадал: 500 mW THD (нийт гармоник муруйлт): < 0.1 % Дуу тусгаарлалтын түвшин: • ~32 dB хүртэл гадна дуу чимээг бууруулна (passive noise attenuation) Холболт: • Сул, ороосон кабель (coiled), single-sided Кабель урт: • ~1.3 м – 3 м хүртэл сунгах боломжтой Коннектор: • 3.5 мм мини-джек + 6.3 мм (1/4″) адаптер багтсан Дуу чимээ өндөртэй орчинд дуу чимээг шингээж чадах чадвартай байх (High ambient noise attenuation).			
46	Компьютер	Процессор (CPU): • Intel Core i7-8100 Санах ой (RAM): • Kingston DDR4 16GB Хадгалах төхөөрөмж • (HDD/SSD): Kingston 512GB Эх хавтан (Motherboard): • H610M (агуужсан Gigabit Ethernet порттой) График карт (GPU): • AMD Onda 550 (Discrete/тусгаарлагдсан) болон түүнээс дээш үзүүлэлттэй байх	Ширхэг	2	

47	Дагалдах хэрэгслүүд	USB кабель, HDMI кабель, аудио кабель	Ширхэг	10	
48	Хүнд даацын U хэлбэртэй бэхэлгээний хавтан	Их хэмжээний жинг дэмжихэд зориулагдсан U (ю үсгийн) хэлбэртэй бат бөх бэхэлгээ байна.	Ширхэг	1	
49	Элсэн хайрцагт ширээ	Ширээний хэмжээ: • 1.7 × 1.32 м Проекцийн хэмжээ: • × 1.55 м Дэлгэцийн хэмжээ: • 10.1 инч Нягтрал (Resolution): • 1920 × 1080 Товшилтын горим (Touch mode): • Хүчлэгч мэдрэгчтэй (capacitive), 10 цэгт товшилт (ten-point touch) Ерөнхий • Зорилтот объектуудыг (жишээ нь, овоолсон элс) барих төхөөрөмжүүд (сомато-сенсор камер) ашиглан барьж, зураглалыг авдаг. • Зураг авсны дараа программ хангамжийн систем эдгээрийг шинжилж, баригдсан объектийг байрлуулсан газрын зураглалтыг өөрчилдөг, ингэснээр хөгжилтэй, сонирхолтой туршлагыг бий болгодог. • Систем нь хязгаарлалт тохируулгыг (Boundaries Calibration) дэмждэг. • Мөн гүнзгий сургалтын дэмжлэгтэй (Deep Learning Support).	Ширхэг	2	

		Үйлдлийн системтэй нийцдэг: • Windows 8, Windows 10			
50	Дэлгэцийн хөдөлгөөнт суурь хөл	Ерөнхий • Дэлгэцийг зөөвөрлөн ашиглах зориулалттай хөдөлгөөнт суурь хөл байна. • Бат бөх металл хийцтэй байна. Даац • Даац: ≥ 50 кг Хөдөлгөөн • Түгжээтэй дугуйтай (lockable wheels) байна. • Хялбар зөөвөрлөх боломжтой байна. Тохируулга • Дэлгэцийн налалт тохируулах боломжтой. • Дагалдах тоног төхөөрөмж байрлуулах тавиуртай байна. Нийлүүлэлт • Урьдчилсан хэмжилт, зураг төсөл батлуулах Угсралт, суурилуулалт багтсан байна.	ШИРХЭГ	10	
51	Transparent OLED дэлгэцтэй ухаалаг шил	Ерөнхий • Үзмэрийн дээр мэдээлэл давхарлан харуулах зориулалттай transparent OLED дэлгэцтэй шилэн хорго байна. • Музейн үзүүллэгт зориулсан тусгай хийцтэй байна. Дэлгэц • Хэмжээ: ≥ 55 инч • Нягтрал: Full HD (1920×1080) буюу түүнээс дээш • Ил тод байдлын хувь: ≥ 35% • Өндөр контрасттай OLED технологитой байна. Контент тоглуулах • 4K видео дэмжих медиа тоглуулагчтай байна. • LAN эсвэл Wi-Fi холболттой байна. • Видео болон зураг автоматаар тоглуулах боломжтой. Хийц • Тусгай захиалгын шилэн хорго хийцтэй байна. • Дэлгэц болон үзмэрийг нэгтгэсэн дизайнтай байна. Гэрэлтүүлэг • Дотор LED гэрэлтүүлэгтэй.	ШИРХЭГ	6	

		• Үзмэрийн өнгийг зөв харуулах өндөр чанарын гэрэлтүүлэгтэй. Ашиглалт • Тасралтгүй ажиллагаанд зориулагдсан. 100–240V тэжээлтэй.			
52	Transparency шилэн дэлгэц	Ерөнхий: • Агаарын бөмбөлөг үүсгэдэггүй, температурт тэсвэртэй, чийг ихтэй орчинд ашиглах боломжтой байх • Rear проекц нь шилэн эсвэл акрил дээр хялбар суурилуулж, шилэн дээр зураг гаргах (цонх шиг) эсвэл өөрийн дэлгэц бүтээх боломжтой байх	Ширхэг	9	
53	Interactive Floor систем	Ерөнхий • Шалан дээр интерактив дүрс проекцлон хэрэглэгчийн хөдөлгөөнд хариу үйлдэл үзүүлэх систем байна. • Музейн үзүүллэгт зориулсан иж бүрэн шийдэл байна. Проекцийн систем • Мэргэжлийн лазер проектортой байна. • Гэрэлтүүлэг: ≥ 8,000 lumen • 4K видео оролтыг дэмжинэ. • Ultra Short Throw линзтэй байна. Хөдөлгөөн мэдрэгч • Олон хэрэглэгчийн хөдөлгөөнийг бодит цагт илрүүлэх мэдрэгчтэй байна. • 360° орчныг хянах боломжтой байна. Медиа сервер • Интерактив контент боловсруулах өндөр хүчин чадалтай компьютер эсвэл сервертэй байна. • SSD хадгалах сантай байна. Программ хангамж • Интерактив контент ажиллуулах, калибровк хийх программтай байна. • Сүлжээгээр удирдах боломжтой. Суурилуулалт • Таазны бэхэлгээ, кабелийн иж бүрэн шийдэлтэй байна.	Багц	2	

		• Проекцийн зориулалтын шалны гадаргуу бүрдүүлсэн байна. Ашиглалт • 24/7 ажиллагаанд зориулагдсан. Суулгалт, тохиргоо багтсан байна.			
5 4	Төвлөрсөн удирдлагын сервер	Энэ нь 4K контент болон интерактив программ хангамжийг гацалтгүй ажиллуулах гол төхөөрөмж юм. Processor (CPU): Intel Core i7-13700K эсвэл AMD Ryzen 9 7900X-ээс дээш. Graphics (GPU): NVIDIA GeForce RTX 4070 Ti (12GB VRAM) эсвэл түүнээс дээш. (Олон проектор зэрэг залгах бол DisplayPort 1.4 гаралттай байх). Memory (RAM): 32GB DDR5 5200MHz+. Storage: 1TB NVMe M.2 SSD (System), 2TB Enterprise SSD (Content storage). Cooling: Шингэн хөргөлт эсвэл өндөр хүчин чадалтай агаарын хөргөлт (Музейн хаалттай шүүгээнд халахгүй байх). Chassis: 19-инчийн Rack-mount зориулалтын кэйс (Төхөөрөмжийн шүүгээнд байрлуулахад тохиромжтой). Проекторыг зайнаас асаах, гэрэл бүдгэрүүлэх зэрэг механик болон дижитал үйлдлийг зохицуулна. Серверээс хол зайд байгаа проектор руу дүрс дамжуулахад ашиглагдана.	Ширхэг	7	
5 5	Программ хангамж, лиценз	Ерөнхий • Дэлгэц, проектор болон интерактив системийг удирдах нэгдсэн программ хангамж байна. Үндсэн боломжууд • Төвлөрсөн удирдлагын интерфэйстэй байна. • Контент удирдлагын систем (CMS) багтсан байна. • Интерактив контент ажиллуулах болон удирдах боломжтой байна. Сүлжээ ба удирдлага • Олон төхөөрөмжийг сүлжээгээр удирдах боломжтой.	Ширхэг	7	

		• Контентыг алсаас шинэчлэх боломжтой. Лиценз • Нэг удаагийн (perpetual) лиценз эсвэл Дор хаяж 3 жилээс доошгүй хугацааны лиценз багтсан байна.			

___o0o___

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

ATA12932 6594204 9024070546

5. ҮЗҮҮЛЛЭГИЙН ДИЖИТАЛ КОНТЕНТИЙН ТОДОРХОЙЛОЛТ

I. НИЙТЛЭГ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Тусгай шаардлага: Дижитал контент, интерактивийг бүтээхдээ заавал тухайн үеэр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачдыг гэрээлж, бодит эх сурвалжид тулгуурласан байх.

1. Ерөнхий шаардлага

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1.1	Контентын хэл	Монгол, Англи (хадмал, аудио солих боломжтой)
1.2	Хүртээмж	Хадмал орчуулгатай, сонсголын бэрхшээлтэй иргэнд тохирсон дохионы хэлтэй байх
1.3	Ашиглалтын орчин	Музейн танхимд тасралтгүй 8–10 цаг ажиллах. /Музейн танхимд өдөр бүр тасралтгүй ажиллах зориулалттай байна./
1.4	Найдвартай ажиллагаа	Гацалтгүй, frame drop ≤5%
1.5	Системийн тогтвортой ажиллагаа	• Контент болон интерактив систем нь музейн орчинд тасралтгүй 72 цаг ажиллах туршилтыг амжилттай давах ёстой. • Систем нь автоматаар асаалт/унтраалт хийсний дараа гараар дахин ажиллуулах шаардлагагүйгээр хэвийн ажиллаж эхэлдэг байна. • Алдаа гарсан тохиолдолд систем автоматаар дахин эхлэх боломжтой байна.
1.6	Нэмэлт хэл	QR кодоор авах боломжтой
1.7	Насжилт	≥50,000 цаг

2. Контентын техникийн үзүүлэлт

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
2.1	Контентын төрөл	3D модель, анимейшн, интерактив сцен
2.2	Нягтрал	Full HD (1920×1080) ба түүнээс дээш
2.3	Кадрын давтамж	30–60 FPS (контентын төрлөөс хамааран)
2.4	Файлын формат	MP4 (H.264/H.265), PNG/JPEG
2.5	3D формат	FBX, OBJ, GLTF (эсхүл дүйцэхүйц)
2.6	Контентын чанарын шаардлага	• Видео болон анимейшн нь frame drop ≤5% байх • Дуу, дүрсний синхрончлол алдагдахгүй байх

		• Контент нь 24/7 ажиллагаанд тохирсон үйлдвэрлэлийн түвшний чанартай байна. • Контентын өнгө, гэрэлтэлт нь проектор болон дэлгэцийн орчинд калибрлагдсан байна.

3. Интерактив ажиллагаа

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
3.1	Оролт	Touch дэлгэц, товчлуур
3.2	Хариу үйлдлийн хугацаа	≤120 ms
3.3	Харагдах хэлбэр	Хэрэглэгч ойлгоход хялбар, логик дараалалтай
3.4	Олон хэрэглэгчийн горим	• Интерактив систем нь олон хэрэглэгч зэрэг ашиглах үед гацахгүй ажиллах • Touch төхөөрөмжийн хариу үйлдэл тогтвортой байх • Интерактив систем нь буруу үйлдлээс хамгаалах reset функцтэй байна

4. Систем, программ хангамж

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
4.1	Үйлдлийн систем	Windows, Linux эсвэл түүнтэй техникийн хувьд дүйцэхүйц үйлдлийн систем дээр ажиллах боломжтой.
4.2	Ажиллах орчин	Проектор, мэдрэгчтэй дэлгэцтэй нийцтэй
4.3	Суурилуулалт	Захиалагчийн байранд бүрэн суурилуулна
4.4	Интеграцийн шаардлага	• Контент нь музейн AV систем, проектор, дэлгэц, мэдрэгчтэй төхөөрөмжтэй бүрэн нийцтэй байна • Контент нь автомат эхлүүлэх (auto-start) горимтой байна • Төхөөрөмж унтарч асаагдсаны дараа контент автоматаар ажиллаж эхэлдэг байна

5. Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн

№	Агуулга	Тайлбар
5.1	Эцсийн файл	Ажиллах бэлэн контент
5.2	Эх файл	3D, видео, дизайн эх файлууд
5.3	Гарын авлага	Ашиглалт, засвар үйлчилгээ
5.4	Эх код ба өмчлөл	Гүйцэтгэгч дараах материалыг бүрэн хүлээлгэн өгнө: • Бүх эх файл (3D, видео, график, дизайн) • Программ хангамжийн source code • CMS системийн админ эрх • Суулгах болон сэргээх заавар

		Бүх контент болон программ хангамжийн өмчлөх эрх захиалагчид шилжинэ.

6. Баталгаат хугацаа

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
6.1	Баталгаа хугацаа	24 сараас доошгүй

7. Хүлээн авах шалгуур

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
7.1	Контентыг хүлээн авахдаа дараах шалгуурыг хангана.	• Контент тасралтгүй 72 цаг ажиллах туршилтыг амжилттай давах • Frame drop ≤5% шаардлагыг бодит орчинд баталгаажуулах • Интерактив хариу үйлдлийн хугацаа ≤120 ms байх • Монгол болон Англи хэл бүрэн ажиллах.

8. Нөөцлөлт ба сэргээх боломж

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
8.1	Нөөцлөлт ба сэргээх боломж.	• Контент болон өгөгдлийг нөөцлөх боломжтой байна • Систем эвдэрсэн тохиолдолд 24 цагийн дотор сэргээх боломжтой байна • Контентын нөөц хуулбар захиалагчид хүлээлгэн өгнө.

9. Техникийн дэмжлэг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
9.1	Техникийн дэмжлэг	• Алсын зайнаас дэмжлэг үзүүлэх хугацаа ≤24 цаг • Шаардлагатай тохиолдолд газар дээр очиж үйлчилгээ үзүүлэх хугацаа ≤72 цаг байна. • Контент засвар, шинэчлэлт хийх боломжтой байна • Жилд дор хаяж 1 удаа системийн үзлэг хийж зөвлөмж өгнө.

II. ҮЗҮҮЛЭГ ТУС БҮРИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА

№	Агуулга	Техникийн үзүүлэлт

1.	Нийтлэг шаардлага	• Контент нь музейн орчинд өдөр бүр тасралтгүй ажиллахад тохирсон үйлдвэрлэлийн түвшний чанартай; • Контентын өнгө, гэрэлтэлт нь тухайн танхимын проектор, дэлгэцийн орчинд тохируулан калибрлагдсан; • Контентын дууны түвшин нь орчны дуу чимээтэй зохицсон; • Контент автоматаар эхлэх (auto-start) боломжтой; • Төхөөрөмж унтарч дахин асах үед контент автоматаар үргэлжлэн ажиллах; • Контентын интерфэйс нь музейн байнгын ашиглалтад тохирсон, алдаа гарсан тохиолдолд reset хийх боломжтой; • Контент болон интерактив систем нь буруу хэрэглээнээс хамгаалсан хамгаалалтын горимтой байна.

Үзүүлэг №1 – Интерактив дижитал газрын зураг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Контентын төрөл	Интерактив газрын зураг
2	Нягтрал	1920×1080 ба түүнээс дээш
3	FPS	30 FPS
4	Мэдрэгчтэй дэлгэц	Multi-touch, 10 цэг
5	Интерактив үйлдэл	Томруулах, багасгах, сонгох

Үзүүлэг №2 – Видео танилцуулга

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Видео үргэлжлэх хугацаа	3–5 минут
2	Нягтрал	4K (3840×2160)
3	FPS	60 FPS
4	Дуу	Stereo / Surround

Үзүүлэг №3 – 3D объектын үзүүлэг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	3D объектын тоо	5 хүртэл
2	Формат	FBX, GLTF
3	Интерактив	Эргүүлэх, томруулах

Үзүүлэг №4 – Хологрант үзүүлэг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Проекцийн төрөл	Hologram display
2	Гэрэлтүүлэг	Танхимын гэрэлд тохирсон

3	Контент	Видео + 3D

Үзүүлэг №5 – Интерактив цаг хугацааны шугам (Timeline)

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Контентын төрөл	Интерактив цаг хугацааны шугам
2	Нягтрал	1920×1080 ба түүнээс дээш
3	FPS	30 FPS-ээс багагүй
4	Интерактив	Скролл, сонголт, буцах
5	Контент	Текст, зураг, богино видео

Үзүүлэг №6 – AR (Нэмэлт бодит байдал) үзүүлэг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	AR технологи	Marker-based эсхүл markerless
2	Төхөөрөмж	Таблет / мэдрэгчтэй дэлгэц
3	FPS	30 FPS-ээс багагүй
4	3D формат	GLTF, FBX
5	Интерактив	Объект харах, эргүүлэх

Үзүүлэг №7 – Хологрaмм үзүүлэг (Advanced)

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Проекцийн төрөл	Hologram fan / pyramid
2	Контент	3D анимейшн + тайлбар
3	Нягтрал	Full HD ба түүнээс дээш
4	Гэрэлтүүлэг	Танхимын орчинд тохируулсан

Үзүүлэг №8 – Видео танхим (Immersive)

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Видео формат	MP4 (H.265)
2	Нягтрал	4K (3840×2160)
3	FPS	60 FPS
4	Дуу	5.1 Surround
5	Үргэлжлэх хугацаа	5–7 минут
6		

Үзүүлэг №9 – Интерактив асуулт–хариулт (Quiz)

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Асуултын төрөл	Сонголттой, мэдрэгчтэй
2	Хариу үйлдэл	Шууд үр дүн харуулах
3	Интерактив	Олон хэрэглэгч

Үзүүлэг №10 – Дижитал мэдээллийн киоск

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Контентын бүтэц	Модульчлагдсан цэс

2	Нягтрал	1920×1080
3	Touch	10 цэг
4	Ашиглалт	Өдөрт 8–10 цаг

Үзүүлэг №11 – 3D реконструкцийн үзүүлэг

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	3D загвар	Өндөр нарийвчлалтай
2	Формат	FBX, GLTF
3	Интерактив	Эргүүлэх, томруулах

Үзүүлэг №12 – Газрын зураг + өгөгдөл (Data-driven map)

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Өгөгдлийн бүтэц	Давхаргатай (layers)
2	Интерактив	Давхарга асаах/унтраах
3	FPS	30 FPS

Үзүүлэг №13 – Дижитал архив

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Контент	Зураг, видео, текст
2	Хайлт	Түлхүүр үг, ангилал
3	Хадгалалт	Дотоод сервер

Үзүүлэг №14 – Аудио түүхчлэл

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Аудио формат	MP3, AAC
2	Сэмпл	48 kHz
3	Хэл	MN/EN

Үзүүлэг №15 – Интерактив хүүхдийн булан

№	Агуулга	Техникийн үзүүлэлт
1	Контент	Тоглоомчилсон интерактив
2	UI	Хүүхдэд ээлтэй
3	FPS	30 FPS

№	Барааны төрөл	Техникийн шаардлага
1	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн аппликейшн, төлөвлөлт хөгжүүлэлт	• Android ба iOS үйлдлийн системүүдтэй ухаалаг гар утас болон таблет төхөөрөмжүүдэд зориулагдан хийгдсэн байх • Бага полигонтой/үзүүлэлттэй төхөөрөмжид гацдаггүй байх • Хамгийн зохистой технологи, аргачлал, бүтэцтэй байх • Программ хангамж, аппликейшний дизайн, концепц/үндсэн чиглэл, удирдах систем /CMS/, өгөгдөлийн баазын бүтэц зохион байгуулалтыг захиалагчын хяналтад гүйцэтгэх • Аппликейшний дүр төрх, концепц/үндсэн чиглэл, хэв маяг нь үзэгчдэд энгийн, ойлгомжтой, ашиглахад хялбар байхаар төлөвлөж, музейд зориулсан загвартай байх • Аппликейшн нь захиалагч байгууллагын үзэл баримтлал, брэндбүүкэнд тулгуурласан загвартай байх • Аппликейшнд нэмэлт өргөтгөл, хөгжүүлэлт хийх боломжтой байх • Хайлт хийх өргөн сонголттой байх • Олон хэл дэмждэг байх

№	Цахим үзмэрийн нэр	Тайлбар
1.	1.1.1 “Их тэсрэлт” богино хэмжээний танилцуулга кино	2-3 минут үргэлжлэх иммерсив дуу дүрсний дундуур нь “алхаж үзэх” аялал нь Их тэсрэлтийн тэлэлтийг танилцуулж, галактик, одод, эцэстээ амьдралын суурийг тавьсан үйл явцыг өгүүлнэ. Хана, таазыг бүрэн ашигласан проекц, хөдөлгөөнт дүрслэл, дуу, гэрлийн шийдлүүдийн нийлбэр нь олон мэдрэхүйд зэрэг нөлөөлөх сэтгэл хөдлөм орчин үүсгэж, үзэгчдэд хүчтэй сэтгэгдэл төрүүлэхүйц байна. Киног орчны дуу чимээ, дуу оруулга, хадмал орчуулгатайгаар гаргана. Үзэгчид монгол, англи хэлний аудиог ээлжилж сонсох боломжтой. *Шаардлагатай тохиолдолд QR кодоор дамжуулан нэмэлт хэлний хувилбарыг авах боломжтой байх.*
2.	1.2.1.1 Интерактив цаглава	Орчлонгийн хуанлийн сар бүр дээр байрлах мэдрэгчтэй дэлгэцээр тухайн сард багтах эрин, үеүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар өгнө. Текст, график, видео зэргийг ашиглан үзэгчид үе тус бүрийн онцлог шинжийг таньж, хооронд нь холбон ойлгоно. Үзэгчид цаг хугацааны урсгалаар урагш, хойш болон "хөндлөн" чиглэлд чөлөөтэй аялж үзэх боломжтой
3.	1.2.2.1 Галактикийн хологрант	Сүүн зам, галактик, гараг, одод бүрэлдэн тогтох үйл явцыг харуулах хологрант проекц нь “орчлонгийн хуанли” үзүүллэгийн төв хэсэгт байрлана.
4.	1.3.2.1 "Эйнштейний $E=mc^2$" богино кино:	Альберт Эйнштейний Харьцангуйн онолын үндсэн санааг тайлбарласан 1-2 минутын богино хэмжээний видео үзүүлнэ. Энэхүү видео нь $E=mc^2$ томьёоны ард байгаа гол ойлголтыг товч, сонирхолтой хэлбэрээр хүргэж, энерги ба материйн харилцан холбоог илүү гүнзгий ойлгоход тусална.

5.	1.3.3.1 Үелэх систем мэдрэгчтэй дэлгэц	Элементүүдийн үелэх систем бүхий мэдрэгчтэй ширээ дэлгэцээр үзэгчид элемент тус бүрийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч, үзэж судлах боломжтой. Ингэснээр мэдрэмж туршлага нь илүү динамик, интерактив болж, үзэгч өөрийн сонирхсон элемент рүү "гүн шумбаж" судлах боломжтой. Дэлгэц дээр дараах мэдээллийг үзүүлнэ: • Тухайн элемент хэдийд нээгдсэн бэ? • Хэн нээсэн бэ? • Атомын бүтэц • Элементүүдийн үүсэл, гарал • Монголын нутаг дэвсгэр дэх тухайн элементүүдийн байгалийн орд, тархалт (жишээлбэл: зэс, алт, молибден, төмөр, цайр, уран гэх мэт) • Эдгээр элементүүд бидний өдөр тутмын амьдралд юунд, хэрхэн ашиглагддаг тухай мэдээлэл
6.	1.4.2.1 Аравтын зэрэг кино	Тодорхой тооны суудал бүхий бэсрэг театрт 9 минутын "Аравтын зэрэг" киног ээлжлэн үзүүлнэ. Үзэгчид киног Монгол, Англи хэлээр ээлжлэн сонсох боломжтой. Англи хэл дээрх дуу болон тайлбарт Монгол хадмал орчуулга дагалдана. Хүсэлт гаргавал QR кодоор дамжуулан нэмэлт хэлний сонголтоор үзэх боломжтой.
7.	1.4.4.2 Өөрийн эрхсээ бүтээх өртөө	Мэдрэгчтэй дэлгэцүүд нь үзэгчид өөрсдөө гараг, сар эсвэл ямар нэгэн эрхсийг нэрлэх, бүтээх, өөрчлөх боломжийг олгох бөгөөд үүнийгээ музей үзсэн дурсгал болгон 3D хэвлэгчээр хэвлүүлж авах эсвэл и-мэйлээр хүлээж авах боломжтой. thisiscolossal.com
8.	1.5.3.3 "Союз-39" станцын хуулбар	Үзэгчид Ж.Гүррагчаагийн ниссэн "Союз" нислэгийн 39-р станцын дотоод орчны хуулбартай танилцана. Энд суух, суудлын бүсээ бүслэх, үзмэрүүдтэй харьцах боломжтой хэсгүүд байна. Анхны тооллого, хөөрөх үеийн чимээ, Удирдлагын төвийн

		(MCC) дуу хоолой зэрэг нь тухайн үеийн уур амьсгалыг бүрдүүлнэ.
9.	2.2 Эртний ландшафт ба Уур амьсгал видео	Монголын эртний ландшафт, экосистем, хуурай газар/далайн түвшин, палео-уур амьсгалыг харуулсан видео танилцуулга нь олон тэрбум жилийн хувьслын явцад Өнөөгийн Монгол орон оршин буй хэсэгт эртний амьдрал ямар байсныг харуулна. Видеог хамааралтай өгүүлэмжээр баяжуулах зорилгоор хадмал тайлбар бүхий дуу хоолой дагалдана. Үзэгчид Монгол, Англи хэлийг ээлжлэн сонсох боломжтой. *Хүсэлт гаргавал нэмэлт хэлийг QR кодоор дамжуулан авах боломжтой.*
10.	2.2.1.1 Эрдсийн интерактив үзмэр	Мэдрэгчтэй дэлгэц нь жонш, зэс, алт, газрын ховор элемент зэрэг тус бүрдээ өвөрмөц физик, химийн шинж чанартай Монголын эрдэс баялгийн талаар мэдээлэл өгнө. Эрдэс тус бүрийн Монголын нийгэм дэх хэрэглээний соёлын түүхийг онцлон харуулна.
11.	2.2.5 Бүх зүйл газраас эхэлдэг- интерактив тоглоом	Хөгжилтэй интерактив тоглоом нь Дэлхийн хишиг болсон эрдсүүдийн бидний өдөр тутмын амьдрал дахь ач холбогдлыг үзэгчдэд таниулна. "Бяцхан алхими" гар утасны тоглоомоос санаа авсан энэхүү тоглоомоор үзэгчид янз бүрийн элемент, эрдэс, чулуулгийг судалж, тэдгээрийг нэгтгэн шинэ биет, материал бүтээсээр эцсийн хэлбэрт хүргэнэ. Тоглогчид түүхий эдээс эхлээд бүтээгдэхүүн хүртэлх янз бүрийн материал, биетүүдтэй таарч, үе шат бүрд баримтуудыг мэдэж авна. Жишээлбэл, тодорхой элементүүд Монголын аль ордоос олддог, аль улс тухайн эрдсийн гол экспортлогч болох, ухаалаг утас бүтээхэд газрын ямар ховор элементүүд чухал болохыг мэдэж авна. Эдгээр зүйлсийн талаарх сонирхолтой баримтуудыг харуулна.
12.	2.3.4.1 Богд хан уулын чулуулаг	Богд хан уулын чулууг урьд нь тэнд байсан эртний далайг санагдуулам усны долгионыг дуурайлган харуулах "гобо" проекц бүхий орон зайд дэлгэн үзүүлнэ. Энэхүү түүхийн бичвэр чулуулгийн үзүүллэгийг дагалдана.

13.	2.4.1 Монголын эрдэнэсийн газрын зураг	Мэдрэгчтэй дэлгэц дагалдсан цуврал проекцууд нь Монголын геологийн янз бүрийн газрын зургуудыг харуулах ба бүс нутаг эсвэл аймаг бүрийн нарийвчилсан мэдээлэл, цаг хугацааны явцад ландшафт хэрхэн хувьссан, 500 сая жилийн тектоник үйл явцаар дэлхийн хэмжээний ордууд хэрхэн үүссэнийг харуулна. Газрын зураг бүрийг бичвэр мэдээлэл дагалдана. Газрын зургийн сонголтод дараах зүйлс багтаж болно: -Монголын байр зүйн зураг Монголын геологийн мужууд Монголын геологийн нэгжүүд Монголын чөлөөт агаарын хүндийн хүчний гажиг Монголын босоо чөлөөт агаарын хүндийн хүчний гажиг Монголын өндөршлийн загвар Монголын налуугийн геоморфометрийн загвар Монголын зүг чигийн геоморфометрийн загвар Монголын сүүдэрлэлтийн геоморфометрийн загвар
14.	3.1.1.1 Дижитал цаг агаарын газрын зураг	Дэлхийн уур амьсгал, агаарын урсгал, усны урсгал, цаг агаарын урсгалууд хоорондоо харилцан уялдаатай байдгийг тайлбарласан нарийвчилсан мэдээлэл бүхий дэлхийн газрын зургуудыг агуулсан мэдрэгчтэй дэлгэц.
15.	4.1.1 Өндөр уулын бүслүүрийн театр	Өндөр уулын бүслүүрийн театр нь өндөр уулын экосистемийг харуулна. Үзэгчид цаг уурын өвөрмөц нөхцөлд амьдарч буй зүйлүүдийн онцлог шинж чанар, тулгарч буй бэрхшээлийг илүү сайн ойлгох болно. Үзэгчид цоохор ирвэс, нөмрөг тас, хималайн хажир болон хад асгат, салхи ихтэй, хатуу ширүүн нутагт дасан зохицсон олон төрлийн ургамал, амьтны зүйлүүдтэй танилцана.
16.	4.1.1.1 Нүх дотор:	Үзэгчид газар доторх нүхийг ойроос харахын тулд "нүх дотор" орж үзэх боломжтой. Тэд энд тарваганы нүхний урт хонгилууд. мөндлүүдийг харна.

17.	4.1.3.1 Шувуу харах дуран	Энд үзэгчид дурангаар олон зүйл шувуудын үүр, ангаахайг олж харах боломжтой. Үзэгч товчлуур дарж, үзэхийг хүссэн үүрнийхээ сонголтыг хийнэ (цармын бүргэд, нөмрөг тас, ооч ёл, хималайн хажир, идлэг шонхор гэх мэт). Дуран доторх жижиг дэлгэцээр богино хэмжээний дүрс бичлэг эсвэл анимаци гарч, тухайн шувууны үүрэн дэх амьдралыг харуулна (өндөг, ангаахай, нөмөрлөх, хооллох үйл явц гэх мэт).
18.	4.1.3.2b Шувуучлахуй	Монгол Улсад бүргэд, шонхор, харцага зэрэг махчин шувуудаар ан хийдэг олон зуун жилийн баялаг уламжлалтай. Цармын бүргэдийг бүргэдийн баяраар алдаршуулж байна. Энэхүү үзүүллэг нь уг уламжлалыг судалж, Монгол дахь шувуучлахуйн практик, цармын бүргэд, шонхорыг агнуурт сонгодог онцлог, барих болон сургах үйл явц, тэдний идэш тэжээл, шувуу ба эзний хоорондох гүнзгий холбоог харуулна.
19.	4.1.4.2 Эмийн ургамал	Уламжлалт анагаах ухаанд эртнээс хэрэглэж ирсэн унаган ургамлууд. Энэхүү үзүүллэг нь ургамал болон түүнтэй холбоотой эмчилгээний аргуудыг таниулна. Гардан үйлдэх интерактив нь үзүүллэг нь үзэгчдэд ургамлын гаралтай эмийг харуулах боломжийг олгоно.
20.	4.1.4.3 Шүтлэгт ургамал	Зарим зүйл унаган ургамлыг ариун дагшин гэж шүтдэг ба эдгээр нь соёлын чухал ач холбогдолтой байдаг. Дээжийн шургуулга/хоргонд ургамлын загвар болон тэдгээрийн экологи, соёлын ач холбогдлын талаарх мэдээллийг үзүүлнэ. Арын дэвсгэр проекц нь эдгээр цэцгийн уран яруу зургийг харуулж, намуухан ая дагалдан
21.	4.2b Тайгын бүслүүр/Ойт хээрийн бүсийн театр	Энэ театр нь үзэгчдэд энэхүү экосистемийн онцлог шинж чанар, түүнчлэн энд амьдрах зүйлүүдийн харилцан хамаарлыг танилцуулна. Үзэгчид ойн амьдралын цикл, бүтэц, бүрэлдэхүүн, мах идэштэн ба идэш тэжээл болох амьтдын харилцаа, мөн газар нутагтай түүх, соёлын хувьд хэрхэн холбоотой байдаг ахмадуудын түүхтэй танилцана.
22.	4.2.1 Уулын тайгын диорам	Тайгын бүрэлдэхүүнд багтах амьтан, ургамлын төлөөлөл, цаатан, цаа буга сүлэлдсэн экологи, соёлын өвөрмөц нарийн

		нийлмэл бүтцийг үүсгэнэ. Тэнгэр баганадсан шинэс мод, хөвсгөр зөөлөн хөвд, хүрэн баавгай, шилүүс, отогтоо ойр бэлчих цаа буга цөм харилцан уялдаатай. Ахмадуудын хууч ярианаас хүн, амьтан, ой тайгын мөнхийн түншлэл, тэдгээрийн экологи, соёлын тэсвэр хатуужлыг мэдэрнэ.
23.	4.2.2.2 Тайгын бүслүүр дахь Цаа буга Интерактив аялал	Үзэгчид дэлгэцийг ашиглан цаа буга тайгад хэрхэн дасан зохицож, хүрээлэн буй орчноо хэрхэн хэлбэржүүлж буйг судлах аялалд гарна.
24.	4.2.2.3. Цаа буга тайгад - интерактив аялал	Үзэгчид дэлгэцийг ашиглан цаа буга тайгад хэрхэн дасан зохицож, хүрээлэн буй орчноо хэрхэн хэлбэржүүлж буйг судлах аялалд гарна. 55*
25.	4.2.3.1а Шилүүс:	Ой, өвсөн дундаас олз руугаа довтлоход бэлэн гэтэн яваа шилүүсийг дүрслэн харуулна. Интерактив самбар нь үзэгчдэд Евроазийн шилүүс болон Сибирийн шилүүсний тухай дараах сонирхолтой баримтуудыг судлах боломжийг олгоно. Үүнд:
26.	4.2.3.2б Хүрэн баавгай:	Хүрэн баавгайг диорамын хэсэгт байрлуулах бөгөөд интерактив самбараар дамжуулан уг амьтны тухай сонирхолтой баримтуудыг танилцуулна. Үүнд: Гадаад төрх Идэш тэжээл ба зан төрх Тоо толгой ба хамгааллын тулгамдсан асуудлууд
27.	4.2.1 Үр ба урсгал – Шинэсний шүтэлцээ:	Тайгаас эх авсан цэнгэг уст том голууд нь тул, зэвэг, хадран зэрэг загас, бусад олон зүйлийн амьдралыг тэтгэдэг. Энэхүү ой, усны амин чухал шүтэлцээ нь тус биомын нарийн нийлмэл тогтолцооны цөм юм. Дижитал проекц бүхий шал нь үзэгчдэд энэхүү амин чухал, тахиралдаж урссан ойн горхи дундуур алхах боломжийг олгоно.
28.	4.3.1.1 Хөрсөн доорх сүлжээ:	Үзэгчид энэхүү шалны доорх үзүүллэгээс хээрийн хөрсөн дэх мөөг, мицелийн сүлжээг судлахын тулд ажиглах боломжтой.

29.	4.4.1 Хээрийн диорам	Энэхүү диорамын гол "гайхамшиг" нь өндөр өвсөн дунд болон үзүүллэгийн бусад хэсэгт тархан байрласан бусад амьтадтай хамт харагдах цагаан зээр юм. Интерактив унших самбар нь үзэгчдэд онцолсон амьтдын хооллолт, зан төрх, үржил, мөн аюул занал, хамгааллын талаар илүү ихийг олж мэдэх боломжийг олгоно.
30.	4.4b Хээрээс Цөл рүү театр	Энэхүү театрт үзэгчид зах хязгааргүй үргэлжлэх хээр талын уудам орон зай, нүүдэлчдийн ахуй амьдралыг мэдрэх болно. Мөн хээр болон цөлийн бүсийн хоорондын харилцан хамаарал, эдгээр бүсэд амьдардаг ургамал, амьтад тухайн орчиндоо хэрхэн дасан зохицож амьдардаг тухай ойлголттой болно.
31.	4.4.2.1 Цэн тогорууны үржил, үүрээ засах нь	Цэн тогоруу нь хосоороо бүжиглэх зан үйл, Монголын тал хээр, намгархаг газарт үржилд ордог гэдгээрээ алдартай. Үзэгчид хоёр ширхэг өндөгтэй үүрээ манаж буй цэн тогорууны бүрэн хэмжээний диорамыг үзнэ. Ард нь том дэлгэцээр тогорууны бүжиг, үржлийн зан үйлийг харуулсан богино хэмжээний видеог үзүүлнэ. Проектор, чиглүүлэгч чанга яригч нь үзэгчдэд хосоороо дуудах чимээг мэдрүүлнэ.
32.	4.4.3.1.3b Хээр талын үл үзэгдэх инженерүүд - Тарвага хөдөлгөөнд	Энэхүү график самбар нь тарвага хэрхэн хээрийн бүтэц бүрэлдэхэд нөлөөлж, хөрсийг сийрэгжүүлэн, махчин амьтдын идэш тэжээл болж, экологийн болон өгүүлэмжийн агуулгыг баяжуулж буйг таниулна.
33.	4.5.1 Цөлөрхөг хээрийн диорам	Хайрга чулуурхаг хөндий, тачир ургамалжил, гандуу, эрс тэс цаг агаартай, ус ховор зэрэг хатуу ширүүн нөхцөлд зэрлэг амьтад хэрхэн дасан зохицож, амьд үлддэг гайхамшгийг харуулна. Монголын цөлөрхөг хээрт ургамал, амьтан бүр байгалийн шалгарлыг давах өргөн чадвартай. Энд усны дусал алтнаас үнэтэй бөгөөд хааяахан таарах задгай усан сангууд нь амьдралыг тэтгэнэ.
34.	4.5.4.1 Баянбүрдийн дижитал иммерсив	Танхимын төв хэсэгт цөлийн дундах "Амьдрал тэтгэх арал" болон цэцэглэн буй ногоон баянбүрдийг проектороор дүрслэн харуулна.

35.	4.6.1.1 Цөлийн орчин - туршлага	Барзгар хад чулуу, элсэн манхан, салхинд элэгдсэн, ангамал хуурай нутаг нь цөл болон баянбүрдийн амьдралыг харуулсан үзүүллэгийг дэглэнэ. Үзэгчид хад чулуу, элсэн манхан дээр тусгасан янз бүрийн түүхүүдтэй танилцах зуур цөлийн салхины исгэрэх чимээ эгшиглэнэ. Түүх, өгүүлэмжүүдийг зохиомлоор бүрдүүлсэн байгалийн орчин дээр шууд проектороор тусган харуулна.
36.	4.6.1.1 Бидэнтэй ярилцаарай	Энэхүү үзүүллэгт үзэгчид хиймэл оюун ухаан (AI) ашиглан хэд хэдэн дээжийн хажууд байрлах QR кодыг гар утсаараа уншуулан тэдэнтэй ярилцах боломжтой. Тэд хүссэн асуултаа асууж болно.
37.	4.7.3.1 Тив дамнасан уялдаа холбоо Олон тоглогчтой интерактив	Энэхүү олон тоглогчтой интерактив тоглоом нь Монгол орны биомууд нь ан амьтдын нүүдэл шилжилт, шим тэжээлийн эргэлт, уур амьсгалын нөлөөлөл болон хүний үйл ажиллагаа зэрэг олон механизмаар дамжуулан хэрхэн харилцан шүтэлцдэг тухай таниулна. Өсвөр насны үзэгчид хамтран ажиллаж, ялгаатай биомуудын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, сайжруулах даалгавар гүйцэтгэх бөгөөд тэдний гаргасан шийдвэрийн үр нөлөө нь 3 хэмжээст макет дээр бодит хугацаанд дүрслэгдэн харагдана. Гэрэл, дуу чимээ, үнэр болон чичиргээ зэрэг мэдрэхүйн эффектүүдийг ашиглан биомын загваруудтай харилцан үйлдэл хийх нь уг тоглоомыг танхим дахь бусад үзмэрүүдтэй уялдуулж, өөр өөр диорамуудын хооронд гүнзгий уялдаа холбоог бий болгоно.
38.	5.1.1 Дэлхийн үүсэл (Хадеан эон) оршил	Манай гарагийг бүрдүүлсэн шинжлэх ухааны гол үйл явцуудыг танилцуулна. Чихэвч эсвэл чиглүүлсэн чанга яригч нь үзэгчдэд киноны тайлбар өгүүлэмжийг сонсох боломжийг олгоно. Үзэгчид өөрийн хүссэн хэлээр (Монгол/Англи) сонгож сонсох боломжтой. *Нэмэлт хэлийг QR кодоор дамжуулан авч болно.*
39.	5.1.1 с	Дэлхийн агаар мандлын хувьслын тасралтгүй мөчлөгийг дуурайлган харуулах манан бүхий том хэмжээний тунгалаг хорго. Энд LED гэрэлтүүлгийн тусламжтайгаар гүн улаан өнгөнөөс (хүчилтөрөгчгүй эртний агаар мандал) хөх-ногоон өнгө рүү (хүчилтөрөгчөөр

		баялаг орчин үеийн агаар мандал) шилжих үзэгдлийг давтамжтайгаар харуулна
40.	5.1.1 Хүчилтөрөгчийн хувьсгал (Протерозойн эон):	Энэхүү үзүүллэг нь дэлхий дээрх амьдрал үүсэх эхлэлийг тавьсан химийн хувьслыг харуулна. Тайлбар самбарт хүчилтөрөгч бий болсон үйл явц болон бүх амьд биетийн эхлэл болсон анхны эсүүд хэрхэн үүссэн тухай өгүүлнэ.
41.	5.1.2.v соронзон молекул	Химийн идэвхжил болон эртний амьдралын бүтцийг харуулах соронзон молекул эвлүүлдэг тоглоом байна.
42.	5.1.4.2	Дижитал дэлгэцүүд нь үзмэрийн агуулгыг баяжуулж, бичил малтмалын мэдээллийн сантай танилцах, дүрсийг томруулан харах, эртний амьдралын гол баримт, онцлогуудыг судлах боломжийг олгоно.
43.	5.1.5 Хувьслын их тэсрэлт (Кембрийн галав) оршил	Кембрийн эриний далайн ёроолын диорам: Далайн усны урсгал болон тухайн үеийн гол төрөл зүйлүүдийн хөдөлгөөнт дүрслэл (проекц)-ийг биет макетуудтай хослуулсан нь энэхүү мэдрэмжийг улам гайхамшигтай, бодит мэт болгоно. Эдгээрийн дунд дотор гэрэлтүүлэгтэй шилэн хоргонд трилобит болон хөвөн биетний эх үзмэрүүдийг дэлгэн байршуулна.
44.	5.1.6.2 Амьдрал хэрхэн бий болсныг илэрхийлэх мэдрэгчтэй дэлгэц	: тайлбар самбар нь үзэгчдэд интерактив хэсгүүдийг сонирхох сэдлийг өгөх бөгөөд тус бүр нь гурван геологийн эриний гол шинж чанарыг нарийвчлан харуулна. Мэдрэгчтэй дэлгэц бүр хос хэлний агуулгатай байх ба цаг хугацааны шилжилтийг томруулж, жижгэрүүлж харах, олдвор болон амьдралын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжийг олгож, үзэгчдэд Геологийн цаг хугацааны асар том хэмжээсийг ойлгоход тусална.
45.	5.2.1.2. Хуурай газарт дасан зохицох дадлагын хэсэг:	Усан доорх экосистемээс хуурай газар руу шилжиж буй үеийг харуулсан бүрэн, нарийвчилсан диорам үзүүллэг. Проектороор гаргах анимациуд нь усны түвшин аажмаар буурах явцад амьтад хэрхэн дасан зохицож буйг харуулна. Эх үзмэрүүдийг диорам доторх хоргонд байрлуулна

46.	5.2.1.3. Малтлагын талбай:	Булсан олдворын хуулбарууд болон палеонтологийн багаж хэрэгсэл бүхий энэхүү зохиомол малтлагын талбайд үзэгчид хурдас чулуулгаас олдворын хуулбарыг малтан гаргах боломжтой. Тэд олсон олдвороо бүртгэлийн цэг дээр баримтжуулж, бодит дээжтэй харьцуулан судлах болно.
47.	5.2.3.2 *Minjinia turgenensis* *бид хоёр*	Энэхүү медиа өртөө нь 415 сая орчим жилийн өмнө амьдарч байсан, хуягт загасыг үзэгчдэд танилцуулна. Зурагт тайлбар болон проекторын дүрслэлийг хослуулан, энэхүү эртний загасны (плакодерм) энгийн бүтэцтэй
48.	5.2.4.1 Махчин амьтдын хувьслын театр	Хагас дугуй хэлбэртэй энэхүү талбайд Лабиринтодонт, Диметродон болон эртний загас зэрэг махчин амьтдын бодит хэмжээтэй макетуудыг дэлгэн үзүүлнэ. Гэрэл, дуу чимээний автоматчилсан үзүүлбэр нь махчин ба идэш тэжээл бологч амьтдын учралыг харуулах бөгөөд хувьслын дасан зохицох чадварыг тайлбарласан өгүүлэмжтэй хослох болно. Орон зайн дууны эффект болон орчны гэрэлтүүлэг нь үзэгчдийг эртний усан доорх болон намаг балчигт орчинд очсон мэт бүрэн автуулна.
49.	5.2.1.1. Интерактив макетууд	Театрын хүрээ дагуу байрлах, гар хүрч болох макетууд нь хазах, сорж хооллох, отох, тастах зэрэг ангуучлах янз бүрийн стратегиудыг үзүүлнэ. Үзэгчид хазалтын хүч, шүдний зуулт болон эрүүний хөшүүргийн үйлчлэлийг туршиж, төрөл зүйлүүдийн хоорондох ялгааг харьцуулан судална. Бусад хэсэгт үзэгчид махчин амьтны нүдээр харж, чихээр нь сонсож үзэх боломжтой.
50.	5.2.5.1	Эртний ойн аялал: Үзэгчид тэнгэр баганадсан лепидодендрон моддын их бие, ойм, шивлээгээр дүүрэн Карбоны галавын ойн бодит хэмжээтэй диорам дундуур алхана. Газрын хөрс болон модны үндэс хэсэгт бодит малтмал эх олдворуудыг шигтгэн байршуулсан нь эртний ургамал цаг хугацааны явцад хэрхэн чулуужин үлдсэнийг харуулна. Орчны намуухан чимээ болон гэрэлтүүлэг нь Эрт төрмөлийн эриний намгийн өтгөн шигүү, чийглэг бүгчим орчныг санагдуулна

51.	5.2.5.2a	Уур амьсгал ба нүүрстөрөгчийн мөчлөгийн өртөө: Интерактив мэдрэгчтэй дэлгэц болон агаарын урсгалын макетууд нь Карбоны галавын ой мод агаар мандал дахь хүчилтөрөгчийг хэрхэн нэмэгдүүлж, нүүрстөрөгчийг нөөцөлж байсныг харуулна. Үзэгчид ойн нягтаршлыг өөрчлөх замаар дэлхийн температур болон нүүрсхүчлийн хийн түвшинд хэрхэн нөлөөлж буйг симуляциар харна. Энэхүү үзмэр нь ургамлын хувьсал дэлхийн агаар мандлын өөрчлөлттэй хэрхэн холбогдож буйг үзүүлнэ.
52.	5.2.5.2b Нүүрс үүсэх үйл явцын үзүүлэн	Механик болон дижитал дэлгэц нь өмхөрсөн ургамлын үлдэгдэл хэрхэн нүүрс болон хувирдгийг харуулна. Үзэгчид хүлэрт намгаас хүрэн нүүрс, цаашлаад чулуун нүүрс (битумт нүүрс) болон хувирах үйл явцыг ажиглаж, эртний үйл явц орчин үеийн эрчим хүчний эх үүсвэртэй хэрхэн холбогдож буйг ойлгоно. Танин мэдэхүйн самбарууд нь эрчим хүчний хэрэглээ болон тогтвортой байдлын талаар эргэцүүлэхэд уриална.
53.	5.2.5.2c Уур амьсгалын интерактив цаглавар:	Хана дагуу үргэлжлэх цаглавар нь Карбоны галаваас өнөөг хүртэлх агаар мандлын өөрчлөлтийг уур амьсгалын өгөгдөл болон олдворын нотолгоотой нэгтгэн харуулна.
54.	5.2.6.1 Сибирийн траппын гамшгийн бүс	Том хэмжээний галт уулын макет эсвэл зурагт самбар нь орон зайг дүүргэх бөгөөд гэрэл, дуу чимээ, аюулгүй утааны эффекттэй хосолсон дэлбэрэлтийн симуляцийг үзүүлнэ.
55.	5.2.1.1 Пермийн ертөнцийн танхим:	Үзэгчид Пермийн галавын сүүл үеийн намгархаг ойгоос хуурай тал хүртэлх амьдрах орчныг харуулсан, хоорондоо харилцан холбоотой, бодит хэмжээтэй олон тооны диорам руу орно. Хөдөлгөөн мэдрэгчтэй амьтдын макетууд эсвэл проекц нь бодит хөдөлгөөн, дуу чимээгээр хариу үйлдэл үзүүлж, махчин ба идэш тэжээл бологчдын харилцаа, амьд үлдэх зан үйлийг харуулна. Хадны гадаргуу болон газрын давхаргад эх олдворуудыг шигтгэж өгсөн нь сэргээн засварласан амьдралыг шинжлэх ухааны бодит нотолгоотой холбож өгнө.
56.	5.2.7 Мөхлийн өмнөх амьдрал:	Тайлбар самбар нь Пермийн галавын сүүл үеийн биологийн олон янз байдал цэцэглэн хөгжсөн, аварга том махчин амьтад ноёрхсон, уур амьсгал улам тогтворгүй болж

		байсан динамик боловч эмзэг ертөнцийг танилцуулна. Энэ хэсэг нь дэлхийн хамгийн аймшигт сүйрлийн өмнөх амьдралын оргил үе рүү үзэгчдийг татан оруулах бөгөөд олдвор, макет, интерактив симуляциар дамжуулан мөхлийн ирмэгт ирсэн экосистемийн талаар мэдээлнэ.
57.	5.2.8.1 Мөхлийн үйл явцын төв	Том хэмжээний интерактив хана нь үзэгчдэд мөхлийн дүр зургийг судалж, экосистемийн сүйрлийг ажиглах боломжийг олгоно. Динамик проекц болон гэрэлтүүлэг нь агаар мандлын өөрчлөлт, галт уулын дэлбэрэлт, далай тэнгисийн хүчилжил болон олноороо үхэж буй үйл явцыг дүрсэлнэ. Температур эсвэл нүүрсхүчлийн хийн түвшин зэрэг хувьсагчдыг өөрчлөхөд экосистем бодит хугацаанд сүйрч, байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахын хор уршгийг гинжин нөлөөллөөр (домино эффект) харуулна.
58.	5.2.9.2а Төрөл зүйлээ бүтээх нь	Олдворын хэв болон 3D сэргээн босгосон үзүүллэг нь их мөхлийг даван туулж чадсан "амьд үлдэгсэд" болох хоёр нутагтан, эртний мөлхөгчид, загас, ургамлын удам угсааг танилцуулна. Түүх бүрийг эх олдворын нотолгоо болон 3D сэргээн амилуулалтыг ашиглан харуулах бөгөөд төрөл зүйлүүд мөхлийн дараах хатуу ширүүн орчинд хэрхэн дасан зохицсоныг мөшгөн харуулна.
59.	5.2.10.1 Монголын нислэгийн нээлтийн төв	Үзэгчид нислэгийн хувьслын үе шатуудыг харуулсан өдний загваруудыг туршиж үзэх боломжтой. Төв хэсгийн тайлбарт олдворын хуулбар, шинжлэх ухааны симуляци, интерактив туршилтуудыг хослуулсан байна. Үзэгчид олдвор болон палеонтологийн нээлтүүдээр дамжуулан нислэгийн хувьслын түүхийг судална. Үзүүллэгийн эргэн тойронд байрлах мэдрэгчтэй дэлгэцүүд нь Монголын холбогдох гол олдворт газрууд болон нээлтүүдийг онцлон харуулна.
60.	5.2.10.2 "Тулалдаж буй үлэг гүрвэлүүд" олдворын үзмэр	: Энэхүү хэсгийн гол үзмэр нь Монголын дэлхийд алдартай "Тулалдаж буй үлэг гүрвэлүүд" буюу протоцератопстой үхлийн тулаан хийж буй велоцирапторыг бодит хэмжээгээр нь дэлгэн үзүүлэх явдал юм. Хөдөлгөөн мэдрэгчтэй, эх үзмэрт аюулгүй, сэтгэл хөдөлгөм гэрэлтүүлэг нь хэлхээ ясны нарийн деталь болон тухайн агшны зан төрхийг гайхалтайгаар хадгалан үлдсэн

		байдалд анхаарлыг хандуулна. Зэргэлдээх самбарууд нь энэхүү олдвор нь идэш тэжээлээ агнах үйл явц, экосистемийн динамик болон хурдан хугацаанд булагдсан нөхцөл байдлын талаар юу өгүүлж буйг тайлбарлана.
61.	5.2.10.3	Үүр ба үр төлөө халамжлах нь: Зэргэлдээх олдвор болон макет үзмэрүүд нь протоцератопс болон бусад үлэг гүрвэлийн өндөгний үүрийг харуулах бөгөөд өндгөө дарах, үүрний бүл үүсгэх, үр зулзагаа асран хамгаалах зан үйлийн нотолгоог онцлон харуулна. Үзэгчид томруулдаг дурантай өртөөг ашиглан өндөгний хальсны бүтцийг харж, эдгээр олдворууд орчин үеийн шувуудтай хувьслын хувьд хэрхэн холбогдож буйг хэлэлцэх боломжтой.
62.	5.3.0	Хөх тээгийн цаг үе (Түрүү Цэрд) - Танилцуулга ба олдворын үзмэр: Тайлбар самбар нь Хөх тээгийн цаг үе буюу Цэрдийн галавын түрүү үеийн талаар тайлбарлана. Цэрдийн галавын түрүү үеийн үлэг гүрвэлийн олдворт газруудаас түгээмэл олддог үлэг гүрвэлийн олдворуудыг дэлгэн үзүүлнэ. Үзэгчид тухайн үеийн эртний орчин нь үржил шимтэй, чийглэг, дулаан уур амьсгалтай байсныг болон пситтакозавр, игуанодонт, харпимимус зэрэг олон үлэг гүрвэлүүд, мөн хампсозавр, усны яст мэлхий зэрэг усны мөлхөгчид амьдарч байсныг мэдэж авна.
63.	5.3.1 Баянширээгийн цаг үеийн баянбүрд (Дунд төрмөл):	Баянширээгийн цаг үе нь Монголын палеоэкологийн хувьд хамгийн баялаг, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой олдворт газруудын нэг юм. Цэрдийн галавын хожуу үед хамаарах энэхүү хурдас нь үлэг гүрвэл, мөлхөгчид, ургамал, сээр нуруугүйтэн амьтдаар дүүрэн ус намгархаг орчныг хадгалан үлдсэн бөгөөд дэлхий нийтийг хамарсан өөрчлөлтийн үеүүдийн хооронд амьдрал хэрхэн цэцэглэн хөгжиж байсны тод дүр зургийг харуулдаг.
64.	5.3.1.0 Цэрдийн үеийн амьдралын орчинтой танилцах булан:	Арын ханан дахь бодит хэмжээтэй байгалийн зураг нь тухайн орчин болох өтгөн ургамал, гүехэн урсгалтай горхи, олон янзын амьтдыг дүрсэлнэ. Хад чулуу, хөрсний дунд шигтгэсэн эх болон хуулбар олдворуудыг цонхоор

		харах боломжтой бөгөөд хуваарийн дагуу олдвор цэвэрлэх, бэлтгэх үйл явцыг үзүүлнэ.
65.	5.3.2 Нэмэгтийн хөндийн аваргууд:	Энэхүү үзмэр нь аварга том хэлхээ яснуудыг бодит хэмжээгээр нь, бүтээлч гэрэлтүүлэгтэйгээр харах боломжтой, өндөрлөсөн тавцан бүхий шийдэлтэй байна. Диорам бүр нь тухайн үеийн байгаль орчин болон нэг экосистемд зэрэгцэн оршиж байсан бусад амьтдыг дүрсэлсэн арын ханын зурагтай байна.
66.	5.3.2.1	Тарбозавр батаар (Тираннозаврид) 100-66 сая жилийн өмнө. Хэлхээ ясыг диорамд байрлуулна.
67.	5.3.2.2	Завролоф (Хадрозавр) 72-66 сая жилийн өмнө. Хэлхээ ясыг диорамд байрлуулна.
68.	5.3.2.3	Бактрозавр (Хадрозавр) 100-70 сая жилийн өмнө. Хэлхээ ясыг диорамд байрлуулна.
69.	5.3.2.4	*Deinocheirus mirificus* 70-66 сая жилийн өмнө. Хэлхээ ясыг диорамд байрлуулна
70.	5.3.2.5 Үлэг гүрвэлийн хөдөлгөөн буюу биомеханиктай танилцах үзүүлэн	. Хамгийн том үлэг гүрвэлүүд дэлхий дээрх бусад бүх амьтдаас хүнд жинтэй байсан ч, тэд хэрхэн алхаж, хөдөлдөг байсан бэ? Энэхүү үзмэрээс үзэгчид эрдэмтэд эдгээр аваргуудын хөдөлгөөнийг сэргээн босгохын тулд олдворыг хэрхэн судалж, өнөөгийн амьтдын хөдөлгөөнийг ажиглан, булчингийн бүтцийг нь хэрхэн шинжилдэг болохыг мэдэж авна.
71.	5.3.3.1 Говь цөлийн туршлагын танхим	Тайлбар самбар нь энэхүү хурдас нь хагас хуурай, улирлын чанартай чийглэг уур амьсгалтай байсныг болон үлэг гүрвэлийн өндөг, мөн протоцератопс, пинакозавр, велоцираптор зэрэг жижиг биетэй чухал үлэг гүрвэлүүдийн олдворууд эндээс олддогоороо алдартай болохыг үзэгчдэд таниулна. Энэ хурдаснаас олдсон үлэг гүрвэлийн олдворууд харьцангуй жижиг, тархай бутархай байдаг нь эртний орчин амьдрахад тийм ч таатай байгаагүйг илтгэнэ.

72.	5.3.3.1а Жодохтын давхаргадас	Тайлбар самбар нь энэхүү хурдас нь хагас хуурай, улирлын чанартай чийглэг уур амьсгалтай байсныг болон үлэг гүрвэлийн өндөг, мөн протоцератопс, пинакозавр, велоцираптор зэрэг жижиг биетэй чухал үлэг гүрвэлүүдийн олдворууд эндээс олддогоороо алдартай болохыг үзэгчдэд таниулна. Энэ хурдаснаас олдсон үлэг гүрвэлийн олдворууд харьцангуй жижиг, тархай бутархай байдаг нь эртний орчин амьдрахад тийм ч таатай байгаагүйг илтгэнэ.
73.	5.3.3.3 AR киоск	Үзүүллэгийн орон зайд хэд хэдэн дэлгэц бүхий киоскууд байрлана. Хувь хүн эсвэл жижиг бүлэгт зориулагдсан эдгээр киоск доторх дэлгэц нь урд нь байгаа олдворын хэв болон ханан дээрх зургийг харуулна. Үзэгч товчлуур дармагц хэлхээ яс булчингаар хучигдаж, дараа нь арьстай болж, диорам амилан амьтад ан хийх, үүрлэх, хооллох, хөдөлж, бүр хоорондоо тулалдаж буйгаар харагдана. Эдгээрийг бусад үзмэрийн хэсгүүд тод харагдахуйц төв байршилд байрлуулна. Үзэгчид дуранг идэвхжүүлэхэд үлэг гүрвэлүүд бүгд амилахыг харж байна гэж төсөөлөхөд хүргэнэ.
74.	5.3.4.1 Цэрд-Палеогений зааг гэж юу вэ?	Анимаци видео нь аварга солир дэлхийг мөргөж, уур амьсгалыг үүрд өөрчлөн, үлэг гүрвэл болон бусад олон төрлийн ургамал, амьтдыг мөхөлд хүргэсэн гэх онолыг танилцуулна. Үзэгчид үл мэдэг чичиргээг мэдэрч, гүн нүргэлэх цохилтын долгионыг сонсож, экосистем мөхөхөд гэрэл, дуу чимээ бүдгэрэн харанхуйлахыг харна. Энэ үйл явц сүйрлээр төгсөхгүй, харин шувуудын бүдэгхэн жиргээ, оймын соёололтоор буюу шинэчлэлийн чимээгүй дохиогоор өндөрлөнө. Видео нь энэ үед юу болсон, их мөхөл хэрхэн явагдсан байж болох талаарх өөр бусад сонирхолтой (гэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй) онолуудыг санал болгоно.
75.	5.4.1.2 Мөхлийн дараах байгалийн диорам:	Шинэ төрмөлийн эриний эхэн үеийн нөхөн сэргэж буй байгаль орчныг харуулсан бодит хэмжээтэй диорам. Үзэгчид том хөхтөн амьтдын (*Indricotherium*, эртний хирс, жижиг

		заан хэлбэртэн) макетууд болон шигтгэсэн эх олдворуудтай танилцана. Салхи, амьтдын дуудлага, ургамлын чимээ зэрэг үелсэн дууны дизайн нь сүйрлийн дараа дахин сэргэж буй амьд байгалийг илтгэнэ.
76.	5.4.1.3 Хөхтөн амьтан бүтээх өртөө	Үзэгчид соронзтой их биеийн хэсгүүдийг (толгой, мөч, сүүл, гавал) ашиглан өөр өөр орчинд (ой, хээр, тундр, цөл) дасан зохицсон хөхтөн амьтдыг "зохион бүтээнэ". Самбарууд нь туурайтай болон зөөлөн тавхайтай хөл, урт болон богино мөч, өвсөн тэжээлтний болон махчин амьтны шүд зэрэг шинж чанаруудыг тайлбарлан сонголт хийхэд чиглүүлнэ. Бэлэн болсон макетууд нь "Хөхтөн амьтан байх олон арга зам" гэсэн хаягтай дундын самбарт соронзоор наалдана. Эсвэл үүнийг жижиг ширээнүүд дээр хийж болох бөгөөд үзэгчид цаасан дээр өгөгдсөн орчинд (уул, гол, хээр, туйл) тохирох хөхтөн амьтныг бүтээнэ. Зурагтай картуудыг ашиглан өөр өөр хэсгүүдийг сонгон будаж, тэмдэглэгээ хийн, мөчдийн төрөл, үс, идэш тэжээл, мэдрэхүйн эрхтэн зэрэг дасан зохицох чадваруудыг сонгоно. Дууссаны дараа бүтээлээ сканнердахад ханан дээрх проекц дээр амьтан нь амилж, хооллож, ан хийж, нисэж буйгаар харагдана.
77.	5.4.1.5 дижитал ургийн мод бүтээгч	Хананд суурилуулсан мэдрэгчтэй дэлгэц эсвэл механик эргэдэг самбар нь хөхтөн амьтдын бүлгүүд нэг өвөг дээдсээс хэрхэн салбарлаж хөгжсөнийг харуулна. Үзэгчид төрөл зүйлийн картуудыг нэмэх эсвэл хасах замаар удам угсаа хэрхэн төрөлжиж, дэлхий даяар тархсаныг нүдээр харна. Энгийн зааврууд нь *Indricotherium* зэрэг устаж үгүй болсон төрөл зүйлүүдийг орчин үеийн төрөл садантай нь холбож өгнө.
78.	5.4.3.1 Мөстлөгийн үеийн иммерсив туршлага	Хаалттай танхим нь гэрэл, дуу чимээ, температурын нарийн тохируулга ашиглан Мөстлөгийн үеийн уур амьсгалыг бүрдүүлнэ. Цайвар цэнхэр гэрэлтүүлэг болон нам дууны эффект нь цэвдэгт газар нутгийг санагдуулна. Салхины исгэрээ болон амьтдын дуудлага сонсогдоно.

79.	5.4.3.2а Мөстлөгийн үеийн угсармал олдворын үзмэр:	Танхимаас үргэлжлэх задгай хэсэгт сэрүүн туяатай гэрэлтүүлэг дор угсарсан олдворууд болон хэлхээ ясны хэсгүүдийг дэлгэн үзүүлнэ.
80.	5.5.1.1 Судалгааны лаборатори	Энэхүү орон зайн төвд том шилэн цонхоор харагдах бодит ажиллаж буй палеонтологийн лаборатори байрлана. Музейн эрдэмтэд, техникийн ажилтнууд олдвор бэлтгэж, мэдээлэл бүртгэж, одоогийн судалгааг хэлэлцэнэ. Үзэгчид шууд ажлыг эсвэл хуваарьт үзүүлэн таниулгыг нийтийн зарлан мэдээлэх систем (PA system) эсвэл видео дэлгэцээр дамжуулан үзэж болно. Дээрээс харсан камер, дэлгэцүүд нь олдвор бэлтгэх нарийн ажлыг ойроос харах боломжийг олгон.
81.	5.5.4.1 Олон улсын хамтын ажиллагааны газрын зураг	• Малтлагын талбай болон буцаан авчирсан газруудыг заах гэрэл бүхий интерактив газрын зураг
82.	5.5.6.1 Тэргүүлэх шинжлэх ухааны төв:	Өмнөх танхимуудын газар шорооны өнгө аястай харьцуулахад тод, орчин үеийн шийдэлтэй тайлбарт бүс. Дизайн нь цэвэр шугам, гэрэлтдэг самбар, өгөгдөл, эс, эртний организмын дижитал дүрслэл зэргээр инновацыг илтгэнэ. Энэ орон зайг Музей хөтөлбөр зохион байгуулахад ашиглаж болно. Үзмэрүүд нь эрдэмтэд олдвороос бичил болон молекулын түвшинд мэдээлэл гаргаж авах, дүн шинжилгээ хийх, тайлбарлахад шинэ технологийг хэрхэн ашиглаж буйг онцлон харуулна. Монголын болон олон улсын судалгааны бодит жишээнүүд зөвхөн дууссан үр дүнг бус, хийгдэж буй нээлтүүдийг харуулна.
83.	6.0.2 Хүн төрөлхтний орон гэрээ хайсан эрэл	Үзэгчид Африк, Евроази, Төв Азиас Монгол руу чиглэсэн эртний хүмүүсийн нүүдлийн маршрутыг жижгэрүүлсэн хувилбараар алхаж туулна. Энд хүн төрөлхтөн бүгд нүүдлийн түүхээрээ холбогддогийг онцолно. Үзэгчид нүүдлийн гол зам дагуух өөр өөр газар нутгийг туулах үед мэдрэгчтэй дуу чимээ, шал болон ханан дээрх дүрслэлүүд хариу үйлдэл үзүүлнэ.

84.	6.0.2.2 Орчны дуу хоолойт өгүүлэмж	Монголын байгалийг харуулсан зурагт самбараас гарах богино боловч сэтгэл хөдөлгөм дуу хоолой (давталттайгаар) үзэгчдийг угтан авч, тэдний аялал цаг хугацаа, орон зайг туулан ирснийг мэдээлнэ. Энэ нь "Та бүгд энэ дэлхий дээр амьдарсан анхны хүн биш..." гэдгийг хэлж, дараагийн хэсгийг танилцуулна.
85.	6.1.1.2 Эрдэмтдийн булан	Ханын зургийн зэргэлдээ түүхийн туршид болон хүн төрөлхтний эцэс төгсгөлгүй түүхийг судлахад Монгол Улсын гүйцэтгэсэн үүргийн талаар илүү ихийг олж мэдэх боломжтой байна. Салаа мөчир болгон дээрх цаг үеүдийг тэдгээрийг судалж буй орчин үеийн шинжлэх ухааны түүхүүдтэй шугамаар холбож харуулах бөгөөд үүнд дараах зүйлс багтана: • Хажуугийн самбарууд нь Монгол эрдэмтдийн түүх, гэрэл зургуудыг дэлгэн харуулна; • Сөхөж үзэх боломжтой самбарууд болон хананд шигтгэсэн үзмэрийн хоргонууд нь хээрийн тэмдэглэлийн хуулбар, судалгааны болон хээрийн багаж хэрэгсэл, малтлагын талбай, лабораторийн туршилт зэрэг жижгэрүүлсэн дүрслэлээр дамжуулан хүний хувьслын судалгаанд Монголын шинжлэх ухааны оруулсан чухал хувь нэмэр, шинэ нээлтүүд, хээрийн шинжилгээ, судалгааны сэдвүүдийг нээн харуулна.
86.	6.1.2 Цаг хугацааны явц дахь биеийн бүтцийн өөрчлөлтүүд оршил	Сая сая жилийн туршид эгц босоо явах, тархины хэмжээ томрох, гарын ур дүй сайжрах, нүүрний бүтэц нарийсах зэрэг биеийн бүтцийн хүчирхэг өөрчлөлтүүд явагдсан
87.	6.1.3.2 Гэр бүлийн ДНХ-ийн түүхүүд	Шалны график зураглал нь орон зайн дагуу байрлах тод өнгөт багануудтай нэгдэнэ. Эдгээр шүтээн (тотем) хэлбэрт багануудд нь эртний өөр өөр нүүдэл болон хүмүүс хэрхэн холилдсоноор манай төрөл зүйлийн олон янз байдал бий болсныг илтгэнэ. Багануудд дээрх Хэвлэмэл тайлбарт болон/эсвэл дижитал самбарууд дараах зүйлсийг багтаана:
88.	6.2.1.1 Иммерсив диорамууд	Эртний хүмүүс одоогийн Монгол нутагт хэрхэн ирснийг мэдсэний дараа үзэгчид тэд энд ирээд хэрхэн амьдарч байсныг олж мэдэх болно. Сууц болон хамтын ахуйг харуулсан бодит хэмжээтэй диорамууд нь

		үзэгчдийг эртний өдөр тутмын амьдрал, нийгмийн харилцаа руу нь хөтлөн оруулах болно. Эдгээр хүмүүс хэчнээн олон янз, хамтач, ур чадвараа хуваалцдаг байсныг, мөн энэ нь заримдаа байгаль орчны хатуу ширүүн нөхцөлд хамт олон болж хөгжихөд хэрхэн нөлөөлснийг ажиглана. Эдгээр диорам нь илүү театрчилсан эсвэл уран сайхны хэлбэртэй байна.
89.	6.2.2.1 Чулуун зэвсгийн хувьслын хана	Диорам доторх задгай гэрийн үргэлжлэл нь түүний цаахна байрлах хана руу хөтлөх бөгөөд энд эртний хүмүүсийн ашиглаж байсан багаж хэрэгслийн хөгжлийг энгийнээс дэвшилтэт арга техник хүртэл, Монголын чулуун зэвсгийн судалгаанаас олдсон мэдээлэлд тулгуурлан харуулна. Олдован ялтаснаас эхлээд ясан зүү хүртэлх чулуун зэвсгийн тэмтрэх боломжтой хуулбаруудыг хананаас салгаж үзэх боломжтой ч танхимаас авч гарахаас сэргийлж утсаар сул бэхэлсэн байна. Хананд бэхэлсэн, янз бүрийн өндөртэй ширээний тавцан бүхий хэсэгт аюулгүй материал байх бөгөөд үзэгчид эдгээр багаж хэрэгслийн өөрсдийн хувилбарыг хийж үзэх, эртний хүмүүс эдгээр бүтээлийг хийхийн тулд ямар хөдөлгөөн, үйлдэл хийдэг байсныг ойлгох боломжтой. Зааварчилгаа диаграмм нь тэдгээр нь хэрхэн ажилладгийг тайлбарлана.
90.	6.2.3.1 Түүх, бэлгэдлийг зураглах нь	Монголын анхны оршин суугчдын амьдрал, орчлон ертөнцийн тухай эртний итгэл үнэмшил, мэдлэг, аж ахуйн амьдрал, ан агнуурын дадал болон бусад амьдралын туршлагыг (тэдний харсан болон агнасан амьтдыг тэмдэглэн үлдээснээр) гэрийн макет доторх тааз, ханын проекцоор дамжуулан дэлгэнэ. Хадны сүг зураг гэрэлтэж, амилан хөдөлж, бүхэл бүтэн түүхийг өгүүлээд дахин бүдгэрнэ. Энэ зуур таазан дээр оддын дүрслэл харагдах бөгөөд ханан дээрх дүрслэл тааз руу шилжин, амьтдыг байгаль, хээ угалзтай хослуулан зүүдний мэт орчныг бүрдүүлнэ. Үүнийг өгүүлэмж дагалдаж болно, эсвэл нам дуутай хөөмий, хээр талын салхи, бөмбөрийн хэмнэл, уншлага, амьтдын дуудлага бүхий орчны чимээтэй хослуулан үлдээж болно. Ханан дээрх амьтдын зураг нь

		Монголоос олдсон дараах дурсгалуудын хуулбар эсвэл тэдгээрээс сэдэвлэсэн байна.
91.	6.2.3.2 Оршуулга ба Зан үйлийн бэсрэг-тайз	Үзүүллэгийн танхимд сэргээн бүтээсэн оршуулга байх бөгөөд эх олдвор нь том хэмжээтэй нүхэн сууц (42.5 м² буюу 7.6 × 5.6 м) байгаа байдалтайгаар хэсэгчлэн харуулж магадгүй. Уг сууцны шалан дор баруун зүгт харуулан суулгасан, 15 орчим настай, 1.2 м өндөр эмэгтэй хүний (охины) оршуулга олдсон. Олон тооны дагалдах эд зүйлс олдсон нь нийгмийн болон зан үйлийн ач холбогдолтойг илтгэнэ. Энэхүү дүр зургийг, ялангуяа хүний үлдэгдлийг сэргээн харуулахдаа, тэр дундаа одоогийн ойлголтоор хүүхэд гэж үзэх тул маш мэдрэмжтэй хандах хэрэгтэй. Цогцсыг хийсвэрлэн харуулах (жишээ нь бодит хэмжээтэй, нүүр царайгүй, үе мөчтэй модон манекен ашиглах), хүнийг 2D зургаар дүрслэх, эсвэл цогцос байгаа шалны хэсгийг бүдгэрүүлэх/харанхуйлах зэрэг зөвлөмжүүд байж болно. Үзэгч гар утсаа оршуулгын хэсэг дээгүүр барихад QR код уншигдаж, дэлгэцэн дээр дотны хүнээ нутаглуулж буй хүн гарч ирэн, хөтлөгч байдлаар бус, харин дотоод сэтгэлийн монолог хэлбэрээр өөрийн мэдрэмж, оршуулгыг хэрхэн бэлтгэсэн тухай ярих болно.
92.	6.2.3.3 Мэдлэг дамжуулах талбай	Аман зохиол болон ардын үлгэр домог нь мэдлэг, соёлыг түгээн дамжуулдаг. Археологийн дурсгалт газрын хэсгийг сэргээн харуулсан байдал нь хүмүүс бүлгээрээ амьдарч байсныг илтгэнэ. Диорам болон оршуулгын газраас үргэлжлэн энэ орон зай даяар (БШУҮМ тодорхой газар болон бусад холбогдох мэдээллийг зөвлөнө) хад чулуу болон бусад туурийн үлдэгдэл нь суудал болох бол, зарим дээр нь уламжлалт түүхүүдийг сийлж, заримд нь түүх өгүүлэх чанга яригчдыг суурилуулна. Энэхүү орон зай нь мөн аман зохиол, уншлагын амьд хөтөлбөр зохион байгуулах интерактив түүх өгүүлэх тойргийн үүрэг гүйцэтгэнэ.

93.	6.3.1.1 Жилийн хүрдээр аялагч	Энэхүү олон давхаргат интерактив нь таван хошуу малыг яагаад сонгосон тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэйгээр улирлын чанартай нүүдлийн өргөн хүрээний түүхийг судална. Хүмүүс мал сүрэгтэйгээ нэг газраас нөгөө рүү хэрхэн нүүдэллэж байсныг харуулахын зэрэгцээ бид таван хошуу мал, тэдгээр нь ямар хэрэгцээг хангадаг байсныг (жишээлбэл: тэмээг ачаа тээвэрлэхэд, үхрийг сүү саальд, сарлагийг дулаан ноосны эх үүсвэр болгон ашигладаг гэх мэт) мэдэж авна. Үзэгчид гурван давхарга, таван хэсэгтэй хүрдийг эргүүлэхдээ ашиглалтын мэдээллийг тухайн амьтан болон улиралтай нь зөв тааруулах даалгавар гүйцэтгэнэ. Энэхүү интерактив нь бидний нүүдэллэх арга барил эрт дээр үеэс хойш өөрчлөгдөөгүйг, иймээс нүүдлийн мал аж ахуй хэрхэн хадгалагдаж ирснийг, мөн цаашид ч хадгалагдах ёстойг (эвдрээгүй хүрдийг засах хэрэггүй) харуулна.
94.	6.3.1.2 Нүүдлийн загварчлалын газрын зураг	Нүүдлийн маршрут нь улирлын болон тогтвортой амьдралын хэв маягийг тусгадаг. Монгол орны газар нутгийг харуулсан, өндөр нам, товгор гадаргуутай, хаялбар шугам, ой, уул, усны ай сав бүхий ширээн дээрх газрын зураг дээр үзэгчид утас ашиглан нүүдлийн маршрутыг тэмдэглэнэ. Түүхэн янз бүрийн нөхцөл байдлыг том картууд дээр өгөх бөгөөд үзэгч үүнд тохируулан газрын зураг дээр нүүдлийн маршрутыг зурах даалгавартай. Мэдрэгчүүд нь утас зөв газартаа байгаа эсэхийг мэдрэх ба ногоон LED гэрлүүд нь үзэгчийн явах ёстой чиглэлд анивчиж зааварчилна. Зам дуусахад үзэгчид өөрсдийн дөнгөж сая зурсан нүүдлийнхээ тухай мэдээллийг унших боломжтой.
95.	6.3.2.1 Хологрaмм туршлага: Супер баатар хошуу мал	Үзэгчид Жилийн хүрд хэсгээс таван хошуу мал тус бүрийг яагаад сонгосон тухай ойлголттой болсон бол одоо энэхүү интерактив хологрaмм (орон зайн дүрслэл) нь тэднийг хэрхэн гаршуулсныг тайлбарлана. Энэ нь тэднийг яг л тайзан дээр гарч буй супер баатрууд эсвэл Олимпын тамирчид мэтээр орон зайд дүрсэлнэ. Эртний Монголчууд гарч ирэн, эдгээр сүрлэг амьтдын байгалийн хүчийг хэрхэн ашигласнаа бахархалтайгаар үзүүлнэ. Эдгээр нь Монголд ховор зүйл биш ч гэлээ,

		хүмүүстэй хэрхэн хамтарч ажилладаг байснаар нь дамжуулан улс оронд оруулсан тэдний болон тэдний өвөг дээдсийн хувь нэмрийн агуу ач холбогдлыг толилуулах болно. Амьтдыг "бодит хэмжээнээс нь ч том" харагдуулахын тулд гүн алслалт технологийг ашиглана. Лазер проектор дахь талстууд нь тусгай нүдний шил зүүсэн үзэгчдэд гэрлийн талбарыг салгаж харагдуулснаар хөдөлгөөнт дүрс амилах болно. Энэхүү технологитой үнэрийг мөн хослуулж болно.
96.	6.3.3.1 Амьд дуу хоолой бүхээг	Итгэл найдвар, төсөөлөл эсвэл шинэ боломжуудыг бэлгэдсэн, эрдэмтдийн ярилцлага, байгалийн зураглал эсвэл бусад тайван дүр төрхийг харуулах видео проекц хийх боломжтой цав цагаан бүхээг эсвэл дууны бөмбөгөр орон зайд үзэгчид уур амьсгалын сорилт, инновацын талаар хэлэлцэж буй Монгол эрдэмтдээс суралцах боломжтой. Ирээдүйд итгэх итгэл найдварыг төрүүлэхийн зэрэгцээ үндэсний болон олон улсын санаачилга, тэр байтугай бидний өдөр тутмын жижиг үйлдлүүдэд ч хүн бүр өөрийн хувь нэмрээ оруулах шаардлагатайг сануулсан, зохих тун нь таарсан сэрэмжлүүлгийг тэд өгөх болно.
97.	6.3.3.2 Интерактив ханын коллаж	Малчдын амьдрал, эрдэмтдийн үзэл бодолтой танилцсан үзэгчид 6-р танхимын аяллынхаа төгсгөлийн цэгт буюу өөрсдийн үгээ хэлэх мөчид ирнэ. Дээрх сэдвүүдийн хүрээнд зураг, мэдэгдэл болон асуултуудыг нэгтгэсэн интерактив ханын эвлүүлэг нь танхимаас авсан мэдээлэлд тулгуурлан тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өв соёлыг үргэлжлүүлэх болон Монголын байгаль, соёлын өвийг хамгаалах бусад стратегитай холбоотой томоохон асуулт, санаа зовоож буй асуудлууд, үзэл бодолд олон нийтийг дуу хоолой, санал бодол, зураглалаа нэмэрлэхийг уриалах болно. Ханан дээр санал бодлоо бичих эсвэл зурах зааврыг эвлүүлгийн хажууд гаргацтайгаар байрлуулна. Энэ нь самбар эсвэл ханан дээр шууд бичих, эсвэл цаас, харандаа ашиглан бичиж, зурсан зүйлээ наах/хатгах/өлгөх хэлбэрээр байж болно.

98.	7.1.0 Геологи ба газарзүй оршил	Дэлхийн чулуулаг, эрдэс болон тектоник хүчнүүд ландшафтыг хэрхэн хэлбэржүүлж буйг эрдэс ялгах өртөө, интерактив галт уул, газар хөдлөлтийн симуляци, Монгол болон дэлхийн иммерсив дижитал зураглалаар дамжуулан мэдрүүлнэ. Геологи ба газарзүй хэсэг нь харанхуй, нууцлаг гэрэлтүүлэгтэй, хар бор, ногоон, цэнхэр өнгө зонхилсон шороон өнгө аястай байна. Агуулгыг динамик проекц, видео, том хэмжээний интерактив дэлгэцээр хүргэнэ.
99.	7.1.1.1 Чулуунаас оч хүртэл: Хувирлын өртөөнүүд (Эрдэс ялгах, турших лаборатори)	Энэхүү гардан хийх интерактив үзмэр нь Монгол орон шиг ашигт малтмал, чулуулгаар баялаг улс нь түүхий эдийг хэрэглээний болон бэлгэдлийн зүйл болгон хувиргах замаар соёлын хувьд ч мөн ямар баялаг болохыг харуулна. Үзэгчид өөр өөр өртөөнүүд дээрх бодит чулуу, металлын түүхий эдийг гартаа барьж үзэн, тэдгээрийн өвөрмөц шинж чанар, өнгө, гялга, бүтцийг мэдрээд сканнер доор байрлуулна. Баяжуулсан бодит байдлын (AR) технологи нь түүнийг эцсийн бүтээгдэхүүн болгон "хувиргаж" харуулна. Жишээлбэл: түүхий галт уулын шил (обсидиан)-ийг бэлэн ир, зэсийн хүдрийг хүрэл багаж, оюуг гоёл чимэглэл болгон харуулна. Мөн үүнийг эсрэг чиглэлд хийх боломжтой бөгөөд чулуу, металл шигтгэсэн уурхайн хана болон хананы урд байрлах хөдөлгөөнт дэлгэцийг ашиглана. Үзэгч дэлгэцийг хананы дагуу гүйлгэж, судлахыг хүссэн металл эсвэл чулууныхаа урд аваачихад түүнээс бүтээж болох эд зүйл дэлгэцэн дээр гарч ирэх ба түүнийг хэрхэн урлаж буй тухай богино хэмжээний бичлэг гарна. Материал бүр нь хүний амьд үлдэх тэмцэл, зан үйл эсвэл худалдаа арилжаатай холбогддог.
100.	7.1.1.2 Орон нутгийн болон дэлхийн чулуулгийн үзүүллэг	Энд бид орон нутгийн болон дэлхийн чулуулгийн дээжийг судлах замаар Монгол орны байгалийн тогтоц дэлхийн геологитой хэрхэн холбогдож буйг олж мэднэ. Улс орнуудаас дээш цухуйсан хигээснүүдийн үзүүрт тухайн нутгийн чулуулгийн дээжийг байрлуулсан том бөмбөрцгийг Монгол орны хэвтээ 3D геологийн газрын зургийн дээр дүүжилнэ. Доорх газрын зургаас мөн адил

		хигээснүүд дээш түрж, Монгол нутгийн чулуулгийн дээжийг дээш өргөн харуулна.
101.	7.1.2.1 Плит хөдөлгөөний ширээ ба Галт уулын өртөө	тектоник нь уулсыг бий болгож, газар хөдлөлтийг өдөөдөг бөгөөд тэдгээрийн зааг нь галт уул дэлбэрэх хамгийн түгээмэл газар болдог. Монгол орон олон тооны галт уултай хэдий ч сүүлийн үед дэлбэрээгүй байна - гэсэн хэдий ч тэдгээр нь хэрхэн ажилладгийг мэдрэх нь гайхалтай туршлага байх болно. Энэхүү гардан хийх ширээний үзмэрт үзэгчид дараах зүйлсийг судална:
102.	7.1.2.2 Газар хөдлөлтийн идэвхжилийн симуляци	Газар хөдлөлийн хүч нь нийгэмд нөлөөлдөг. Газар хөдлөлт байнга тохиодог эсвэл байнгын эрсдэлтэй газрын оршин суугчид тэсвэрлэх чадварыг хөгжүүлж, дэд бүтэц нь ихэвчлэн эдгээр аюулд дасан зохицсон байдаг. Энд иммерсив тавцан нь үзэгчдэд синхрончлогдсон чичиргээ, гэрэл, дууны эффектээр дамжуулан газар хөдлөлтийн хүчийг мэдрэх боломжийг олгоно. Рихтерийн шаталбар дээрх өөр өөр магнитудыг сонгосноор тэд зөөлөн чичирхийллээс хүчтэй доргилт хүртэлх янз бүрийн эрчимтэй газар хөдлөлт ямар мэдрэмж төрүүлдгийг харьцуулах боломжтой
103.	7.1.2.3 Гамшгийн бэлэн байдлын булан	Газар хөдлөлт эсвэл галт уулын дэлбэрэлтийн үед хурдан шуурхай арга хэмжээ авах мэдлэг, багаж хэрэгсэл бүхий тэсвэртэй нийгмийг цогцлоох нь амьд үлдэх боломжийг нэмэгдүүлэх гол түлхүүр юм. Энд үзэгчид газар хөдлөлт/галт уулын бэлэн байдлыг хангах стратеги, гарын авлагуудтай танилцахаас гадна хот, суурин газрын төлөвлөлт нь Монголд болон дэлхий дахинд учирч болзошгүй нөлөөллөөс хэрхэн хамгаалж болохыг судална. Энэхүү үзмэр нь хамтын хариуцлага, бэлэн байдал, мөн динамик байгаль орчинд хүн ард, газар нутгаа хамгаалахад хамтын ажиллагаа; хайрлан хамгаалах сэтгэлгээ чухал болохыг эргэцүүлэн бодоход уриална. Цуврал гурван киоск нь хэрхэн аюулгүй байх тухай тодорхой, практик зөвлөмжүүд болон хот суурингууд барилга байгууламжаа хэрхэн бэхжүүлж, нүүлгэн шилжүүлэх замыг төлөвлөж, газрыг нөхөн сэргээж, олон нийтийн тэсвэрлэх чадварыг дэмжиж буй

		орон нутгийн болон дэлхийн жишээг танилцуулна. Гардан хийх бодлого шийдвэрлэх даалгаврууд нь үзэгчдийг санаагаа туршиж үзэхэд уриална.
104.	7.1.2.3с Гамшгийн дараах Киоскын үйл ажиллагаа: "Дэлбэрэлтийн дараа дахин барих, сэргээн босгох"	Ширээний дэлгэц дээр үнс нурамд дарагдаж, газар нутаг нь өөрчлөгдсөн тосгоныг харуулна. Гол нөлөөлөлд өртсөн зарим хэсгийг дугуйлж тодруулсан байх бөгөөд үзэгчдийн анхаарлыг тийш чиглүүлж, хэрхэн сэргээн босгох, олон нийтийн амьдралыг хамгаалах, соёлын дурсгалт газруудыг хадгалах, аюулгүй байдлыг уламжлалтай тэнцвэржүүлэх талаар бодоход хүргэнэ. Үзэгч хажуугийн самбар дахь эх сурвалжуудаас ямар багаж хэрэгсэл, тусламж авах боломжтойг хайж, хариуцлагын талаар болон тусламжийг хаанаас авч болохыг суралцана. Үүнд:
105.	7.1.3.2 Хайрцаг дахь шуурга"	Уур амьсгал нь орон нутгийн болон дэлхий нийтийн туршлагыг хэлбэржүүлдэг бөгөөд цаг агаарт дасан зохицох нь түгээмэл ойлголт юм. Энэхүү өртөөнд үзэгчид Монгол орны байгальд тохиолддог цаг агаарын үзэгдлүүдийг өөрсдөө бий болгох боломжтой. Салхины хүч, усны нарийн ширхэгт мананг тохируулж, өнгөт гэрлийг байрлуулснаар үзэгчид зөөлөн салхи, үүл мэт шүршигч болон бодит жижиг солонгыг (Говьд зуны борооны дараа эсвэл Хөвсгөлийн уулын голуудын дээгүүр татдаг шиг) үүсгэж болно:
106.	7.2.1.1 Макет бүтээх ширээ ба мэдрэгчтэй дэлгэцийн интерактивууд	Амьдралын мөчлөг нь биологийн олон янз байдлын үндэс болсон өсөлт, өөрчлөлт, дасан зохицох чадварыг харуулдаг. Үзэгчид энэ хэсэгт хэд хэдэн жишээг судлах болно: Баримлын эргэн тойронд байрлах том дугуй тавцан нь үзэгчдийг олон тооны макет угсрах ширээ болон мэдрэгчтэй дэлгэцийн өртөөнүүдээр хөтөлнө. Бөөгнөрөл үүсгэхгүйгээр хайгуул хийх, оролцох боломжийг олгох үүднээс жигд зайтай, үзэгчдийн урсгалыг тасралтгүй байлгахын тулд дугуй хэлбэрээр зохион бүтээгдсэн эдгээр өртөөгөөр дурын дараалаар зочилж болох бөгөөд төвд байрлах урлагийн бүтээлээр дамжуулан амьдралын мөчлөгийн үзэл баримтлалтай нүдэнд харагдахуйц байдлаар холбогдоно. Төв баримал нь мэдрэгчтэй дэлгэцийн өртөөн дээрх харилцан үйлдэлд хариу үйлдэл үзүүлэх

		хөдөлгөөнт эсвэл гэрлийн элементүүдийг агуулж, үзэгчдийн хайгуулыг амьдралын мөчлөгийн үзэл баримтлалтай холбож өгнө.
107.	7.2.1.1a Дэлхийн мөчлөгүүд	Энэхүү том хэмжээний график ханын зураг нь усны эргэлт, нүүрстөрөгчийн мөчлөг, азотын мөчлөг, фосфорын мөчлөг зэрэг дэлхийн үндсэн мөчлөгүүдийг харуулна. Үзэгчид мөчлөгийн өөр өөр цэгүүдийг төлөөлөх соронзтой дугуйнуудыг график дээр байрлуулах замаар эдгээр байгалийн мөчлөг хэрхэн ажилладгийг суралцана. Соронзууд нь дугуйнуудыг гадаргуу дээр тогтооно. Дугуйг зөв газарт нь байрлуулахад шигтгэсэн гэрлүүд асна. Бүх дугуйг зөв байрлуулсны дараа гэрлүүд анивчиж, хөдөлж, мөчлөг урсаж байгааг илтгэнэ. Дахин эхлэх товчлуурыг дарахад гэрэл унтарч, дугуйнууд суурь хэсэг дэх хадгалах сав руу гулсан орно.
108.	7.2.1.1b Мод усыг хэрхэн шингээдэг вэ	Монголын заг (*Haloxylon ammodendron*) мод нь цөлийн хүнд нөхцөлд дасан зохицсон бөгөөд нарны халуунаас хоргодох газар, сүүдэр хайсан янз бүрийн амьтдад хоргодох байр болдог чухал үүрэгтэй. Үндэстэй заг модны зүсэлт нь модны үндсэн дэх нарийн үсэрхэг хэсгүүдээр усыг хэрхэн шингээж, улмаар навчаараа дамжуулан агаарт буцааж гаргадгийг харуулна. Модон дээрх проекц дүрслэл нь энэ мөчлөг хэрхэн явагддаг, эдгээр мод нь эргэн тойрныхоо бусад төрөл зүйлийг хэрхэн хоргодох байр, шим тэжээлээр хангадгийг харуулна.
109.	7.2.1.1e Нүүрстөрөгчийн атомын тоглоом	Энэхүү олон тоглогчтой тоглоомонд үзэгчид дэлхийгээр эргэлдэж буй нүүрстөрөгчийн атомын дүрд хувирна. Хэд хэдэн зогсоолын цэг дээр үзэгчдээс асуулт асуух бөгөөд хариултаас нь хамааран тэд мөчлөгийн дараагийн үе шат руу шилжих эсвэл нүүрстөрөгч болон агаар мандалд цацагдана. Агаар мандал дахь нүүрстөрөгч нэмэгдэх тусам анхааруулга гарч ирэх бөгөөд тэд нүүрстөрөгчийг багасгах эсвэл тоглоом зогсох эгзэгтэй түвшинд хүрэх хүртэл үргэлжилнэ. Үзэгч бүрийн зорилго бол хэт их нүүрстөрөгч ялгаруулахгүйгээр мөчлөгийг туулах явдал юм.

110.	7.2.1.2 Амьтдын дуу чимээ ба авианы өртөө	Амьтдын харилцаа холбоо, дуу хоолой нь улирал, өсөлт цэцэглэлтийг илтгэдэг. Энэхүү дуут бүхээгт Монголын орон нутгийн өөр өөр зүйлүүдийн дуу чимээний сонголтыг санал болгох бөгөөд улирлын ялгааг нь тодорхой тэмдэглэсэн байна. Олон дуу чимээг нэгэн зэрэг тоглуулж "концерт" үүсгэх боломжтой бөгөөд бичлэг хийж, QR кодоор дамжуулан үзэгч өөрийн бүтээсэн шинэ дууг и-мэйлээр хүлээн авах боломжтой. Үзэгчид удирдлагыг ашиглан ямар амьтан, хэзээ, яагаад, ямар дуу гаргадгийг ялгахын тулд аль амьтныг сонсохоо сонгоно.
111.	7.2.2.1 Идэш тэжээлийн хэлхээг бүтээх эвлүүлдэг хана	Биомын байгалийн зураглал нь энэхүү интерактив үйл ажиллагааны арын дэвсгэр болно. Үзэгчид амьтдыг ханын зураг дээрх идэш тэжээлийн хэлхээний тохирох байршилд нь байрлуулах замаар идэш тэжээлийн хэлхээг аажмаар сурч, бүтээнэ. Жишээлбэл, Говийн цөлийн биомд үнэг, харцага, шар шувуу идэш тэжээлийн хэлхээний оройд байх бол мод, ургамал зэрэг бүтээгчид хамгийн доод түвшинд байна. Үзэгчид идэш тэжээлийн хэлхээний нэг буюу хэд хэдэн хэсгийг хасахад гарах үр дагавар, энэ нь бусад бүх зүйлд хэрхэн нөлөөлдгийг мэдэж авна. Үүнд багтах биомууд:
112.	7.2.2.3 Төрөл зүйлийн хорогдол ба сэргэлтийн дижитал тоглоом	Том мэдрэгчтэй дэлгэц дээр 2 ба түүнээс дээш үзэгч Монголын экосистемүүдээс (хээр тал, тайга эсвэл Говь цөл) сонгоно. Орчин бүр 7.2.2.1-д үзсэнтэй ижил энгийн идэш тэжээлийн хэлхээгээр холбогдсон ургамал, амьтны аймгийн бүрдлээр эхэлнэ (ж.нь: өвс → тарвага → бүргэд; заг мод → шавж → цөлийн үнэг). Үзэгчид бэлчээрийн даац хэтрэхээс сэргийлэх, хулгайн антай тэмцэх, усны эх үүсвэрийг сэргээх эсвэл нүүдлийн зурвас замыг хамгаалах зэрэг байгаль хамгааллын сорилтуудтай тулгарна. Тоглогч шийдвэр гаргахад идэш тэжээлийн хэлхээ тэр дороо шинэчлэгдэнэ:

113.	7.2.3.1 Уур амьсгалд дасан зохицож амьд үлдэх тоглоом	Эко-дасан зохицол гэдэг нь тэнцвэрийн тухай ойлголт болохыг, мөн Монгол орон дэлхийн уур амьсгалын тэсвэрлэх чадварт ямар агуу практик сургамж санал болгодог болохыг ойлгохын тулд үзэгчид дасан зохицох стратеги боловсруулдаг дижитал өртөө эсвэл ширээ. Түүхүүд нь Монголын эрс тэс цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтөд хүн болон амьтад хэрхэн дасан зохицсоныг харуулахын зэрэгцээ практик эко-шийдлүүдийг онцолно.
114.	7.3.1.1 Татах хүч	Тайлбар самбар нь татах хүч гэдэг нь гараг эсвэл бусад том биетүүд бусад зүйлийг төв рүүгээ татдаг хүч болохыг тайлбарлана. Энэ бол гарагуудыг нарыг тойрон эргэх тойрог замд нь барьж байдаг хүч юм. "Татах хүчний худаг" интерактив нь татах хүч хэрхэн ажилладгийг тайлбарлана.
115.	7.3.1.2а Өөрсдөө галзуу хулгана бүтээ	Оролцогчдод галзуу хулганы замыг өөрсдөө сонгон бүтээх боломжийг олгодог интерактив мэдрэмж туршлага. Дараа нь тэд овгор бүрийн өндөр эсвэл налуу, налуу замын өнцөг, гогцооны хэлбэр зэрэг хөдөлгөөнд нөлөөлөх хувьсагчдыг туршиж үзэх боломжтой болно.
116.	7.3.2.2с Биолюминесценц	Энэхүү үзмэрт үзэгчид биолюминесценц гэж юу болох, Монголд ямар организм гэрэлтдэг болохыг судлах боломжтой.
117.	7.3.3.1а Луужингаар чиг баримжаалах	Энэхүү үзмэрээс үзэгчид дэлхийн соронзон орон гэж юу болох, тэр нь сансарт хэрхэн тархаж дэлхийг нарны салхинаас хамгаалж, амьдрал оршин тогтнох боломжийг бүрдүүлдэг болохыг ойлгож авна
118.	7.3.3.2 Соронзон нүүдэл	Энэхүү үзмэрээс үзэгчид дэлхийн соронзон орон шувууд болон бусад амьтдын нүүдлийн маршрутад хэрхэн нөлөөлдгийг мэдэж авна. Зарим шувууд болон амьтдад соронзон орон мэдрэх чадвар буюу магниторецепц байдаг. Судалгаагаар олон зүйлийн шувуудын нүдэнд (ялангуяа баруун нүдэнд) соронзон мэдээллийг боловсруулдаг тархины тусгай хэсэгтэй холбогдсон соронзон мэдрэгчүүд байдгийг тогтоожээ. Энэхүү харааны-соронзон систем нь шувууны харж буй дүрслэл дээр соронзон орны мэдээллийг давхарлан харуулж, шувууны ойлголтод нэг төрлийн "соронзон газрын зураг"-ийг үүсгэдэг бололтой.

119.	7.4.1.1 Химийн элементүүдийн үелэх систем	Энэхүү интерактив ширээн дээр элементүүд куб хэлбэрээр тус бүрдээ гэрэлтэнэ. Үзэгчид товчлуур дарах эсвэл хавхалгыг сөхөх замаар тухайн элементийн талаар илүү ихийг мэдэж, бодит амьдрал дээр хэрхэн ашиглагддаг жишээг харах боломжтой.
120.	7.4.1.2 Шилэн саван дахь үүлс	Монголын үүлэрхэг тэнгэрийн үзэсгэлэнт дүр зураг (дрон зураг эсвэл бичлэг) нь энэхүү энгийн боловч хөгжилтэй шинжлэх ухааны туршилтын арын дэвсгэр болно. Энд үзэгчид усыг үүл болгон хувиргах боломжтой.
121.	7.4.2.1а Би юунаас бүтсэн бэ?	Графикууд нь хүн болон бусад организмын (жишээ нь: хүн, загас, шавж, ургамал) элементийн найрлагыг харьцуулан харуулна. Үүнийг эргэдэг самбар эсвэл ухаалаг ширээ ашиглан илүү сонирхолтой байдлаар хийж болно. Тэмдэглэгээтэй төрөл бүрийн "дугуй"-г гадаргуу дээр тавихад тухайн организмын найрлагыг шууд харуулна. Дэлгэцэнд хүрснээр элемент, нэгдлүүдийн талаар болон бусад дугуйгаар илэрсэн организмуудтай хэрхэн харьцуулагдаж буйг (ж.нь: та болон нүүрсний хэлтэрхий хоёрт ямар нийтлэг зүйл байна вэ?) мэдэж авах боломжтой.
122.	7.5.3 Ирээдүйн төсөөлөл ба Шинээр гарч буй судалгаа	Дижитал хянах самбар, шинжлэх ухааны ирээдүйн дүрслэл, хиймэл дагуулын зураглал, иргэдийн оролцоот шинжлэх ухаан, технологи, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн химийн дэвшлийг харуулсан Монголын болон дэлхийн санаачилгууд нь шинжлэх ухааны боловсрол, музейн хувьсан өөрчлөгдөж буй үүргийг онцолно.
123.	Дом театр контент	Үзүүллэгийн 7 танхим тус бүрийн шинжлэх ухааны кино контент хийх, худалдан авах зардал
124.	Орчуулга 5-н хэл дээр	Үзүүллэгийн 7 танхим тус бүрийн шинжлэх ухааны кино контентийг 5 хэл дээр орчуулах
126	Үзмэрийн аудио тайлбар хийх QR технологиор үзмэрийн тайлбар	- Захиалагчийн бэлтгэсэн Монгол, Англи хэл дээрх музейн бичвэр тайлбарыг үзмэр тус бүрд 2-5 минутанд багтаан аудио хэлбэрт оруулах.

	боловсруулах (2000 үзмэрт)	- Аудио бичлэгүүд нь мэргэжлийн студид чанарын өндөр түвшинд бичигдсэн байх. Монгол Англи хэл дээрх дуу оруулалт нь цэвэр тод, дуудлага болон хэл зүйн алдаагүй байх. - Аудио үзмэрүүдийг нэгдсэн программ хангамжид байршуулах. - Программ хангамж нь үзмэрийн мэдээллийг оруулахад автоматаар QR код үүсгэдэг байх. - Үзмэрийн бичвэр тайлбарыг Англи хэл дээр орчуул ж, QR-руу шилжүүлэх. - Бэлэн болсон үзмэрийн фото зураг болон текст мэдээллийг нэг стандарт болгон бэлтгэх.
127	БАРИМТАТ КИНО (бүрэн хэмжээний, 30 минут, 6 анги)	"Монгол орны Тагийн бүслүүрийн дөрвөн улирал" - "Монгол орны Тайгын бүслүүрийн дөрвөн улирал" -"Монгол орны Ойт хээрийн бүслүүрийн дөрвөн улирал" -"Монгол орны Хээрийн бүслүүрийн дөрвөн улирал" -"Монгол орны Говийн бүслүүрийн дөрвөн улирал" -"Монгол орны Цөлийн бүслүүрийн дөрвөн улирал" Тус бүр 30 мин үргэлжлэх Олон улсын шаардлага хангасан: 4K, 60fps, файл ирүүлэх -Зориулалт: Музейн үзүүлэг дэглэлтэнд, -ТВ, сошиал сурталчилгаанд, -Олон улсын хэмжээнд үзүүлэхүүц.
128	Баримтат кино, гэрэл зураг, дуу авианы бичлэг, дроны дурс бичлэг	**1. БАРИМТАТ КИНО (бүрэн хэмжээний, 30 ми 6 анги)** 1. "Монгол орны Тагийн бүслүүрийн дөрвөн улирал" 2. "Монгол орны Тайгын бүслүүрийн дөрвөн улирал" 3. "Монгол орны Ойт хээрийн бүслүүрийн дөрвөн улирал" 4. "Монгол орны Хээрийн бүслүүрийн дөрвөн улирал" 5. "Монгол орны Говийн бүслүүрийн дөрвөн улирал" 6. "Монгол орны Цөлийн бүслүүрийн дөрвөн улирал" **2. БАРИМТАТ КИНО (богино хэмжээний, 5минут, 24 анги)** (Тагийн бүслүүр)

		1. "Монгол Алтай нурууны Тагийн бүслүүр" 2. "Цамбагарав уулын Тагийн бүслүүр" 3. "Хархираа, Түргэний уулсын Тагийн бүслүүр" 4. "Хөвсгөлийн сарьдаг уулсын Тагийн бүслүүр" (Тайгы бүслүүр) 5. "Хангай нурууны Тайгын бүслүүр" 6. "Хөвсгөлийн сарьдаг уулсын Тайгын бүслүүр" 7. "Хэнтэй нурууны Тайгын бүслүүр" (Ойт хээрийн бүслүүр) 8. "Монгол Алтай нуруу ба Говь Алтай нурууны Ойт хээрийн бүслүүр" 9. "Хангай нурууны Ойт хээрийн бүслүүр" 10. "Хойд бүсийн уулсын Ойт хээрийн бүслүүр" 11. "Хэнтэй нурууны Ойт хээрийн бүс" 12. "Халх, Нөмрөгийн сав газрын Ойт хээрийн бүслүүр" (Хээрийн бүслүүр) 13. "Алтай, Хангай нурууны хоорондох Хээрийн бүслүүр" 14. "Хангай, Хэнтэй нурууны хоорондох Хээрийн бүслүүр" 15. "Дорнод Монголын Хээрийн бүслүүр" ("Алтай, Хангай нурууны хоорондох Хээрийн бүслүүр" **3.ГЭРЭЛ ЗУРАГ** **1.** Монгол орны 6 бүс, бүслүүрийн төлөөлөл газар нутгийн төрх **2.** Монгол орны 6 бүс, бүслүүрийн Биологийн төрөл зүйлийн түлхүүр зүйлс **4.ДРОНЫ ДҮРС БИЧЛЭГ** 1. Монгол орны 6 бүс, бүслүүрийн төлөөлөл газар нутгийн төрх Монгол орны 6 бүс, бүслүүрийн Биологийн төрөл зүйлийн түлхүүр зүйлс **5.ДУУ АВИАНЫ БИЧЛЭГ** 1. Монгол орны 6 бүс, бүслүүрийн төлөөлөл газар нутгийн дуу авиа 2. Монгол орны 6 бүс, бүслүүрийн Биологийн төрөл зүйлийн түлхүүр зүйлсийн дуу авиа

128	Монголын байгалийн шинжлэх ухааны салбарт нэр хүнд бүхий эрдэмтдийн баримтад кино	Монголын байгалийн шинжлэх ухааны салбарт нэр хүнд бүхий эрдэмтдийн баримтад кино, контент хийх
129	Ажлын хөлс	Ажил гүйцэтгэлийн хөлс
Нийт 128 дижитал үзүүллэгийн баяжилт, видео зураглал байна.		

Дуу дүрс/Мэдээллийн технологи/Мультимедиа/Механик системүүд

- Бүх AV/IT/Мультимедиа/Механик системийг Багц 3 болон 4-т заасны дагуу суурилуулна.
- Медиа контентыг дуу дүрс тоглуулах төхөөрөмжүүдтэй уялдуулан бүрэн тохируулах, үүнд шаардлагатай код бичих эсвэл программчлах ажлыг багтаана.

Системийн суурилуулалт ба тохируулга

- Суурилуулалт болон системийн тохиргоог үйлдвэрлэгчийн мэргэшсэн төлөөлөгчид гүйцэтгэнэ. Үүнд бүх нам хүчдэл (LV), дуу дүрс (AV), мэдээллийн технологи (IT)-ийн системүүд болон бусад ижил төстэй эмзэг электрон системүүдэд зориулсан Тасралтгүй тэжээлийн үүсгүүр (UPS) багтана.
- Боломжтой бол хяналтын системүүдийг сүлжээнд холбох бөгөөд Extron (www.extron.com) зэрэг нэгдсэн, хялбаршуулсан удирдлагын системийг ашиглана.
- Зөвхөн үзүүллэг, үзмэрүүдийг Захиалагчийн шаардлагын дагуу суурилуулсны дараа AV тоног төхөөрөмжид эцсийн тохируулга хийнэ.

Анхаарах зүйл: Багц 3 болон 4-т тодорхойлсон бүрдэл хэсгүүдийг дэмжих шаардлагатай бие даасан үзүүллэгүүд рүү цааш түгээх боломжийг олгохын тулд шахсан агаар, ундны ус, ус зайлуулах системийг 7-р Танхим дахь төвлөрсөн (таталцлын хүчээр ажиллах боломжтой) байршилд гаргаж өгөх шаардлагатай.

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

ATA12932 6594204 9024670546

6. БРЭНД ДИЗАЙН, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий үзүүлэлт		
№	**Шалгуур**	**Техникийн тодорхойлолт**
1.	Үндсэн хийцлэл	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэх Музейн үйл ажиллагааг зөвхөн үзмэр үзүүлэх бус, судалгаа, эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн төв гэдгийг лого болон өнгө төрхөөр дамжуулан олон нийтэд таниулах.
Логоны бүтэц		
№	**Шалгуур**	**Техникийн тодорхойлолт**
2.	Ерөнхий шаардлага	Монгол орны өвөрмөц байгаль, палеонтологийн олдвор (үлэг гүрвэл г.м), биологийн олон янз байдлыг орчин үеийн дизайны шийдэлтэй хослуулан "Үндэсний" гэх статусыг илэрхийлэх. Шинэ лого нь дижитал орчин, хэвлэмэл материал, сувенир болон барилгын гадна фасадад ашиглахад тохиромжтой, хэд хэдэн хувилбараар хөрвөх чадвартай байх.
3.	Нэршил	Монгол: Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей Англи: National museum of natural science
4.	Дизайны шаардлага	Амьтан, ургамал, геологи, палеонтологийг агуулсан
5.	Өнгө	Шинжлэх ухааны музейд тохиромжтой орчин үеийн өнгөний палитр санал болгох
6.	Шрифт	Уншихад хялбар "Sans-serif" төрлийн шрифт (Жишээ нь: Montserrat эсвэл Roboto)
Техник үзүүлэлт		
№	**Шалгуур**	**Техникийн тодорхойлолт**
7.	Өнгө	RGB, CMYK, Pantone кодыг нарийвчлах
8.	Вектор файл	AI /Adoe Illustrator/, EPS, SVG
9.	Зургийн файл	PNG /дэвсгэргүй тунгалаг/, JPG /цагаан дэвсгэртэй/
10.	Нягтаршил	300 dpi, өргөн – хамгийн багадаа 3000 px байх ба өнгөт хувилбар, хар-цагаан хувилбар, нэг өнгийн /mono/ хувилбар
11.	Ашиглагдах байдал	Нэрийн хуудас, албан бланк, дугтуй, ажлын үнэмлэх, гадна фасад, вэб сайт, социал хуудас, постер, цахим шуудангийн гарын үсэг г.м

Брэндинг		
№	**Шалгуур**	**Техникийн тодорхойлолт**
12.	Судалгаа	Олон улсын жишигт нийцсэн байдлын судалгаа, харьцуулалт хийж тайлагнах
13.	Дотор засал	Гадна болон дотоод интерьерийн зураглалд брэндингийн агуулга, өнгө шингэсэн байх
14.	Wayfinding болон хаягжилтын систем	• Танхимын нэрийн самбар • Чиглүүлэх тэмдэг • Давхарын зураглал • Аюулгүй гарцын тэмдэг • Танхимын кодчилол
15.	Гадна фасад	Гадна фасадад байрлах логоний хийцлэл, материал сонголт
16.	Бүтээгдэхүүн	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейг илэрхийлэх брэнд бүтээгдэхүүнийг доорх төрлүүдэд санал болгох: Өнгө, дизайн дэмжих хэлбэр, уриа үгийн бичилт, бичиг хэрэг, цахим орчин, хаягжилт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, ажилтны хувцас, тээврийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ г.м
17.	Хүлээлгэн өгөх	Гүйцэтгэгч дараах брэндийн иж бүрэн материалыг боловсруулж хүлээлгэн өгнө: • Логоны иж бүрдэл (primary, secondary, icon) • Брэндийн өнгөний систем (primary, secondary palette) • Шрифтын багц ба хэрэглээний заавар • Брэндийн pattern, график элементүүд • Фото болон дүрсний стиль (image style guide) • Икон багц (icon set) • Социал медиа загварууд • Презентацийн загвар (PowerPoint template)
18.	Брэндийн гарын авлага (Brand guideline)	Гүйцэтгэгч 50–80 нүүр бүхий брэндийн гарын авлага боловсруулна. Үүнд: • Лого ашиглах дүрэм • Өнгө ашиглах заавар • Шрифт ашиглах дүрэм • Layout grid • Жишээ хэрэглээнүүд
19.	Өмчлөл	• Брэндийн бүх эх файл, дизайн, концепц нь захиалагчийн өмч болно.
20.	Дизайны баталгаажуулалт	Гүйцэтгэгч хамгийн багадаа 3 удаагийн засвар өөрчлөлт хийх боломжтой байна.
21.	Хүлээн авах шалгуур	• Брэндийн гарын авлага батлагдсан байх • Бүх эх файлыг хүлээлгэн өгөх • Бүх файл нээлттэй форматтай байх

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

АТА12932 6594204 9024070546

7. ҮЗҮҮЛЛЭГИЙН ХАЯГ, ТАЙЛБАР, ОРЧУУЛГЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

I. ТЕКСТ КОНТЕНТ				
№	**Барааны нэр**	**Техникийн тодорхойлолт**	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**
1	Шинжлэх ухааны тайлбар текст боловсруулах, редактор	Музейн тайлбар текстийг шинжлэх ухааны редакторaар хянуулах, нэр томьёоны нэгдсэн сан (glossary) боловсруулах, эцсийн текстийг Word болон Excel форматаар хүлээлгэн өгөх.	Багц	1
2	Олон хэлний орчуулга	Монгол хэл дээрх тайлбаруудыг 5 хэл рүү мэргэжлийн түвшинд орчуулах, орчуулга бүрийг хос редакторaар хянуулж баталгаажуулах.	Ширхэг	3000
3	Монгол бичигт хөрвүүлэх	Монгол хэл дээрх тайлбар текстийг Unicode стандарт бүхий Монгол бичигт мэргэжлийн түвшинд хөрвүүлж, засварласан эх файлыг editable хэлбэрээр хүлээлгэн өгнө.	Ширхэг	3000
4	Контент стандарт формат боловсруулах	Фото, текст, аудио контентын метадата, файлын нэршил, хавтасны бүтэц болон CMS-д импортлох нэгдсэн стандарт боловсруулах, баримтжуулж хүлээлгэн өгөх.	Багц	1

II. ХЭВЛЭЛ БА САМБАР				
№	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Нэгж	Тоо
5	Танхимын ханын ерөнхий тайлбар	Үзүүллэгийн танхим тус бүрийн ерөнхий тайлбарыг ханан дээр лазер/UV хэвлэлээр тод, гаргацтай байршуулна. Хэл: Монгол, Англи, Монгол бичиг. Танхим бүрт ойролцоогоор 3×5 м талбайд байршуулна. Ханын зориулалтын винил/обой эсвэл хатуу хавтан материал ашиглаж, угааж цэвэрлэх боломжтой байна.	Ширхэг	7
6	Танхимын ерөнхий тайлбар самбар	Composite эсвэл acrylic материалтай, зузаан ≥5 мм, гэрэл ойлголтгүй (anti-glare) гадаргуутай, хананд суурилуулах бэхэлгээний иж бүрдэлтэй, дотор орчны ашиглалтын нөхцөлд тэсвэртэй.	Ширхэг	7
7	Бүлэг үзмэрийн тайлбар самбар	Acrylic/composite. Шилэн хоргонд байрлуулах боломжтой.	Ширхэг	155
8	Нэгж үзмэрийн хаяг тайлбар	Acrylic материалтай шошго, зузаан ≥3 мм. Гэрэл ойлголтгүй (anti-glare) гадаргуутай, стандарт дизайн загвар ашигласан, шилэн хоргонд байрлуулахад тохиромжтой.	Ширхэг	2057
9	Танхимын хэвлэл (обой, стикер, график элемент)	Үзүүллэгийн танхимын ханын	Ширхэг	1706

		график, обой, стикер болон чиглүүлэх график элементүүдийг өндөр нягтралтай UV хэвлэлээр гүйцэтгэнэ. Галд тэсвэртэй, дотор орчны зориулалтын материал ашигласан, арчиж цэвэрлэх боломжтой, өнгө алдахгүй байх.		
III. ФОТО БА ДҮРС				
№	**Барааны нэр**	**Техникийн тодорхойлолт**	**Нэгж**	**Тоо**
10	Уран сайхны фото, гар зургийн эх файл	Сэдэвчилсэн танхим болон үзмэрт ашиглах байгаль, ан амьтан, ургамал, монгол ахуйг харуулсан гэрэл зураг, эртний амьтан, ургамлын сэргээн босгосон зураг болон гар зургийн эх файлыг худалдан авч нийлүүлнэ. Нягтаршил ≥300 dpi, RAW/TIFF/PSD зэрэг эх форматаар байна. Зохиогчийн эрхийн зөрчилгүй, музейд бүрэн ашиглах болон шилжүүлэх эрхтэй байна.	Ширхэг	3000
11	3D/AR тархацын тайлбар контент	Үзмэрийн тархац, орчны мэдээллийг харуулах 3D/AR контент боловсруулна. Photo tracking технологи ашигласан 2D/3D motion graphic, дуу, тайлбар, график элементтэй байна. Видео формат: Full HD болон 4K, MP4	Ширхэг	5

		болон эх файлын хамт нийлүүлнэ.		
12	Байгалийн бүс нутгийн виртуал аялал видео	Дархан цаазат болон тусгай хамгаалалттай бүс нутгийг танилцуулах дрон болон газрын зураг авалттай 4K видео бэлтгэнэ. Дуу, тайлбар, инфографик элементүүд орсон байна.	Ширхэг	15
IV. АУДИО КОНТЕНТ				
№	**Барааны нэр**	**Техникийн тодорхойлолт**	**Нэгж**	**Тоо**
13	Үзмэрийн аудио тайлбар	Үзмэрийн тайлбар текстийг мэргэжлийн студид бичиж, дууны боловсруулалт (noise reduction, mastering) хийсэн байна. Дууны чанар ≥48kHz / 24bit. Формат: WAV болон MP3. QR болон дижитал системд ашиглахад бэлэн файл нийлүүлнэ.	Ширхэг	1140
14	Музейн ерөнхий аудио тайлбар	Музейн ерөнхий танилцуулгын аудиог 5 хэл дээр мэргэжлийн студид бичиж, дууны боловсруулалт хийсэн байна. Формат: WAV болон MP3.	Ширхэг	7
V. ДИЖИТАЛ СИСТЕМ				
№	**Барааны нэр**	**Техникийн тодорхойлолт**	**Нэгж**	**Тоо**
15	QR код бүхий тайлбарын систем	Үзмэрийн тайлбар контент байрлуулах контент удирдлагын систем (CMS) хөгжүүлэх. Автомат QR код үүсгэх	Ширхэг	3000

		боломжтой, гар утаснаас уншигдах mobile friendly интерфэйстэй, аудио, текст, зураг холбох боломжтой. Системийн нэвтрэх эрх болон эх кодыг захиалагчид шилжүүлнэ.		
16	Контент системд байршуулах	Бэлтгэсэн бүх текст, зураг, аудио контентыг QR системд байршуулж, холбоос, туршилт, шалгалтыг бүрэн хийж хүлээлгэн өгнө.	Багц	1
VI. КАТАЛОГ БА ЭХ ФАЙЛ				
№	**Барааны нэр**	**Техникийн тодорхойлолт**	**Нэгж**	**Тоо**
17	Үзмэрийн тайлбарын каталог дизайн, эх файл	Музейн үзүүллэгийн танхимуудын тайлбар бичвэрийг нэг стандарт дизайнтайгаар эмхэтгэж каталогийн эх бэлтгэл хийнэ. Каталогт дараах танхим, сэдвүүдийн тайлбар багтана: 1) Орчлон ертөнцийн үүсэл ба хөгжил 2) Геологи 3) Газар зүй 4) Биологийн олон янз байдал 5) Амьдралын үүсэл, хувьсал (Кембрийн өмнөх, Палеозой, Мезозой, Кайнозой) 6) Хүний үүсэл, хувьсал (эртний хүмүүс, нүүдлийн мал аж ахуй) 7) Шинжлэх ухаан.	Багц	1

		Танхим тус бүрийн үзмэрийн тайлбар, редакторласан текст, фото зураг багтсан байна. InDesign болон хэвлэлийн PDF эх файлыг editable хэлбэрээр хүлээлгэн өгнө.		
18	Үзмэрийн тайлбарын каталог хэвлэх	Каталогийг бүрэн өнгөт, өндөр чанарын цаасан дээр хэвлэж нийлүүлнэ.	Ширхэг	1000
19	Бүх эх файл хүлээлгэн өгөх	Бүх боловсруулсан эх файлууд (AI, PSD, INDD, аудио, видео болон холбогдох лиценз, нэвтрэх эрх)-ыг иж бүрнээр захиалагчид шилжүүлнэ.	Багц	1

Жич: Дээрх тоо хэмжээ, загвар нь урьдчилсан тооцоо бөгөөд нарийвчилсан дизайны шатанд ±10%-ийн хэлбэлзэлтэйгээр баталгаажна.

___o0o___

Загвар самбар

160 x 200 cm



100 x 200 cm



250 x 55 cm



___o0o___

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

8. СЭРГЭЭСЭН АМЬДРАХ ОРЧИН, МЕХАНИК ЗАГВАР ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Агуулга	Тавигдах шаардлага
	Нэр, байршил, хүчин чадал	- Нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н Үзмэр боловсруулалт, модель бүтээх болон холбогдох материал, химийн бодис нийлүүлэх. - Байршил: • А блок- 2 дугаар давхарт 1-3 танхим; • Б блок- 1 дүгээр давхарт 2 танхим; • Б блок- 2 дугаар давхарт 1 танхим; • В блок- 1-2 давхарт 1 танхим; - Хүчин чадал: • А блок- 2 дугаар давхарт 1 танхим (Орчлонгийн үүсэл хөгжил)-292.04 м^2; • А блок- 2 дугаар давхарт 1 танхим (Геологи)-550.52 м^2; • А блок- 2 дугаар давхарт 1 танхим (Газарзүй)-795.30 м^2; • Б блок- 1 дүгээр давхарт 1 танхим (Хүний үүсэл хөгжил)-500 м^2; • Б блок- 1 дүгээр давхарт 1 танхим (Шинжлэх ухаан танин мэдэхүй)-2,065 м^2; • Б блок- 2 дугаар давхарт 1 танхим (Биологи)-2,856.23 м^2; • В блок- 1-2 давхарт 1 танхим (Амьдралын үүсэл хөгжил)-1,696.75 м^2+2,391.74м^2=4,088.49м^2;
2	Бүтээлийн төрөл:	Сэргээсэн амьдрах орчин, механик загвар
3	Материал:	Материал нь бат бөх, удаан эдэлгээтэй олон улсын шинжлэх ухааны музейн стандарт байх
4	Хэмжээ:	Батлагдсан зураг төслийн дагуу байх.
5	Ерөнхий шаардлага:	1. Бүх сэргээн засварлалт, механик загварууд нь шинжлэх ухааны оролцоот үзмэр, палеонтологи, биологийн хамгийн сүүлийн үеийн олдвор, судалгаанд үндэслэсэн байна. Гүйцэтгэгч нь мэргэжлийн эрдэмтдийн зөвлөгөөг заавал авсан байна. 2. Ашиглах бүх материал (полимер, силикон, металл) нь хүний биед хорт нөлөөгүй, үнэргүй, галд тэсвэртэй (FR - Fire Retardant) стандартыг хангасан байна.

		3. Үзмэрүүд нь олон нийтийн хөдөлгөөн ихтэй орчинд 10-аас доошгүй жил чанараа алдахгүй байхаар тооцогдсон байна. 4. Механик загварууд нь үзэгчид (ялангуяа хүүхэд) хүрэхэд гар хуруу хавчуулах, хурц ирмэгээр зүсэх, цахилгаанд цохиулах эрсдэлгүй байна. 5. Үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд хор хөнөөл багатай технологи ашиглахыг эрмэлзэнэ. 6. Үзмэрийн дүрслэл, төрх байдлыг сайтар анхаарч бүтээх.
6	Тусгай шаардлага:	1. Гүйцэтгэгч хийгдэх загвар,хэмжээ, материалыг захиалагчаар батлуулах. 2. Шууд үзүүллэгт дэглэх боломжтой бэлэн үзмэр байх **3. Ахин бүтээсэн үзмэр (Static Reconstructions):** • Анатомийн нарийвчлал: Ясны бүтэц, булчингийн холбоос, арьсны нугалаас бүрийг бодит мэт (Hyper-realistic) гаргах. • Будалт ба Текстур: Арьсны өнгийг жигд тод, гүн болон сүүдэрлэх техникийг ашиглан гараар будна. Нүдний болрыг тусгай оптик материалаар хийж, амьд мэт харагдуулна. • Суурилуулалт: Үзмэрийн жинг хөрсний макет дээр жигд хуваарилж, үзэгчдийн аюулгүй байдлыг хангах далд бэхэлгээтэй байх. 4. **Механик болон Аниматроник загвар** • Хөдөлгөөний жигд байдал: Моторуудын ажиллагаа гацахгүй, огцом хөдөлгөөн хийхгүй, чимээ багатай (Low noise levels) байна. • Программчлал: Хөдөлгөөний цикл нь 1-3 минутын хооронд өөр өөр байх бөгөөд үзэгчид нэгэн хэвийн давтамж мэдрэгдэхгүй байхаар тооцно. • Алсын удирдлага ба Хяналт: Үзмэрүүдийг төвлөрсөн удирдлагын системээс асаах, унтраах, алдааг оношлох боломжтой байна. **5. Сэргээсэн амьдрах орчны дэглэлт** • Гэрэлтүүлгийн интеграц: Диорам бүр өөрийн гэсэн гэрэлтүүлгийн температуртай байна (Жишээ нь: Далайн гүн - 6500K хүйтэн, Цөлийн орчин - 2700K дулаан). • Аудио систем: Чиглүүлэгч чанга яригч (Directional speakers) ашиглан зөвхөн тухайн үзмэрийн өмнө зогсоход дуу сонсогддог, бусад үзмэрт саад болохгүй байхаар шийднэ. **6. Хүлээн авах шалгуур үзүүлэлт**

		• Гүйцэтгэгч ажлыг хүлээлгэн өгөхдөө дараах баримт бичгийг бүрдүүлнэ: • Үзмэрийн техникийн үзүүлэлт, ашигласан материалын гэрчилгээ. • Ажиллуулах болон өдөр тутмын арчилгааны гарын авлага монгол хэл байх. • Засварын Иж бүрдэл: Өнгө алдах, нөхөх үед ашиглах нөхөөс материал, будагны код дагалдах. **7. Бусад.** Иж бүрдлийн нарийвчилсан бүрэлдэхүүнийг зураг техникийн шийдлийн шатанд баталгаажуулна.

№	Барааны нэр	Техникийн ерөнхий шаардлага	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Дүйцэхүйц зураг
1.	Элсэн хайрцаг	- Зөөврийн хувьд гурван хэсэгт хуваагдана - 5200 люмен проектор - Халихад зориулсан элс/цаасны сав багтана - Хүүхдийн өндөрт тохирсон 8 1⁄2" хөлтэй Байршил: 3.1.2.1	1	Баг ц	
2.	Түүх сонгогч үзүүллэг	- Үндсэн бүтэц: Төв хэсэгтээ "түүх сонгогч" бүхий сийлбэртэй, том хэмжээний модон дугуй ширээ - Сонгогч нь эргэдэг зураг, амьтны тотем эсвэл сийлбэртэй чулуун хэлбэртэй байж болно - Багтаамж: 8 хүртэлх хүн зэрэг суух боломжтой суудалтай. - Дууны систем: Суудал бүрийн дээр эсвэл ард байрлах, зөвхөн тухайн хүнд сонсогдох чиглэсэн чанга яригч (directional speakers) Байршил: 1.1.3.2	1	Баг ц	
3.	Түүхэн сансрын станцын дотоод орчныг бодит мэт хуулбарлан хийсэн үзвэр	- Үндсэн бүтэц: р. Үзмэрийн төв хэсэгт бодит хэмжээтэй пуужингийн удирдлагын хэсэг (бүхээг) байрлана. - Интерактив удирдлага: Дээш гарах тавцан болон бодит унтраалга, товчлуур бүхий удирдлагын самбартай. - Дижитал систем: Хөлөг хөөргөх явцыг симуляци хийх болон түүхэн дүрс бичлэгүүдийг харуулах нэгдсэн дижитал дэлгэцүүдтэй.	1	Баг ц	

		- Орчны бүрдүүлэлт: Сэдэвчилсэн аудио дуугаралт болон сансрын хөлгийн доторх орчныг бүрдүүлэх тусгай гэрэлтүүлэг. Байршил: 1.5.3.3			
4.	Соронзон эвлүүлдэг хэсгүүд (тивүүд, тектоник хавтангууд, галт уулс, далайн нурууд).	Үзэгчид эдгээрийг газрын зураг дээр зөв байрлуулж тоглоно. Автоматжуулсан хариу үйлдэл: * Хавтанг зөв байрлуулмагц хавтангуудын хил хязгаарыг тодруулах LED гэрлэн арын гэрэлтүүлэг идэвхжнэ. Байршил: 2.1.2.1 Зэргэлдээх дэлгэц дээр геологийн үйл явцыг (уул үүсэх, хагарал үүсэх г.м) харуулсан богино хэмжээний анимэйшн тоглогдоно.	1	Баг ц	
5.	Малтлагын хэсэг	Элс эсвэл хайргаар дүүргэсэн, дотор нь олдворын хуулбарууд (яс, шүд, хээ дардас) нуусан малтлагын цэг. Багаж хэрэгсэл: Зөөлөн багс, хусуур, элс шигшүүр болон ажлын ширээнүүдтэй. Танин мэдэхүйн хэсэг: Олдворуудыг харьцуулан таних диаграмм бүхий том хэмжээний хана болон "илрүүлсэн" олдворуудыг нарийвчлан шинжлэх рентген гэрлийн хайрцаг (X-ray lightbox). Байршил:2.4.5.1	1	Баг ц	
6.	AR үзмэрийн суурь эко орчин	Суурин тулгуур (pedestal) дээр байрлуулсан, бат бөх хийцтэй "дуран" хэлбэрийн төхөөрөмжүүд. дуран бүр нь дижитал камертай бөгөөд дүрсийг дотор нь суурилуулсан дэлгэц дээр томруулан харуулна. Байршил:4.1.3.1	1	Баг ц	

7.	Соронзон молекул	Соронзон молекул тоглоом Байршил:5.1.2	1	Баг ц	
8.	Малтлагын орчин	Хөрсний үе давхарга (stratified layers) бүхий элс, шороотой гүнзгийрүүлсэн талбай. □ Мэргэжлийн түвшний зөөлөн багс, зориулалтын малтлагын хусуур. Малтлагын талбайг нарийвчлан бүртгэх торлосон хүрээ Олдворыг таних хэсэгт таблет эсвэл QR кодууд байрлах бөгөөд тэдгээр нь: • Тухайн олдворын 3D загвар. • Палеонтологичдын тайлбар видео руу шууд холбогдоно. Байршил:5.2.1.3	1	Баг ц	
9.	Гар аргаар угсардаг, соронзон эсвэл хоорондоо холбогддог модульчла гдсан систем.	Гар аргаар угсардаг, соронзон эсвэл хоорондоо холбогддог модульчлагдсан систем. Байршил:5.2.2.3	1	Баг ц	

10.	1,5 - 2 метр өндөртэй, босоо байрлалтай өндөр нам болдог аварга шавжны толгойн маскууд	Бат бөх, хөнгөн жинтэй FRP (Fiberglass Reinforced Plastic) буюу шилэн хөвөнгөөр хийгдсэн. Шавжны нийлмэл нүдийг төлөөлөх LED матриц дэлгэцүүдтэй бөгөөд тэдгээр нь хөдөлгөөнт дүрс (animation) харуулна Дотор талдаа орчны дуу чимээ болон шавжны жиргээг сонсгох спикерүүдтэй. Олон хүн ашиглах тул ариутгах боломжтой нүүрний хамгаалалт (face guard)-тай. Байршил: 5.2.4.2	1	Баг ц	

11.	Гавлын ясны бүтэц (Skull Alignment) үзүүллэг	1. Хазалтын хүч (Bite Force) • Технологи: Даралт мэдрэгч бүхий тохируулж болдог хөшүүргийн систем. • Үйлдэл: Хэрэглэгчид хөшүүргийг дарж өөрийн гаргаж чадах хүчийг хэмжих бөгөөд систем нь үүнийг махчин амьтдын (жишээ нь: матрын 16,000 Ньютон буюу 16 кН) хазалтын хүчтэй харьцуулж харуулна. 2. Гавлын ясны бүтэц (Skull Alignment) • Технологи: Эргэдэг суурь (pivot mount) дээр байрлуулсан гавлын ясны бодит хуулбарууд. • Үйлдэл: Хөшүүргийн механикийг ашиглан эрүүний булчингийн байрлал хазалтын хүчинд хэрхэн нөлөөлдгийг бодитоор туршиж үзнэ. • Зорилго: Махчин амьтдын богино эрүү яагаад илүү хүчтэй хаздаг болохыг физикийн үүднээс ойлгох. 3. Махчны хараа (Predator Vision) • Технологи: VR/AR толгойн төхөөрөмж эсвэл тусгай линз бүхий дуран. • Дүрслэл: Харааны талбайн нарийвчлал (binocular vision), шөнийн хараа (night vision) болон дулаан мэдрэгч (thermal imaging) хараг симуляциар үзүүлнэ. • Зорилго: Махчин амьтад олзоо хэрхэн орон зайн баримжаатайгаар "бай" болгон хардагийг мэдрэх. 4. Сонсголын систем (Hearing) • Технологи: Бинаураль (binaural) аудио станц.	1	Баг ц	

		• Үйлдэл: Чиглэсэн сонсголын симуляци ашиглан махчин амьтад (жишээ нь: шар шувуу) олзныхоо байрлалыг дууны тусламжтайгаар хэрхэн см-ийн нарийвчлалтай тогтоодогийг туршина. Байршил: 5.2.4.2			
12.	Модны анатомийн үндсэн хэсгүүдийн үзүүллэг	□ Модон материалаар хийгдсэн, Том хэмжээний (30-50 см) хэсгүүдээс бүрдэх бөгөөд модны анатомийн үндсэн хэсгүүдийг (үндэс, их биеийн цагираг, мөчир, навч) төлөөлнө. Байршил:5.2.5.2	1	Баг ц	
13.	Эрт галав болон мөхөл үзүүллэг	1. Агаар мандлын камер (Atmosphere Chamber) • Технологи: Галт уулын хийг орлох аюулгүй манан (safe fog) бүхий битүүмжилсэн шилэн сав. • Интерактив: Дотор нь байрлах pH болон агаарын чанарын мэдрэгчүүд нь "хий" нэмэгдэх үед агаарын бүтэц хэрхэн өөрчлөгдөж буйг дэлгэц дээр бодит цагт харуулна. 2. Далайн хүчиллэгжилтийн сав (Ocean Acidification Tank) • Технологи: Индикатор шингэн (өнгийг нь өөрчилдөг) бүхий далайн загвар бүхий сав. • Үйлдэл: Сав руу нүүрсхүчлийн хий (CO_2) шахахад усны хүчиллэг чанар нэмэгдэж, индикатор шингэний өнгө өөрчлөгдөнө. 3. Үнс ба Газар (Ash & Land) • Технологи: Үнсийг орлох элс болон лаавыг орлох шавраар хийсэн гар малтлагын ширээ.	1	Баг ц	

		• Үйлдэл: Үзэгчид "үнс", "лаав"-ын үе давхаргыг үүсгэж, геологийн давхарга зүйн (stratigraphy) загварыг босгоно. • Байршил: 5.2.6.3			
14.	Том хэмжээний соронзон гадаргуутай эвлүүлдэг тоглоомын ширээ.	Том хэмжээний соронзон гадаргуутай эвлүүлдэг тоглоомын ширээ. Байршил:5.2.7.2	1	Баг ц	
15.	Тектоник хавтангууд үзүүллэгийн хэсэг	(Ширээний гадаргуу): 2400мм × 1800мм (олон хүн зэрэг ашиглахад зориулсан доод хэмжээ). (Өндөр): 850мм (300мм өндөр суурь бүтцийг оролцуулаад). (Дааац): 300кг (үзэгчид дээр нь тулах болон налах үеийн ачааллыг тооцсон). (Хүрээний материал): 50×50мм хэмжээтэй, нунтаг будгаар (powder-coated) будсан, 2мм зузаантай ган төмөр хоолой. (Гадаргуугийн материал): CNC машинаар зорж гаргасан өндөр нягтралтай уретан (HDU) хөөсөнцөр, эпокси давирхай (resin) бүрхүүлтэй. (Хамгаалалтын давхарга): 12мм зузаантай, гялбааны эсрэг (anti-glare) бүрхүүл бүхий хатаасан шил. □ Number of Plates (Хавтангийн тоо): 3-4 үндсэн тектоник хавтан + 1 субдукцийн бүс (нэг хавтан нөгөөгөө доогуур орох хэсэг). • (Хэмнэлттэй): Worm gear (хорхой араа) бүхий 20:1 харьцаатай хурд сааруулагчтай гар эргүүлэг.	1	Баг ц	

		Байршил: 7.1.2.1			
16.	Галт уул үзүүллэг	(Өндөр): 2.2 метр (шалнаас галт уулын тогооны ирмэг хүртэл). (Суурийн голч): 2.4 метр. (Жин): Ойролцоогоор 400 кг. (Дотор араг яс): Ган төмөр бүтэц (25мм-ийн дөрвөлжин хоолой). (Гадна бүрхүүлийн материал): Шилэн ширхэгтээр хүчитгэсэн гипс (GRG) эсвэл полиуретан хөөс. (Гадаргуугийн бүтэц): Давирхайгаар (resin) өнгөлсөн, бодит хад чулуу мэт харагдах цутгамал. (Тогооны амсар): 500мм-ийн диаметртэй. (Лаавын суваг): Янз бүрийн налуу бүхий 3-4 суваг. Байршил: 7.1.2.1	1	Багц	
17.	Газар хөдлөлтийн хүч	(Үзүүлэлт): - 1.5×1.5м хэмжээтэй тавцан. - 300кг даац. - 0.1–10Гц давтамж. - ±150мм шилжилт (хөдөлгөөний далайц). - Байршил7.1.2.2	1	Багц	

18.	Салхи үүсгэх үзүүллэг	□ Type (Төрөл): Нээлттэй хэлхээ бүхий босоо агаарын урсгал үзүүлэх туннель. □ Test Section (Туршилтын хэсэг): 600мм × 600мм × 1200мм (өндөр) хэмжээтэй, тунгалаг акрилан харах хэсэг. □ Air Speed (Агаарын хурд): 0–25 м/с (0–56 миль/цаг) хүртэл тасралтгүй тохируулах боломжтой. □ Motor (Мотор): 3 фазын, 3кВт-ын чадалтай, давтамж хувиргагч (VFD) бүхий сойзгүй тогтмол гүйдлийн (BLDC) мотор. □ Safety (Аюулгүй байдал): Агаар сорох хэсгийн хамгаалалтын тор, яаралтай зогсоох товчлуур, нэвтрэх хаалга нээгдэх үед автомат зогсох систем. Байршил: 7.1.3.1	1	Багц	
19.	Хуй салхи үүсэг зарчим	□ Үндсэн технологи: Том хэмжээний LED эсвэл проектор дэлгэц дээрх бодит цагийн (real-time) 3D график дүрслэл. □ Гол системүүд: * Үйлдвэрийн зориулалттай DMX удирдлагатай сэнсүүд (хурд нь 5-80 км/цаг). • Долгионт (surround) дуугаралт. • Мэдрэхүйн чичиргээ дамжуулагч (rumble/tactile transducers). □ Хэрэглэгчийн интерфейс: Гэмтэл болон халдлагаас хамгаалагдсан физик хянах хэрэгслүүд (эргүүлдэг товчлуур, мэдрэгчтэй дэлгэц). □ Аюулгүй байдал: * ASTM F24 болон ADA (хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдал)-ын стандартад нийцсэн. • Хамгаалалтын хаалт бүхий эд ангиуд.	1	Багц	

		• Яаралтай зогсоох (emergency stop) товчлуурууд. Байршил7.1.3.2			
20.	Чулуулгын өгөршил үүсэх явц	Удирдах боломжтой шахуурга (насос) болон сэнс, ус цуглуулах сав, солих боломжтой 'ландшафт' (байгалийн тогтоц бүхий) тавиур болон үндсэн мэдрэгчүүдээр (цаг хэмжигч, урсгал хэмжигч) тоноглогдсон, бат бөх, тусгайлан захиалж хийлгэсэн симулятор Байршил: 7.1.1.3	1	Баг ц	
21.	Бичил ертөнц үзүүллэг	Ultra HD 4K (3840x2160) нарийвчлал – бусад системээс хоёр дахин илүү тодорхой дүрслэл Шуурхай өндөр нарийвчлалтай дүрслэл – HDMI-ээр шууд монитор буюу проекторт дамжуулна Дотоод дээд гэрэлтүүлэг – LED тусгалт эписцоп гэрэл (доод гэрэлтүүлэг нэмэлт боломжтой) Урд талын томруулалт, анхаарлын төвлөрөлт – ойлгомжтой удирдлагаар гажуудал, зөрүүгээс хамгаална Макро томруулгын хүрээ – 13-130 мм харах талбай (2x-40x томруулалт) Өндөр дээжид төвлөрөх – 3 инч хүртэл өндөр дээж дээр (4 инчийн үед бага зэргийн гэрэл бууралттай) анхаарлаа төвлөрүүлнэ Бүх утас далдлагдсан – суурилуулахад цэвэр, гажуудалд тэсвэртэй интеграци Баримтжуулах хэрэгсэл: Зарим тохиргоонууд зураг, видеог хадгалах SD карттай Лабораторийн стандартаар усны эсрэг суурь – зураас, толбо, усны эсрэг (модон суурийн хувилбараас ялгаатай)	1	Баг ц	

		Дээж баригч: Эргэдэг карусель эсвэл онцгой, аюулгүй, зөөврийн дээж баригч харилцан үйлчлэлийн үзэсгэлэнд зориулагдсан. Байршил: 2.2.4 - 5.2.1.1			
22.	Амьд организмуудыг төлөөлөх RFID/NFC технологи бүхий токенууд (таних тэмдэг) үзүүллэг	▯ Үндсэн самбар: График дүрслэл бүхий том хэмжээний ханын хавтан (1.2м x 2.4м-ээс дээш хэмжээтэй). ▯ Таних тэмдэг: Амьд организмуудыг төлөөлөх RFID/NFC технологи бүхий токенууд (таних тэмдэг). ▯ Программ хангамж: Холболтуудыг баталгаажуулж, дэлгэц дээр динамик идэш тэжээлийн хэлхээг (food web) дүрслэн харуулна. ▯ Хийцлэл: Хүүхдийн хэрэглээнд тэсвэртэй, бат бөх, аюулгүй бүтэцтэй. Байршил: 7.2.2.1	1	Баг ц	
23.	Физик хэлбэрээр хийгдсэн, интерактив загвар	▯ Биет бүтэц: Физик хэлбэрээр хийгдсэн, интерактив загвар (ойролцоогоор 1-2 метрийн хэмжээтэй). ▯ Дүрслэл: Атомын цөм (протон ба нейтрон) болон электроны бүрхүүлийг тодорхой харуулсан байна. ▯ Бүрэлдэхүүн хэсэг: Удаан эдэлгээтэй, гар хүрэхэд мэдрэгдэхүйц (tactile) эд ангиудтай: • LED гэрлээр гэрэлтдэг электронууд. • Эргэлддэг бөөмийн бөмбөлгүүд (нуклонууд). ▯ Интерфейс: Химийн элементийн мэдээллийг харах зориулалттай мэдрэгчтэй дэлгэц (touchscreen) суурилуулж болно.	1	Баг ц	

		Байршил: 7.2.1.1е			
34	Шалны тохижилт, угсралт	Бүтэц: 4D суудлын динамик ачааллыг даах хүчитгэсэн металл каркасан дээрх олон үе Шатлалт (tiered) бүтэцтэй байна. Акустик үе: Бетон болон өнгөн талбайн хооронд өндөр нягтралтай резинэн жийргэвч (Vibration Isolation Pad) угсрах Өнгөлгөө: Зориулалтын галд	м.кв	268	

		тэсвэртэй (Class B1), элэгдэлд тэсвэртэй Акустик хивсэнцэр эсвэл LVT (Luxury Vinyl Tile) хавтан. Өнгө: Гэрэл ойлгохгүй матт бараан (Dark charcoal/Black). Кабель менежмент: Шалны доор суудлын хүчдэлийн ба дата кабелийг дамжуулах 100x100мм хэмжээтэй ган суваг (Cable Tray) болон суудлын хөл бүрт кабель гаргах нүхнүүдийг төлөвлөнө. Аюулгүй байдал: Шатны ирмэг бүрт үзэгчдийн аюулгүй байдлыг хангах, бага хүчдэлийн (12V/24V) LED гэрэлтүүлэг бүхий хөнгөн цагаан профиль (Stair nosing) суулгана.			
35	Гэрэлтүүлгийн систем	Заалны ерөнхий гэрэлтүүлэг: Өндөр зэрэглэлийн Dimmable LED Downlight. Аюулгүй байдлын гэрэлтүүлэг: Шатны ирмэг болон зорчих хэсэгт суурилуулсан Low-voltage LED Profile. Аваарын системтэй (Emergency backup) холбогдсон байна. Ханын акцент гэрэл: Хананд суурилуулсан RGBW LED Strips. Удирдлагын систем:	иж	1	

		DMX512 эсвэл DALI протоколоор ажиллах нэгдсэн удирдлагын пульт. Контенттой (Show controller) синхрончлогдож, автоматаар ажиллах боломжтой байна.			

“4K ЛАЗЕР ПРОЕКТОР”- ЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Ерөнхий шаардлага	360° дом проекцийн системд зориулагдсан, олон сувгийн (multi-channel) дүрс гаргах чадвартай мэргэжлийн лазер проектор.
2	Гэрлийн эх үүсвэр	RGB Pure Laser (Red, Green, Blue тусдаа лазер эх үүсвэртэй). 20,000 ANSI lumen-ээс багагүй. (ISO/IEC 21118 стандарт хангасан байна.)
3	Өнгөний гаралт	Rec. 2020 өнгөний стандартыг ≥95% хангах. Auto Color Calibration системтэй байх.
4	Нягтаршил	4K UHD (3840 x 2160). Aspect Ratio: 16:9 эсвэл 16:10.
5	Технологи	3-Chip DLP™ RGB Laser
6	Дүрсийн чанар	Contrast ratio: 2,000:1 (Native) - 5,000:1 (Native) ба түүнээс дээш. 12-bit өнгөний гүн дэмждэг байх.
7	Нийлэмж (Integration)	Black Level Adjustment болон Color Matching функцтэй байна. (Энэ нь проекторын уулзвар хэсэгт хар өнгө болон бусад өнгийг ялгаралгүй ижилсүүлэхэд ашиглагдана.)
8	Сүлжээ ба удирдлага	HDBaseT, LAN (RJ45), RS-232C удирдлагатай. LAN/Web Control-оор дамжуулан алсаас асааж/унтраах, төлөв хянах SNMP болон PJLink дэмжих боломжтой байна.
9	Ажиллах горим	Дом театрын онцлогт тохирсон 360° Orientation (ямар ч өнцгөөр суурилуулж болох) болон 24/7 тасралтгүй ажиллагааны горимтой байна.
10	Хөргөлт ба дуу чимээ	RGB Лазерт зориулсан дотоод шингэн хөргөлтийн систем (Integrated Liquid Cooling). Дуу чимээ ≤45dB.
11	Жигд байдал	Дэлгэцийн нийт талбайн гэрэлтүүлгийн жигд байдал (Brightness Uniformity) нь 90%-иас багагүй байна.
12	Холболт	HDMI 2.1, DisplayPort 1.4, QSFP+ (Fiber) эсвэл 12G-SDI. 4K/60Hz-120Hz дэмждэг байх.
13	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥5 жил эсвэл ≥20,000 цаг.
14	Стандарт	IEC 60950-1/62368-1 (Аюулгүй байдал), EN 55032/55035 (EMC), RoHS, CE Marking, ISO 9001 чанарын стандарттай байна.

ПРОЕКТОРЫН ЛИНЗНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Зориулалт	Бэхэлгээний систем нь 8 проекторын дүрсийг заадасгүй нийлүүлж, дүрсийг тогтвортой хадгалах гол үүрэгтэй.
2	Системийн төрөл	Dome театрын 8 сувгийн (multi-channel) системд зориулагдсан, 4K Resolution Support (нягтаршил дэмжих) өндөр чанарын оптик линз.
3	Оптик чанар (MTF)	Бөмбөгөр гадаргуугийн төвөөс ирмэг хүртэл дүрсний тод байдлыг хадгалах High Modulation Transfer Function (MTF) үзүүлэлттэй байна.
4	Фокус ба Гүн (Focus)	Deep Focus буюу бөмбөгөр гадаргуугийн бүх цэгт дүрсийг жигд фокуслах чадвартай (Large Depth of Field) байна.
5	Шидэлтийн харьцаа	12 метрийн дэлгэцэнд 8 проектороор бүтэн бүрхэлт үүсгэхэд тохиромжтой Wide-angle (ойрын зайн) линз байна. /Нийлүүлэгч тал Optical Throw Calculation тооцооллыг ирүүлнэ/.
6	Дижитал тохируулга	Проекторын их биеэс алсаас удирдах Powered Zoom, Powered Focus болон Powered Lens Shift (хэвтээ ба босоо чиглэлд шилжих) функцтэй байна.
7	Геометр гажуудал	Бөмбөгөр дэлгэц дээрх дүрсийн уулзваруудыг (Edge Blending) нарийн нийлүүлэхэд зориулагдсан Low TV Distortion (<1%) буюу гажуудал багатай байна.
8	Гэрэл нэвтрүүлэлт	Гэрлийн алдагдлыг багасгаж, контрастыг нэмэгдүүлэх олон үе шат бүхий Anti-reflective (AR) coating бүрэлттэй байна.
9	Механик шинж чанар	20,000 ANSI lumen лазер проекторын өндөр дулаанд тэсвэртэй, бэхэлгээний бат бөх хийцтэй (Жин: 5-10 кг орчим).
10	Нийцэл	Сонгосон проекторын брэнд, загварт зориулагдсан үйлдвэрлэгчийн баталгаат эх линз байна.
11	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил (Оптик гэмтэл, гажуудалгүй байх).

ПРОЕКТОР СУУРИЛУУЛАХ НАРИЙН ТОХИРУУЛГЫН БЭХЭЛГЭЭ (Precision Bracket)-НИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Хийцлэл	Проектор суурилуулах хүнд даацын зориулалттай, 20,000 ANSI lumen лазер проекторын өндөр дулаанд тэсвэртэй ган эсвэл хөнгөн цагаан хайлш хийцтэй байна.
2	Даац	Проектор болон линзний нийт жин болох ≥200 кг ачааллыг 5:1 аюулгүй байдлын коэффициенттэйгээр (Safety factor) бүрэн даах чадвартай байна.
3	Системийн төрөл	Dome театрын 8 сувгийн (multi-channel) системд зориулагдсан, 4K Resolution Support (нягтаршил дэмжих) өндөр чанарын оптик линз.
4	Оптик чанар (MTF)	Бөмбөгөр гадаргуугийн төвөөс ирмэг хүртэл дүрсний тод байдлыг хадгалах High Modulation Transfer Function (MTF) үзүүлэлттэй байна.
5	Фокус ба Гүн (Focus)	Deep Focus буюу бөмбөгөр гадаргуугийн бүх цэгт дүрсийг жигд фокуслах чадвартай (Large Depth of Field) байна.
6	Шидэлтийн харьцаа	12 метрийн дэлгэцэнд 8 проектороор бүтэн бүрхэлт үүсгэхэд тохиромжтой Wide-angle (ойрын зайн) линз байна. (Нийлүүлэгч тал Optical Throw Calculation тооцооллыг ирүүлнэ).
7	Дижитал тохируулга	X, Y, Z тэнхлэгийн дагуу Micro-adjustment (нарийн араат тохируулга) хийх боломжтой байна. Tilt (±20°), Roll (±10°), болон Yaw (±20°) тохируулгыг түгжих (locking) механизмаар тоноглосон байна.
8	Геометр гажуудал	Бөмбөгөр дэлгэц дээрх дүрсийн уулзваруудыг (Edge Blending) нарийн нийлүүлэхэд зориулагдсан Low TV Distortion (<1%) буюу гажуудал багатай байна.
9	Гэрэл нэвтрүүлэлт	Гэрлийн алдагдлыг багасгаж, контрастыг нэмэгдүүлэх олон үе шат бүхий Anti-reflective (AR) coating бүрэлттэй байна.
10	Тогтвортой байдал	Чичиргээ, гулсалт үүсгэхгүй байх ба тохируулсан байрлалаа урт хугацаанд тогтвортой хадгалах механик хийцтэй байна.
11	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил
12	Стандарт	NFPA 13/101, EN 13501, B1/M1 (Галд тэсвэртэй), IEC 60364, ISO 9227 (Зэврэлтэд тэсвэртэй) стандартуудыг хангасан байна.

МЕДИА СЕРВЕР/ДҮРС БОЛОВСРУУЛАХ СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Процессор (CPU)	Intel Xeon Scalable эсвэл Intel Core i9 (Latest Gen), 16-core / 32-threads-ээс багагүй хүчин чадалтай.
2	График систем (GPU)	2 x NVIDIA RTX A5000 эсвэл 1 x NVIDIA RTX 6000 Ada. 8 сувгийн 4K/60Hz дүрсийг боловсруулах 32GB-аас багагүй VRAM-тай байна.
3	Техник синхрончлол	NVIDIA Quadro Sync II карт суурилуулсан байна. 8 гаралтын кадрыг (Frame-lock/Genlock) SMPTE стандартын дагуу миллисекундын зөрүүгүй синхрончилж, дүрс урагдах (tearing)-ыг бүрэн арилгана.
4	Интерфэйсүүд	8 x DisplayPort 1.4 болон HDMI 2.1 портуудтай байна. Өгөгдөл дамжуулах 10GbE сүлжээний порттой байна.
5	Өнгө ба Дүрс	Дүрсийн өнгө боловсруулалт нь ISO 3664 стандартыг хангасан байна. Автомат калибровк хийх камерын систем нь ISO 12232 стандартын дагуу гэрэл мэдрэх чадвартай байна.
6	Программ хангамж	8 сувгийн Warping & Blending лиценз багтсан байна. Олон сувгийн дүрсийг заадасгүй нийлүүлэх автомат калибровкын системтэй нийцдэг байна.
7	Хадгалах сан	2TB NVMe SSD (Gen4) - Өндөр нягтаршилтай видео контентыг маш хурдтай унших зориулалттай.
8	Аюулгүй ажиллагаа	Main болон Backup системүүд нь “Heartbeat” синхрончлолтой байх ба үндсэн системд алдаа гарсан тохиолдолд нөөц систем рүү 10 секундээс ихгүй хугацаанд автоматаар шилжиж, шоу болон контентын тасалдал үүсгэхгүй ажиллах боломжтой байна.
9	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил

БӨМБӨГӨР ДЭЛГЭЦИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Системийн хэлбэр	360° Dome театрт зориулагдсан, 12м диаметртэй, хагас бөмбөрцөг (Hemisphere) хэлбэрийн өөрөө даагч систем байна.
2	Материал ба хийц	Өндөр чанарын хөнгөн цагаан хайлш бүхий хатуу хавтангууд байна. Хавтангууд нь дууны долгион нэвтрүүлэх микро нүхжилттэй (Perforated Aluminum) байна.
3	Оптик шинж чанар	Гэрэл ойлголтын коэффициент (Gain) 0.3–0.5 байна. Энэ нь олон проекторын гэрлийн давхцал болон дотоод сөрөг ойлтоос (Cross-reflection) бүрэн сэргийлсэн байна.
4	Нүхжилтийн стандарт	Нүхжилтийн диаметр 1.0-1.5мм, нийт талбайн нүхжилтийн харьцаа (Open area) 22%-25% байна. (Дууны чанарыг дэлгэцээр чөлөөтэй нэвтрүүлэхээр байна).
5	Угсралтын технологи	Хавтангуудыг "Seamless Overlap" технологиор заадасгүй холбож, дүрсийн нэгдмэл байдлыг алдагдуулахгүй цул гадаргуу үүсгэнэ.
6	Гал тэсвэрлэлт	Олон улсын барилгын аюулгүй байдлын А1 зэрэглэлийн галд тэсвэртэй стандарт хангасан байна.
7	Тусгай /Суурилуулалт ба ашиглалт/	Дэлгэцийн болон каркас бүтцийг үйлдвэрлэгчийн баталгаат инженерийн хяналтан дор (Supervision), инженерийн зураг төслийн дагуу (Shop drawing) газар дээр нь иж бүрэн угсарч, оптик тохируулга хийж, ашиглалтад бэлэн болгон "Түлхүүр гардуулах" (Turn-key) нөхцөлөөр хүлээлгэн өгнө.
8	Баталгаа	Баталгаа: ≥5 жил (Гадаргуугийн өнгө алдалт, деформацигүй байх).

БӨМБӨГӨР ДЭЛГЭЦИЙН АРАГ /КАРКАС/-ЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Каркасны хийцлэл	12м диаметртэй, 15°-20° налуутай (tilted), өөрөө өөрийгөө даах чадвартай Геодезийн (Гурвалжин сүлжээт) бүтэцтэй байна.
2	Материал	Бүтцийн үндсэн элементүүд нь бат бөх хөнгөн цагаан хайлш (6061-T6) эсвэл барилгын даацын ган (Q345/S355) материалаар хийгдсэн байна.
3	Техникийн орон зай	Дэлгэцийн хавтан болон үндсэн хананы хооронд 40-60 см зай (Technical Gallery) үлдээж, засвар үйлчилгээ болон аудио систем байрлуулах боломжийг хангасан байна.
4	Даац	Нийт даац (Static Load) Каркас нь дэлгэцийн хавтан, 18 ширхэг чанга яригч, 8 проектор болон бусад тоноглолын нийт ≥2,500 кг (2.5 тонн) статик ачааллыг 5:1 аюулгүй байдлын коэффициенттэйгээр даах чадвартай байна.
5	Акустик	Чанга яригчаас гарах чичиргээг дэлгэцэнд дамжуулахгүй (Anti-vibration mounts) резинэн жийргэвчтэй байна.
6	Гадаргуугийн бүрээс	Металл гадаргуу нь зэврэлтээс хамгаалагдсан, гэрэл ойлгохгүй матт хар өнгийн Powder Coating (нунтаг будаг) бүрээстэй байна.
7	Тусгай /суурилуулалт/	Каркасны бүтцийн статик болон динамик ачааллын тооцооны тайланг (Structural Analysis Report) угсралтын өмнө танилцуулан Turn-key (Түлхүүр гардуулах) нөхцөлөөр, үйлдвэрлэгчийн баталгаат инженерийн хяналтан дор иж бүрэн угсарч хүлээлгэн өгнө.
8	Баталгаа	Үлйвэрлэгчийн баталгаа: ≥10 жил (Статик бат бөх чанар).
9	Стандарт	Олон улсын A1 / B1 / M1 (Гал тэсвэрлэлт) болон ISO 9227 (Зэврэлтэд тэсвэртэй) стандартуудыг бүрэн хангасан байна.

ЧАНГА ЯРИГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
Дууны хүрээллийн чанга яригч (Surround Speakers)		
1	Зориулалт	Дом театрын дэлгэцийн ард (Behind-the-screen) байрлахад зориулагдсан, 2 замын (2-way) мэргэжлийн чанга яригч.
2	Акустик	Хөнгөн цагаан нүхжилттэй дэлгэцээр дамжих дууны алдагдлыг нөхөх чадвартай, өндөр давтамжийн (HF) тохируулгатай байна.
3	Бэхэлгээ	Каркас дээр бэхлэгдэх зориулалтын U-bracket эсвэл олон өнцгөөр эргэх бэхэлгээтэй байна.
4	Чадал	300W RMS-ээс багагүй. SPL (Дууны даралтын түвшин): ≥120 dB.
5	Холболт	Мэргэжлийн Speakon (NL4) эсвэл terminal block холболттой.
6	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: 3 жил.
Бага давтамжийн чанга яригч (Subwoofer)		
9	Зориулалт	Кино болон шоуны эффект (LFE - Low Frequency Effects) гаргах зориулалттай, хүнд даацын subwoofer.
10	Драйвер	18 инч (45.72 см) ба түүнээс дээш диаметртэй, халуунд тэсвэртэй voice coil бүхий драйвертай.
11	Чадал	1000W RMS (эсвэл 2000W Peak) ба түүнээс дээш.
12	Давтамж	Доод хязгаар 35 Hz-ээс бага байх (Жишээ нь: 25Hz - 150Hz).
13	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил
14	Стандарт	ISO 3382 стандартын дагуу бөмбөгөр танхимын цуурайг тооцоолсон байршилд суурилуулна.

АУДИО ДИЖИТАЛ ДОХИО БОЛОВСРУУЛАГЧ ПРОЦЕССОР (DSP)-ЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
Аудио дижитал дохио боловсруулагч процессор		
1	Оролт/Гаралт	16 x 16 эсвэл 32 x 32 суваг бүхий өндөр нягтаршилтай дижитал боловсруулалттай байна.
2	Дижитал Протокол	Медиа серверээс аудиог алдагдалгүй, шуугиангүй хүлээн авах Dante эсвэл AES/EBU дижитал оролттой байна.
3	Акустик менежмент	Loudspeaker Management System: Спикер бүр дээр тусгаарласан Delay (хоцролт), Parametric EQ (эквалайзер), Crossover болон Limiter тохируулах боломжтой байна.
4	Боловсруулах чадал	40-bit Floating Point DSP боловсруулалттай. Хэрэглэгчийн график интерфэйс (GUI) ашиглан зайнаас удирдах боломжтой байна.
5	Аудио чанар	Давтамжийн зурвас: 20Hz – 20kHz (±0.5dB). Динамик цар хүрээ: ≥110dB.
	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: 2 жил.
6	Холбогдох Стандарт	IEC 60065 (Аюулгүй ажиллагаа), EN 55032 (Цахилгаан соронзон нийцэл), AES67 (Дижитал аудио сүлжээний харилцан ажиллагаа).
Аудио чадлын өсгөгч (Power Amplifier)		
7	Сувгийн тоо	Нийт сувгийн тоо 18-аас багагүй байна. (Жишээ нь: 5-6 ширхэг 4-сувгийн өсгөгч ашиглан 20-24 сувгийн нөөц бүрдүүлнэ).
8	Чадлын үзүүлэлт	Суваг бүр ≥300W (8 Ohms) чадалтай. Subwoofer-д зориулсан өсгөгч нь Bridge mode дэмждэг, бага давтамжийн өндөр ачаалал даах чадвартай байна.
9	Хөргөлтийн систем	Хэт халалтаас хамгаалсан автомат сэнсэн хөргөлттэй, 24/7 тасралтгүй ажиллагааны горимтой байна.
10	Холболтын төрөл	Оролт: XLR / Terminal block. Гаралт: Speakon эсвэл мэргэжлийн шурагт холболттой байна.
11	Хамгаалалт	DC fault, Short circuit, Thermal protection болон Soft start системээр тоноглогдсон байна.
12	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил.
13	Холбогдох Стандарт	CE, RoHS, Energy Star (Цахилгаан зарцуулалтын хэмнэлттэй), IEC 62368-1 (Мэдээлэл, аудио/видео төхөөрөмжийн аюулгүй байдал).

ДҮРСНИЙ УДИРДЛАГА, ХЯНАЛТ БА АВТОМАТ ТОХИРУУЛГЫН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
Дүрсний удирдлага хяналт ба автомат тохируулгын систем		
1	Программ хангамж	360° бөмбөгөр проекцийн системд зориулсан, 8-аас багагүй сувгийн дүрс боловсруулах, Warping, Edge blending болон медиа тоглуулах цогц лиценз байна.
2	Автомат тохируулга	Систем нь дүрсийг камер ашиглан автоматаар тохируулна. Проекторуудын геометрийн зөрүүг 0.5 пикселээс бага нарийвчлалтайгаар нийлүүлэх чадвартай байна.
3	Камерын иж бүрдэл	Industrial Grade Calibration Camera: Өндөр нягтаршилтай (4K UHD), Fisheye линзтэй, Dome-ийн нийт талбайг нэг цэгээс харах чадвартай камер, бэхэлгээ, кабелийн хамт байна.
4	Дүрсийн удирдлага	Advanced Black Level Management: Олон проектор давхцаж буй хэсгийн хар өнгөний түвшинг автоматаар тохируулж, дүрсийг ялгаралгүй цул харагдуулах функцтэй байна.
5	Синхрончлол	Үндсэн (Main) болон нөөц (Backup) серверүүдийг Frame-level түвшинд синхрончлох болон алсаас удирдах (Show Control) функцтэй байна.
6	Стандарт ба Эрх	SMPTE таймкод болон олон улсын дүрс бичлэгийн стандартыг дэмжинэ. Лиценз нь үйлдвэрлэгчийн албан ёсны, хугацаагүй (Perpetual) байна.
7	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил (Лиценз болон мэдрэгч).
Олон сервер удирдах төхөөрөмж — KVM Switch		
7	Портын тоо	16-аас багагүй порттой байна (ирээдүйд сервер нэмэх нөөцтэй).
8	Алсын хандалт	KVM over IP: Сүлжээгээр дамжуулан BIOS түвшний удирдлага хийх боломжтой байна.
9	Холболт	Компьютер тус бүрд залгах Dongle (DisplayPort/USB эсвэл HDMI/USB) багцтай байна.
10	Дэлгэцийн чанар	Видео нягтаршил: 1920x1200 @ 60Hz-ээс багагүй (4K дэмждэг бол давуу тал).
11	Аюулгүй байдал	Олон түвшний хэрэглэгчийн эрх, IP/MAC filtering, SSL 128-bit encryption-тэй байна.
12	Дагалдах хэрэгсэл	Rack-mount LCD Console (монитор, гар, хулгана) багтсан байна.

13	Баталгаа	Баталгаа: ≥2 жил

ДҮРСНИЙ УДИРДЛАГА, ХЯНАЛТ БА АВТОМАТ ТОХИРУУЛГЫН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
Нэгдсэн удирдлагын компьютер		
1	Үйлдлийн систем	Сүүлийн үеийн (14-р үеэс хойшхи) Intel Core i7/i9 эсвэл Xeon W процессортой байна. Олон даалгаврыг зэрэг гүйцэтгэхэд зориулагдсан ≥12 цөмтэй байна.
2	Санах ойн багтаамж	Системийн тогтвортой байдлыг хангах үүднээс ≥64GB RAM-тай байна. Өгөгдөл унших хурд нь өндөр байх (NVMe SSD).
3	График карт	NVIDIA RTX цувралын (≥8GB VRAM) график карттай байна. Хос 4K мониторыг 60Hz давтамжтай сааталгүй гаргах чадвартай.
4	Сүлжээний холболт	2-оос багагүй 1GbE/10GbE LAN порттой байна.
5	Дэлгэцийн систем	2 ширхэг 27-инчийн 4K монитор. IPS панелтай, өнгөний нарийвчлал сайтай, нүд ядраахгүй (Flicker-free) технологитой байна.
6	Программ хангамж	Windows 10/11 Pro (64-bit) албан ёсны лицензтэй. Антивирус болон системийн оношлогооны программтай байна.
7	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил.
Театрын системийн удирдлагын дэлгэц		
7	Системийн төрөл	Дом театрын автоматжуулалтын системийг (AV Automation) зайнаас болон нэгдсэн байдлаар удирдах зориулалттай зөөврийн эсвэл суурин Touch Control Panel байна.
8	Дэлгэцийн үзүүлэлт	10-12.9 инч, өндөр нягтаршилтай (Retina/OLED), олон цэгт мэдрэгч (Multi-touch) дэмждэг, гэрэлтүүлэг өндөртэй байна.
9	Программ хангамж ба GUI	Проекторыг асаах/унтраах, аудио түвшин тохируулах, медиа тоглуулагчийг удирдах (Play/Pause/Skip), гэрэлтүүлэг зохицуулах тусгайлан бэлтгэсэн GUI (Graphic User Interface)-тэй байна.
10	Холболт ба Сүлжээ	Wi-Fi 6 болон Bluetooth дэмждэг, удирдлагын сервертэй (Show Control PC) тасралтгүй холбогдож, хоцрогдолгүй (low latency) ажиллах чадвартай байна.
11	Найдвартай байдал	Операторын өрөөнд байрлах зориулалтын Цэнэглэгч суурь (Docking station) болон уналтаас хамгаалсан Хамгаалалтын гэр (Rugged case)-ийн хамт байх.

12	Процессор ба батарей	Хүнд программ хангамж ажиллахад зориулагдсан өндөр хурдны чипсеттэй, цэнэгээ 10-аас багагүй цаг барих чадалтай байна.
13	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил.

СҮЛЖЭЭ, ХОЛБОЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
Кабель, сүлжээ, холболтын иж бүрдэл		
1	Видео холболт (Fiber Optic)	8 проекторыг сервертэй холбох Active Optical Cable (AOC) HDMI 2.1 эсвэл DisplayPort 1.4 Fiber кабелиуд байна. Кабель бүр 4K/60Hz, 18Gbps-аас багагүй зурвасын өргөнийг 50 метр хүртэл зайд ямар нэгэн дохионы саатал, алдагдалгүй дамжуулах чадвартай байна.
2	Аудио холболт (High-Fidelity)	18 чанга яригчийн (14+4) холболтод зориулсан 12 AWG (3.3mm²) огтлолтой, 99.9% хүчилтөрөгчгүй цэвэр зэс (OFC) кабель байна. Өсгөгч болон процессор хооронд хөндлөнгийн шуугианаас хамгаалагдсан Noise-shielded Balanced XLR кабелиуд байна.
3	Сүлжээний дэд бүтэц	Системийн хяналт болон удирдлагад зориулсан Layer 3 Managed Gigabit Switch (24-өөс багагүй порттой) байна. Төхөөрөмжүүдийг холбох сүлжээний кабель нь Cat6A S/FTP (Double Shielded) стандартын байна.
4	Хамгаалалт ба Аюулгүй байдал	Бүх төрлийн кабелиуд нь олон нийтийн газарт тавигдах галын аюулгүй байдлын шаардлага хангасан, утаа бага ялгаруулдаг, галд тэсвэртэй (LSZH бүрээстэй) байна.
5	Тусгай /Инженерчлэл ба Тооцоолол/	Барилгын зураг төсөлд суурилсан, дохионы алдагдал үүсэхгүй байх хамгийн оновчтой трасс болон кабелийн уртыг нарийвчлан тооцно. Холболтын хэсгүүд шошготой, цэгцтэй байна.
6	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥1 жил (Холболтын найдвартай байдал).
Серверийн шүүгээ		
7	Хэмжээ ба багтаамж	Өндөр 42U (~2000 мм), Өргөн 600-800 мм, Гүн 1000-1100 мм байна. Стандарт 19 инчийн хүрээ (Rails)-тэй байна.
8	Хийц ба Материал	Өндөр зэрэглэлийн хүйтнээр цувисан ган металл хийцтэй байна. Өнгө нь хар (Powder coated) байна.
9	Агаарын солилцоо	Урд болон хойд хаалга нь агаарын чөлөөтэй урсгал (Airflow) хангах High-perforation (80%+ торон) хийцтэй эсвэл хөргөлтийн хэрэгцээнд нийцсэн шилэн/металл хосолсон цоожтой хаалгатай байна.
10	Даацын чадал	Хүнд даацын сервер болон тасралтгүй тэжээлийн төхөөрөмжүүдийг (UPS) найдвартай даах Static load ≥ 1200 кг байна.

11	Кабель зохион байгуулалт	Шүүгээн доторх кабелиудыг цэгцлэх босоо болон хэвтээ Cable Management суваг, нүхнүүдтэй байна. Кабелийг нэвтрүүлэх хэсгүүд нь резинэн хамгаалалттай байна.
12	Дагалдах хэрэгсэл	Зөөвөрлөх дугуй болон тогтворжуулагч хөл (Leveling feet), хажуугийн салдаг хавтан (Side panels), газардуулгын иж бүрдэл болон PDU (Цахилгаан түгээгч) бэхлэх боломжтой байна.
13	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥5 жил

ОРЧНЫ ХЯНАЛТ БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
Нарийвчлалтай хөргөлтийн систем		
1	Системийн төрөл	Дата төв болон серверийн өрөөний зориулалттай, 24/7/365 тасралтгүй ажиллах горимтой Precision Air Conditioning (PAC) систем байна.
2	Хөргөх чадал	≥20 кВт (Sensible Cooling)-аас багагүй байна. Температурыг ±1°C, харьцангуй чийгшлийг ±5% нарийвчлалтай тогтмол барих (Dehumidification/Humidification) чадвартай байна.
3	Компрессор	Эрчим хүчний хэмнэлттэй, ачааллаас хамаарч эргэлтийн хурдаа тохируулдаг DC Inverter технологийн компрессортой байна.
4	Агаарын урсгал	Доороос (Underfloor) эсвэл урдаас (Front-discharge) үлээх сонголттой байна. Агаар шүүгч нь EU4/G4 ангиллын олон улсын стандарт хангасан байна.
5	Хяналт ба Удирдлага	Ухаалаг хяналтын самбартай байх ба сүлжээгээр зайнаас хянах (SNMP/Modbus) порттой байна. Температур, чийгшил, шүүлтүүрийн бохирдол болон ус алдалтыг мэдрэх мэдрэгчүүдээр тоноглогдсон байна.
6	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил
Гал унтраах автомат систем		
7	Системийн төрөл	Автомат ажиллагаатай Clean Agent (FM-200 / HFC-227ea) хийн гал унтраах систем байна. Гал унтраасны дараа тоног төхөөрөмжид ямар нэгэн үлдэгдэл, чийг, тунадас үлдээдэггүй байна.
8	Ажиллагааны горим	Хос мэдрэгчтэй (Smoke + Heat) логик системтэй байна. Хоёр мэдрэгч зэрэг идэвхжсэн үед хийг 10 секундийн

		дотор гадагшлуулж, тоног төхөөрөмжийн тэжээлийг автоматаар таслах (Interlock) холболттой байна.
9	Баллон ба Хий	Даралтын хэмжүүр (Pressure gauge), цахилгаан клапан (Solenoid valve) бүхий UL/FM зөвшөөрөлтэй баллон байна. Хийн хэмжээг серверийн өрөөний эзэлхүүнд (m^3) тохируулан NFPA 2001 стандартын дагуу тооцож нийлүүлнэ.
10	Хяналтын самбар	Гал унтраах системийн тусгайлсан хяналтын самбар (Fire Control Panel) байна. Барилгын нэгдсэн галын дохиоллын системтэй холбогдох (Interface) боломжтой байна.
11	Нэмэлт хэрэгсэл	Гараар ажиллуулах товч (Manual release), түр зогсоох товч (Abort switch), хий гадагшлахыг анхааруулах гэрлэн болон дуут дохиоллын иж бүрдэлтэй байна.
12	Интеграцчилал	Гал илэрсэн үед Нарийвчлалтай хөргөлтийн систем (PAC)-ийг автоматаар унтраах гинжин хэлхээний холболттой байна.
13	Стандарт	NFPA 2001 (Clean Agent), ISO 14520 стандартуудыг бүрэн хангасан байна. Нийлүүлэгч нь өрөөний битүүмжлэлийн тест (Room Integrity Test)-ийг гүйцэтгэнэ.
14	Тусгай /суурилуулалт/	Гал унтраах системийг угсрахдаа өрөөний битүүмжлэлийг бүрэн хариуцаж, NFPA 2001 стандартын дагуу Room Integrity Test-ийг гүйцэтгэж, тайланг хүлээлгэж өгнө. Систем нь хөргөлт болон нэвтрэх хяналтын системтэй программчлалын түвшинд холбогдсон байна.
15	Баталгаа	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил (Цэнэглэлт болон мэдрэгч).

ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	**Шалгуур**	**Техникийн шаардлага**
Хүлээлгийн суудал		
1	Загвар	Олон нийтийн хүлээлгийн танхимд зориулагдсан, модуль (S-curve) загвартай. Үзэгчид хоёр талаас нь зэрэг суух боломжтой, ирмэгүүд нь дугуйрсан эргономик шийдэл бүхий иж бүрдэл.
2	Дүүргэлт	Өндөр нягтаршилтай, суулт өгдөггүй цутгамал PU (Polyurethane) хөөсөнцөр дүүргэгчтэй. Галд тэсвэртэй байдлын EN 1021-1/2 эсвэл BS 5852 стандартыг бүрэн хангасан байна.

3	Үндсэн каркас	Дотор каркас нь ачаалал даах чадвартай бат бөх ган (Steel) эсвэл хатуу модон (Plywood/Solid wood) хийцтэй байна.
4	Суудлын хөл	Зэвэрдэггүй ган эсвэл зураас, чийгэнд тэсвэртэй нунтаг будгаар будсан ган хөлтэй. Шал зурахаас хамгаалсан, дуу чимээ гаргахгүй резинэн ултай (Glides) байна.
5	Бүрээсний материал	Зориулалтын өндөр чанарын текстиль (нэхмэл даавуу) эсвэл хиймэл арьс. Текстиль нь чийгтэй цэвэрлэгээ хийх боломжтой, хир толбо тогтдоггүй (Stain-resistant) түрхлэгтэй байна.
6	Эдэлгээний стандарт	Бүрээсний элэгдэл тэсвэрлэх чадвар: ≥50,000 Martindale байх.
7	Техникийн үзүүлэлт	Нэг суудлын даац: ≥120 кг. Модулиуд нь хоорондоо тусгай түгжээгээр холбогддог, салж нийлэх боломжтой байна.
8	Хэмжээ	Нийт урт (7 модуль): 3500 – 4500 мм - Суудлын өндөр: 420 – 450 мм - Нэг суудлын өргөн: ≥600 мм
9	Стандарт	EN 16139 (Нийтийн тавилгын аюулгүй байдал), MNS EN 16139, ISO 9001.
10	Баталгаат хугацаа:	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН СУУДЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/Д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Зориулалт	Дом театр бөмбөгөр дэлгэцийн дээвэр рүү харах өнцөг бүхий тусгай зориулалтын суудал байна.
2	Түшлэгийн налуу (Recline)	Суудлын түшлэгийн налуугийн өнцөг нь байрлалаас хамааран 45°-аас 50° градус байна.
3	Автомат хураагуур	Үзэгч босох үед суудал нь автоматаар дээш хураагддаг (Gravity return mechanism) байна.
4	Толгойн тулгуур	Дээшээ харж видео үзэхэд хүзүүний булчинг амраах зориулалттай, эргономик зөөлөвч бүхий өндөр түшлэг (Headrest)-тэй байна.
5	Тохойвч (Armrest)	Тохойвч нь цэвэрхэн загвартай, зөөлөвчтэй эсвэл өндөр чанарын полипропилен материалаар хийгдсэн байна.

6	Механизмын ажиллагаа	Суудал налах болон хураагдах механизм нь ямар нэгэн механик дуу чимээ гаргадаггүй (Silent movement system) байна.
7	Материал (Бүрээс)	Олон улсын галын аюулгүй байдлын BS 5852 эсвэл GB 8624 (Class B1) стандарт хангасан, галд тэсвэртэй, элэгдэлд тэсвэртэй даавуун бүрээстэй байна.
8	Дотор зөөлөвч	Өндөр нягтаршилтай цутгамал хөөсөнцөр (Molded PU foam) байна. Нягтаршил: ≥45 кг/м³.
9	Загвар	Орчин үеийн дизайнтай, театрын дотоод засалтай зохицсон өнгө, хэлбэртэй байх./захиалагчтай зөвшилцөх/
10	Бэхэлгээ ба бүтээц	Суудлын дотор араг нь ган хийцтэй, шаланд 2-оос багагүй цэгээр найдвартай бэхлэгддэг байна.
11	Тэмдэглэгээ	Суудлын болон эгнээний дугаарлалт харанхуй орчинд харагдахуйц (Luminous numbers) байна.
12	Баталгаат хугацаа:	Үйлдвэрлэгчийн баталгаа: ≥5жил

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

ATA12932 6594204 9024070546

18. ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН КАСТ, МОДЕЛЬ, ҮЗМЭР ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Агуулга	Тавигдах шаардлага
1	Барааны нэр, байршил, хүчин чадал	- Бараа нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей" үзүүллэг дэглэлтэд үлэг гүрвэлийн каст, модель, үзмэр, цуглуулга худалдан авах - Байршил: • А блок- 2 дугаар давхар, 2 дугаар танхим (геологи); • Б блок- 1 дүгээр давхар, 6 дугаар танхим (Хүний үүсэл, хөгжил); • Б блок- 2 дугаар давхар, 4 дүгээр танхим (Биологи); • В блок 1 дүгээр давхар, 5 дугаар танхим (Амьдралын үүсэл, хувьсал); - Хүчин чадал: • В блок- Амьдралын үүсэл, хувьсал танхимд: • Шинээр хийлгэх хэв хуулбар; • Үлэг гүрвэлийн модел хөдөлгөөнгүй загварууд; • Б блок-Биологийн танхимд: • Монгол орны ховор, эндимик /унаган ургамал/-ын модель; • Геологийн танхимд: • Нүүрс олборлолт харуусан макет; • Хүний үүслийн танхимд: • Эртний хүний макет.
2	Бүтээлийн нэр:	Үлэг гүрвэлийн үзмэрийн хэв хуулбар, модель болон холбогдох цуглуулга
3	Бүтээлийн төрөл:	Хэв/хуулбар, хөдөлгөөнгүй модель, интерактив хуулбар, цуглуулга
4	Материал:	Үзмэрийн хэв хуулбар, модель, макет нь дараах материал болон хийцийн шаардлагыг хангана:

		- Үндсэн хийц: Шилэн мяндсан хүчитгэсэн полимер /Fiberglass Reinforced Plastic – FRP/ материалаар хийгдсэн, музейн орчинд олон жилийн турш ашиглах боломжтой, бат бөх, деформацид орохгүй, хагарал үүсэхгүй хийцтэй байна. - Цутгамал болон деталь хэсэг: Дүрслэл, гадаргуугийн нарийвчлалыг хангах зориулалттай өндөр нягтралтай polyurethane resin ашигласан байна. - Гадаргуугийн өнгөлгөө: • Олон улсын музейн стандартын акрил суурьтай будаг хэрэглэсэн байна. • Өнгө нь бүдгэрэхгүй, хэт ягаан туяанд тэсвэртэй (UV resistant), арчиж цэвэрлэх боломжтой хамгаалалтын бүрхүүлтэй байна. • Чулуужсан яс, биетийн өнгө, текстурыг бодит олдворын өнгөтэй ижил түвшинд дуурайлган гаргасан байна. - Дотоод карказ ба суурь: Хэмжээ, жингээс хамаарч шаардлагатай тохиолдолд: • Ган карказ • Металл суурь хүрээ ашиглан бүтцийн тогтвортой байдлыг хангана. - Аюулгүй байдал, ашиглалт: • Үзэгчдийн орчинд ашиглахад аюулгүй, хурц ирмэггүй • Зэврэлт, чийгшил, температурын өөрчлөлтөд тэсвэртэй • Дотор орчны музейн ашиглалтын нөхцөлд (≥10 жил) хэлбэрээ алдахгүй байна.
5	Хэмжээ:	- Ясны хуулбар: бодит хэмжээс; - Модель: техникийн үзүүлэлтэд заасан хэмжээ (эсвэл пропорциональ хэмжээ)
6	Ажлын хамрах хүрээ	Гүйцэтгэгч дараах ажлыг иж бүрнээр гүйцэтгэнэ: - Эх олдвороос хэв авах, силикон хэв бэлтгэх, хэв цутгалт хийх, өнгөлгөө будаг гүйцэтгэх; - Хуулбар болон модель бүрийг үзүүллэгт дэглэх боломжтой байдлаар суурь, тогтоогч, шаардлагатай

		карказын хамт бэлэн бүтээгдэхүүн хэлбэрээр нийлүүлэх; - Бэлэн бүтээгдэхүүнийг тээвэрлэн хүргэх, угсралт, байршуулах; - Хүлээлгэн өгөх иж бүрдэл баримт бичгийг бүрдүүлэх / Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт ҮНЭТ МЕТАЛЛ, ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ СОРЬЦ, ЧАНАРЫГ ТОГТООХ, БҮРТГЭХ ЖУРАМ-ын дагуу хүлээлгэн өгөх/ Үүнд: • Үзмэрийн гарал үүсэл, specimen number-ийн баталгаажуулалт; • Ашигласан материалын мэдээлэл; • Ашиглалт, арчилгааны заавар; • Баталгааны бичиг; - Геологийн танхимын эрдэс, чулуулгийн болон ашигт малтмалын цуглуулгыг хавсралтад заасны дагуу иж бүрнээр нийлүүлэх.
7	Ерөнхий шаардлага:	Гүйцэтгэл нь дараах чанар, стандартын шаардлагыг хангасан байна: - Хэв авах ажиллагаа • Жинхэнэ эх олдвороос хэв авсан байх. • Эх олдворыг гэмтээхгүй, бохирдуулахгүй, мэргэжлийн хамгаалалтын аргаар гүйцэтгэх. - Хэв цутгалт ба хийц • Цутгалт нь нягт, агаарын хөндий, цэврүүгүй байх. • Геометр хэлбэр, анатомийн харьцаа алдагдахгүй байх. - Дүрслэл, өнгөний нарийвчлал • Өнгө, фактур, гадаргуугийн бүтэц нь эх олдворын жишиг зураг, кодод нийцсэн байна. • Анатомийн онцлогийг бодит байдлаар сэргээсэн байна. - Материал ба бүтцийн шаардлага • Polyurethane resin суурьтай хийц • Acrylic хамгаалалтын будгийн бүрхүүл

		• Шаардлагатай тохиолдолд custom steel frame дээр суурилуулсан байх - Хэвийн иж бүрдэл хүлээлгэн өгөх • Хэв авахад ашигласан силикон хэв (эсвэл иж бүрдэл)-ийг музейд шилжүүлэн өгнө.
8	Тусгай шаардлага:	- Эх олдворын бүртгэлийн дугаар баталгаажуулалт Хийгдсэн үзмэр бүр нь аль эх олдвор дээр тулгуурласан болохыг нотлох эх олдворын бүртгэлийн дугаар бүхий баримт бичигтэй байна. - Загвар, материал батлуулах Хийгдэх загвар, ашиглах материал, өнгөний шийдлийг үйлдвэрлэл эхлэхээс өмнө Захиалагчаар батлуулна. - Бэлэн үзмэр хэлбэрээр нийлүүлэх Бүтээгдэхүүн бүр нь үзүүллэгт шууд дэглэх боломжтой, угсралт, суурилуулалтын бэлэн байдлыг бүрэн хангасан байна.

-o0o-

№	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг	Дүйцэхүйц зураг
Шинээр хийлгэх хэв хуулбар				
1	Тарбозаврын хэлхээ арга яс	- Эх олдворын дугаар: mpc-d552-1 - Байрлах хэсэг. А блок 1-р давхар угтах хэсэгт	3	
2	Овирапторын өндөгний үүр	- Эх олдворын дугаар: mpc- d100/1001 - Байрлах хэсэг. Судалгааны сан хөмрөгт сургалтын зориулалттай ашиглах	1	
3	Өндөгний үүр	- Эх олдворын дугаар: mpc- d100/1003 - Байрлах хэсэг. Судалгааны сан хөмрөгт сургалтын зориулалттай ашиглах	1	
4	Өндөгний үүр	- Эх олдворын дугаар: mpc- d100/1005 - Байрлах хэсэг. Судалгааны сан хөмрөгт сургалтын зориулалттай ашиглах	1	
5	Өндөгний үүр	- Эх олдворын дугаар: mpc- d100/1007 - Байрлах хэсэг. Судалгааны сан хөмрөгт сургалтын зориулалттай ашиглах	1	
6	Ноцолдож буй үлэг гүрвэлүүдийн хэлхээ арга яс	- Эх олдворын дугаар: mpc-d100/25; 100/501 - Байрлах хэсэг. А блок 1-р давхар угтах хэсэгт	1	

7	Дейнохейрын урд мөч Mpc-d100/18	- Эх олдворын дугаар: mpc-d100/18 - Байрлах хэсэг. Судалгааны сан хөмрөгт сургалтын зориулалттай ашиглах	1	
8	Харпимимусын хэлхээ арга яс	- Олдворын хувийн дугаар: mpc- mpc-d100/29 - Байрлах хэсэг. В блок 1-р давхар	1	
9	Гарудимимусын хэлхээ арга яс	- Олдворын хувийн дугаар: mpc-d100/13 - Байрлах хэсэг. В блок 1-р давхар	1	
10	Галлимимусын хэлхээ арга яс	- Олдворын хувийн дугаар: mpc-d100/12 - Байрлах хэсэг. В блок 1-р давхар	1	
11	Адазаврын хэлхээ арга яс	- Олдворын хувийн дугаар: mpc-d100/21, 22, 23 - Байрлах хэсэг. В блок 1-р давхар.	1	
12	Протоцератопсын бөөнөөр хадгалагдсан зулзага	- Олдворын хувийн дугаар: mpc-d100/530 Байрлах хэсэг. В блок 1-р давхар	1	
13	Өндгөө дарсан Овирапторид-читипати - big mama	- Олдворын хувийн дугаар: mpc-d100/979 - Байрлах хэсэг. В блок 1-р давхар	1	

14	Завроподын хэлхээ арга яс бүтэн болгож хуулбарлах	- Олдворын хувийн дугаар: mpc-d100 - Байрлах хэсэг. B блок 1-р давхар.	1	
Үлэг гүрвэлийн модел хөдөлгөөнгүй загварууд				
15	Psittacosaurus	Урт: 92см, Өргөн: 55см, Өндөр: 25см - Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	2	
16	Oviraptorosauria n	Урт: 156см, Өргөн: 30см, Өндөр: 30см -будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	3	
17	Protoceratops	Урт: 124см, Өргөн: 112.5см, Өндөр: 76см Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	5	
18	Bactrosaurus	Урт: 323см, өргөн: 148см, өндөр: Пропорциональ (харьцаагаар) Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	2	
19	Hadrosauridae	Урт: 323см, өргөн: 148см, өндөр: Пропорциональ (харьцаагаар) Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	2	

20	*Tarbosaurus bataar*	Урт: 730см, өндөр: 250см Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	3	
21	Saurolophus sp.	Урт: 445см, Өргөн: 85см, Өндөр: 176см Будган өнгөлгөөтэй шилэн хуванцар	3	
22	Өндөг (egg)	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой.каст	1	
23	Эрүү шүд	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой.	2	
24	Арьсны хэв дардас	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой.	2	
25	Шүд (tooth)	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой. 7 төрлийн байх	1	

26	Шүд (tooth)	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой. 17 ширхэг өөр төрлийн байна.	1	
27	Хойд хөлийн мөчдийн хэсэг	Үзэгчид барьж үзэх боломжтой интерактив хэсэгт ашиглахад тохиромжтой.	1	
28	Үндэсний бахархалт шувуу – Идлэг шонхор	Үндэсний бахархалт шувуу – Идлэг шонхор 64 мк талбайд тусгай үзүүллэг дэглэн үзүүлнэ. 5-7 шонхор байна	1	
29	Монгол орны ховор, эндимик /унаган ургамал/-ын модель	Монгол орны ховор, эндимик /унаган ургамал/-ын модель 30ш 1. Механик болон Аниматроник загвар - Хөдөлгөөний жигд байдал: Моторуудын ажиллагаа гацахгүй, огцом хөдөлгөөн хийхгүй, чимээ багатай (Low noise levels) байна. - Программчлал: Хөдөлгөөний цикл нь 1-3 минутын хооронд өөр өөр байх бөгөөд үзэгчид нэгэн хэвийн давтамж мэдрэгдэхгүй байхаар тооцно.	1	

		- Алсын удирдлага ба Хяналт: Үзмэрүүдийг төвлөрсөн удирдлагын системээс асаах, унтраах, алдааг оношлох боломжтой байна.		
30	Нүүрс олборлолт харуусан макет	Нүүрс олборлолтын нөлөөллийг бодит мэт харуулсан байна	1	
31	*Одос үхрийн модель*	Амьд мэт харагдах бөгөөд хүрч үзэх боломжтой байна.	1	
32	Макет орчны хамт	Монгол төрхтэй, 10 хүний хэмжээстэй макет хийх. Өндөр-170см Мадам Тюссогийн хэмжээний, хүний арьс, үс шиг харагдах силикон болон лааны холимог баримал	1	
33	Арслан заан болон савагт хирсний макетууд	Дэлхийн экосистемийг дахин өөрчилсөн мөхлийн давлагаа бүхий Мөстлөгийн үеийн сүүлчийн 5 хөхтөн амьтан байх	1	
34	Геологийн танхимд дэглэгдэх эрдэс, чулууллаг, ашигт малтмалын	Даалгаврын хавсралтаас харна уу.	1	

	цуглуулга худалдан авах			

___o0o___

Геологийн танхимд нийлүүлэх эрдэс, чулуулгийн цуглуулгын дэлгэрэнгүй жагсаалт

№	Эрдэс, чулууллаг, металл, металл бус ашигт малтмалын нэр	Тайлбар
1	2	3
1	Монгол орны өнгөт эрдэнийн чулууны дээж. Үүнд: 1. Пироп 2. Альмандин 3. Ногоон хаш 4. Цагаан хаш 5. Биндэрьяа 6. Усан биндэрьяа 7. Хризолит 8. Аметист 9. Цитрин 10. Усан болор 11. Утаат болор 12. Мөсөн болор 13. Молор 14. Цагаан шүр 15. Оюу 16. Мана 17. Гартаам 18. Чүнчигноров 19. Ягаан цахир 20. Цэнхэржсэн цахир 21. Хас 22. Баргилт 23. Лиственит 24. Офиокальцит 25. Родонит 26. Обсидиан 27. Амазонит 28. Лепидолит 29. Туф 30. Флюорит 31. Чулуужсан мод	- Эрдэс, чулуулаг тус бүрийг хэлбэр ба агрегатын байдлыг илэрхийлэхээр болон мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад зүсүүлж, өнгөлж онцлогийг харуулсан байна. - Ховор сонин хэлбэртэй чулууг сонгох. - Эрдэс, чулуулаг тус бүр 25х25см хэмжээтэй байгаль дээрх хэв шинжээрээ байна. - Кварцын төрлийн эрдэс, чулуулаг байгаль дээрх хэв шинжээс нь гадна зассан байдлаар нийлүүлнэ. - Жижиг хэмжээтэй цуглуулаг нийлүүлэх тохиолдолд ширхгийн тоог нэмэгдүүлэх; - Манын олон төрлөөс төлөөлүүлэх /халтар, харлаг, чон, сүй, тархит, замагт, шар, дотор, хүрэн алаг, цэнхэр, нүдэт, шалз, усан, бор, улаан гэх зэрэг/, - Гартаамын олон өнгөнөөс төлөөлүүлэх /саарал өнгөтэй байхаас гадна цагаан, цэнхэр, улаан хүрэн, ягаан, ногоовтор зэрэг/ - Флюрит нь тунгалаг, хагарал ан цав багатай хайлуур жонш байна, зүсэж өнгийг нь гаргасан байна, 60 см-аас багагүй өндөр, харьцангуй том хэмжээтэй.

2	Магмын гаралтай чулуудын дээж 1. Дунит 2. Оливинит 3. Перидотит 4. Фельдшпатит 5. Габбро 6. Норит 7. Анортозит 8. Тералит 9. Тефрит 10. Базальт 11. Диорит 12. Монцонит 13. Шүлтлэг сиенит 14. Андезит 15. Фонолит 16. Гранодиорит 17. Тоналит 18. Гранит 19. Риолит	- Тус бүр 25х25 см хэмжээтэй байгаль дээрх хэв шинжээрээ байна. - Байгаль дээрх бусад олон төрлийн эрдэс, элемтийн холилдсон байдлаар байвал давуу талтай.
3	Хувирмал гаралтай чулуулаг 1. Кварцит 2. Шохойн чулуу 3. Филлит 4. Гялтганууртай занар 5. Төмөрлөг чулуулаг 6. Гнейс 7. Ногоон занар 8. Гантиг 9. Силикатлаг гантиг 10. Грейзн 11. Линсвенит	- Тус бүр 25х25 см хэмжээтэй байгаль дээрх хэв шинжээрээ байна. - Байгаль дээрх бусад олон төрлийн эрдэс, элемтийн холилдсон байдлаар байвал давуу талтай.
4	Тунамал гаралтай 1. Элсэн чулуу 2. Аргиллит 3. Боксит ба Латерит 4. Фосфорит 5. Цахиурлаг чулуу 6. Гипс ба Ангидритаас бүрдсэн чулуу	- Тус бүр 25х25 см хэмжээтэй байгаль дээрх хэв шинжээрээ байна. - Байгаль дээрх бусад олон төрлийн эрдэс, элемтийн холилдсон байдлаар байвал давуу талтай.

	7. Доломит 8. Шохойн чулуу 9. Шаварлаг занар 10. Шавар	
5	Үнэт чулууны дээж: 2010 оны 281 дүгээр тогтоолын 2р хавсралтад орсон үнэт чулууны дээжүүд байх.	- Энэхүү ангилалд багтах чулуудыг хиймэл, дуураймал чулуу/имитаци/, синтетик чулуугаар 40 орчим хувь орлуулж болно. - Гоёл чимэглэлийн зориулалтаар өнгөлж зассан хувилбар байж болно. - Өнгөлж зассан синтетик чулуу нийлүүлэх тохиолдолд чулуу бүрийн ширхэг 3-аас багагүй байна.
6	2010 оны 281 дүгээр тогтоолын 2р хавсралтад орсон хагас үнэт чулууны дээжүүд байх 20-дээс дээж байх	- Энэхүү ангилалд багтах чулуудыг 20 хүртэлх хувийг хиймэл, дуураймал чулуу/имитаци/, синтетик чулуугаар орлуулж болно. - Гоёл чимэглэлийн зориулалтаар өнгөлж зассан хувилбар байж болно. - Өнгөлж зассан синтетик чулуу нийлүүлэх тохиолдолд чулуу бүрийн ширхэг 3-аас багагүй байна. - 60-аас багагүй хувь нь үндсэн хэлбэр ба агрегатын байдлыг илэрхийлэхээр хэв шинжтэй байна
7	Гоёл чимэглэлийн чулууны дээж хагас үнэт чулууны дээжүүд байх 50 дээш дээж байх	- Энэхүү ангилалд багтах чулуудыг 20 хүртэлх хувийг хиймэл, дуураймал чулуу/имитаци/, синтетик чулуугаар орлуулж болно. - Гоёл чимэглэлийн зориулалтаар өнгөлж зассан хувилбар байж болно. - Өнгөлж зассан синтетик чулуу нийлүүлэх тохиолдолд чулуу бүрийн ширхэг 3-аас багагүй байна. - 50-аас багагүй хувь нь үндсэн хэлбэр ба агрегатын байдлыг илэрхийлэхээр хэв шинжтэй байна
8	Металл бус ашигт малтмалын дээжис: 1. Фосфор 2. Хүхэр 3. Давс 4. Шүү	Нунтаг болон шингэн ашигт малтмалын дээжийг өнгө үзэмж сайтай шилэн саванд нийлүүлэх. Шилэн сав нь цилиндр хэлбэртэй 15 см ээс багагүй өндөртэй байх - Лабораторийн дээжний шил байж болно.

	5. Гипс 6. Эрдсийн будаг 7. Бал чулуу 8. Шөрмөсөн чулуу 9. Исландын жонш ба кальцит 10. Цеолит 11. Перлит 12. Керамзитын шавар 13. Бентонит 14. Каолин 15. Магнезит 16. Шавар, шохой 17. Чулуун нүүрс 18. Хүрэн нүүрс 19. Коксжих нүүрс 20. Газрын тос	- Байгалийн хэв шинжээрээ, олборлосон хувилбараараа тус тус байна.
9	Чулуужсан яс, ургамлын үлдэгдэл, хэв дардас агуулсан чулуу	- Эртний амьтны яс, ховор сонин хэлбэртэй чулууг сонгох.
10	Мана гартаамын бижирмэг, хийцлэлтэй үзмэр	- 30 кг-аас багагүй байна.

___o0o___

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын хавсралт

ATA12932 6594204 0024070546

19. "ЛАБОРАТОРИЙН, САН ХӨМРӨГИЙН, ЛАЗЕР БОЛОН ЦААСАН ХЭВЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Утга	Тавигдах шаардлага
1	Ажлын зорилго	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн лабораторид шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлж, зарим тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулах
2	Ерөнхий мэдээлэл	Музейн лабораторид 138 төрлийн 17114 ширхэг багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлж, үүнээс 9 төрлийн тоног төхөөрөмжийг захиалагчийн санал болгосон өрөөнүүдэд суурилуулж, туршилт хийж, ашиглалтад оруулж хүлээлгэн өгнө. Байгалийн шинжлэх ухааны музейд дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулах лабораториуд ажиллана. Үүнд: • Амьтдын чихмэл хийх • Байгалийн төлөөлөл болсон үзмэр, эд өлгийн зүйлсийг сэргээн засварлах • Палеонтологийн олдвор, дээжид техник боловсруулалт хийх, судлах • Олдвор дээжээс хэв хуулбар авах, хувилах • Ургамал, шавж боловсруулах • Чулуу боловсруулах, судлах • Амьтдын яс хэлхэх • Биологийн төрөл зүйлийг генетикийн түвшинд судлах • Мод эдлэлийн цех • Байгалийн гаралтай бүх төрлийн олдвор дээр судалгаа хийх
2	Суурилуулах байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	Байгууламжийн нэр: • Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей. Байршил: • А блок зоорийн давхарт Хүчин чадал Багаж тоног төхөөрөмжүүд дараах дугаартай, нэр бүхий өрөөнүүдэд байршина. • № 48 Хэв хуулбарын лаборатори-73.60 м² • № 49 Хэв хуулбарын лаборатори -104 м² • №54 Чихмэлийн лаборатори- 32.40 м² • №55 Чихмэл сэргээн засварлах өрөө -37.30 м² • №56 Палеонтологийн лаборатори- 148.60 м² • №57 Микроскопын лаборатори- 90.70 м² • №58 Гистологийн лаборатори-66 м²

		• №64 Мужаан цех-43.20 м² • №66 Техник боловсруулалт чулуу- 45.60 м² • №67 Чихмэлийн лаборатори-26.72 м² • №69 Химийн бодис хадгалах өрөө-19.65 м² • №71 Амьтны яс цэвэрлэх хэлхэх- 31.05 м² • №72 Угаалгын өрөө-26.92 м² • №73 Ургамлын лаборатори-31.05 м² • №74 Шавжийн лаборатори-26.92 м² • №75,76,77 Чулуу боловсруулах цех-137.43 м² • №79,80 Модон эдлэлийн цех-91.31 м² • №81 3D принтер өрөө-69.71 м²
3	Ерөнхий шаардлага	• Тоног төхөөрөмжүүд олон улсын жишигт нийцсэн чанартай байх; • Олон улсын чанарын шаардлага хангасан патент, зөвшөөрөлтэй байх; • Оюуны өмчийн зөрчилгүй байх; • Тээвэрлэлт, гаалийн татвар, суурилуулалт, нөөц эд анги дагалдах; • Лабораторийн орчныг бүрдүүлэх • 2025 оноос хойш үйлдвэрлэсэн шинэ байх; • Нийлүүлэгч байгууллага нь угсралт, тохируулгыг хийж баталгаажуулсан акт үйлдэж хэрэглэгчид хүлээлгэж өгөх Дараах стандартуудад нийцсэн байх • MNS ISO/IEC 17025- Лабораторийн чанарын стандарт • MNS 4990:2000 – Хөдөлмөрийн аюулгүй байдал • MNS 6240 – Лабораторийн агааржуулалт
4	Техникийн шаардлага	Музейн лабораторид нийлүүлэх багаж, тоног төхөөрөмжүүдээс дараах 9 нэр төрлийн тоног төхөөрөмжийг суурилуулах, турших, ажиллах албан хаагчдыг сургалтад хамруулах зэрэг ажил үйлчилгээ дагалдана. Үүнд: • Лабораторийн ширээ • Палеонтологийн олдворт техник боловсруулалт хийхэд ашиглах хаягдал сорогч тоног төхөөрөмж • Татах шүүгээ • Электрон микроскоп • Хатаах шүүгээ • XRF анализ хийгч машин • Чулуу зүсвэрийн суурин хөрөө • Рентген зураглал хийх тоног төхөөрөмж • Чулуу өнгөлөгч машин Нийт нийлүүлэх багаж төхөөрөмжийг тендерийн баримт бичигт заагдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлтэд нийцүүлсэн байна.

5	Суурилуулалтын нөхцөл	• Шал тэгш, даацын шалтай • Тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх үед 3-4 хүнд угсралт тохируулга, засвар үйлчилгээний болон ажиллуулах практик сургалт хийх • Суурилуулалтын дараа туршилт хийх
6	Баталгаа, үйлчилгээ	• Баталгаат хугацаа: **≥24 сар** • Засварлах боломжтой байх • Ашиглалтын гарын авлага Монгол хэл дээр байна

_____o0o_____

ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО ШИРХЭГ

№	Барааны нэр	Техникийн үзүүлэлт, ерөнхий шаардлага	Тоо, ширхэг	Хэмжих нэгж	Дүйцэхүйц жишиг зураг
1	Лабораторийн ширээ	• Хэмжээ: ○ Урт: 3000 мм ○ Өргөн: 1400 мм ○ Өндөр: 700–800 мм (тохируулгатай эсвэл стандарт) • Тавцан: ○ Хүчил, шүлтэд тэсвэртэй зориулалтын лабораторийн тавцан ○ Элэгдэл, чийгт тэсвэртэй • Хийц: ○ Металл каркастай, нунтаг будагтай ○ Бат бөх, тогтвортой хийцтэй • Тоноглол: ○ Урвалжийн тавиуртай ○ Угаалтуурта й (ус зайлуулах системтэй) ○ Шургуулгатай, түгжээтэй байж болно • Онцлог: ○ Цэвэрлэхэд хялбар ○ Лабораторийн аюулгүй ажиллагаанд нийцсэн	30	ширхэг	

		• Дагалдах: ○ Усны холболт, сифон			
2	Лабораторийн сандал	Хэмжээ: • Суудлын өндөр: 48–58 см, хийн лифтээр тохируулна • Суудлын өргөн: ~32 см Хийц: • Металл суурьтай, хром эсвэл нунтаг будагтай • 5 хөлтэй, дугуйтай Суудал ба түшлэг: • Түшлэгтэй • Эргономик хэлбэртэй Бүрээс: • Химийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар (PU / PVC төрлийн) Ачаалал даах чадвар: • ≥100 кг Онцлог: • 360° эргэдэг • Өндөр тохируулгатай	100	ширхэг	
3	Air scribe /Хийн цохилттой зүү/	• Ажиллах зарчим: Хийн даралтаар ажилладаг цохилтот зүү • Агаарын даралт: 2.5 – 6.0 bar • Агаарын зарцуулалт: ≤ 120 л/мин • Цохилтын давтамж: Тохируулгатай • Хяналт: Нарийн удирдлагатай (vibration багатай) • Хошуу (зүү) • Диаметр: 1, 2, 3, 4, 5, 6, 8 мм • Диаметр бүрээс 6 ширхэг	42	ширхэг	

		• Материал: Хатуу хайлш /ган • Солих боломжтой • Холбох хоолой • Тохируулгын түлхүүр • Сав баглаа боодол			
4	Хийн компрессор	Нэр төрөл:1 шатлалт, поршинт компрессор Хүчдэл (В/Гц) - 220В/50 гц Моторын чадал м.х/кВт - 3,0м.х/2,2 кВт Бүтээмж (л/мин) - 350 Даралт (Bar) - 8 -10 bar/115 -150 psi Банк /литр/ - 95 Жин (кг) - 98	2	ширхэг	
5	Хийн компрессор	Хүчдэл (V/Ph) - 220/1 Мотор kW - 1.8 Даралт (Bar/Psi) - 10/145 Банк /литр/ - 50 Бүтээл L/min - 260 Эргэлт /rpm/ - 2850 Хэмжээ (см) - 84 x 40 x 67 Жин (кг) - 35,5	5	ширхэг	
6	Хийн хадаасны буу	Хэмжээ: • Жин 2.5 кг (5.5 фунт) • Өндөр 251мм (9.9") • Өргөн 94мм (3.7") • Урт 363мм (14.3") Ашиглалтын даралт: 5~8 бар (70~120 psi) Жолооны хүч: (in-lbs @100psi) 369 Агаарын зарцуулалт: (L/sc @90psi) 0.8 (1.7 cfm)Type 16 Gauge Senco P / Prebena WS Ачаалах хүчин чадал: 160 Бариулын төрөл: Гөлгөр Үдээсний урт: 19~40мм (3/4"~1-9/16") Үдээсний титэм өргөн: 26.4мм (1-1/16")	4	ширхэг	

		Үдээсний утас диаметр. 1.6x1.4мм (0.062"x0.055"			
7	Хийн үдээсний буу	1022J ангиллын үдээс таарах	4	ширхэг	
8	Батерей дрилл	Хүчдэл: 12V Ачаалалгүй хурд: 0-600 эрг/мин Хамгийн их эргэлт: 20НМ Чак багтаамж: 0.8-10мм	20	ширхэг	
9	Цахилгаан тасдагч	Хүчдэл: 220-240V~50/60Hz Оролтын хүч: 1500 Вт	20	ширхэг	
10	Гагнуурын аппарат	Гаралтын гүйдэл: 40-380А Электродын диа /max/: 2.5-6.0мм Хүчдэл: 380В/50Гц, 1фаз Тэжээлийн чадал: 16.9 кВт Тасралтгүй ажиллах горим: 60% Жин: 25,8кг Дагалдах зүйлс: Электрод баригч /1.8м/, Хавчаар - массын утас /1,2м/, Хамгаалалтын маск, цэвэрлэгээний сойз	10	ширхэг	
11	Суурин тасдагч	• Төрөл: Суурин, дискэн тасдагч • Ашиглалт: Металл материал таслах • Ажиллах хүчдэл: 220 V • Хөдөлгүүрийн чадал: 2300 W • Эргэлтийн хурд: 3800 эрг/мин (r/min) • Таслах диск: -Диаметр: 355 мм -Солих боломжтой • Таслах чадвар: -Дугуй хоолой: Ø115 мм хүртэл	2	ширхэг	

		-Дөрвөлжин профиль: 115 × 115 мм хүртэл *(эсвэл үйлдвэрлэгчийн зааврын дагуу)* • Жин: 17.5 кг • Онцлог: -Бат бөх суурьтай -Таслах өнцөг тохируулах боломжтой -Аюулгүйн хамгаалалттай			
12	Цүүцны иж бүрдэл	• Төрөл: Гар цүүц • Иж бүрдэл дэх хэмжээ: 6 мм, 12 мм, 18 мм, 25 мм, 32 мм • Иж бүрдэл дэх тоо: 5 ширхэг • Ир: Өндөр хатуулагтай ган • Элэгдэлд тэсвэртэй • Бариул: Эргономик хэлбэртэй • Арын хэсэгт ган малгайтай (цохилтын хүчийг үр дүнтэй дамжуулна)	8	Иж бүрдэл	
13	Алх	20 унц/560 гр	8	ширхэг	
14	Геологийн алх	Хэмжээ • Ерөнхий урт 320 мм • Алхны толгон хэсгийн урт 170 мм • Цохих хэсгийн хэмжээ 30х 23 мм	20	ширхэг	

15	Хуурайны иж бүрдэл	• Эдэлгээ даах бат бөх хийцтэй. • Ирний мохолтыг багасгах үүднээс өндөржүүлсэн нүүрстөрөгчийн гангаар хийгдсэн. • Нийт урт:150 мм • Тоо:6 ширхэг	8	ширхэг	
16	Галоген шинжилгээний гэрэл	• 30,000 Lux • Гэрлийн температур: 3600±200k • Тусгалтын өнцөг: 95% • Хүчдэл: 220в±22в	30	ширхэг	
17	Оффис төмөр шкаф	Ерөнхий мэдээлэл • Төрөл: Оффисын төмөр шкаф • Зориулалт: Бичиг хэрэг болон хувцас хадгалах (хос зориулалттай) • Өнгө: Цагаан, саарал Хэмжээ • Өндөр: 1800 мм • Өргөн: 970 мм • Гүн: 400 мм Хийц, материал • Материал: Ган төмөр • Төмрийн зузаан: 1 мм • Нугас: Зэвэрч, гажихгүй бат бөх нугас Бүтэц, зохион байгуулалт • Хаалга: 5 хаалгатай • Тавиур: Нийт 2 ширхэг	100	ширхэг	

		Өндөр нь тохируулгатай (дээш, доош хөдөлнө) • Тасалгаа: 4 тусдаа тасалгаатай • Хувцасны хэсэг: Өлгүүртэй Гутлын тавиуртай • Аюулгүй байдал • Цоож: Бат бөх цоожтой • Түлхүүр: Хаалга бүрд 2 ширхэг түлхүүр Нөөц (запас) түлхүүр Будаг, бүрээс • Будаг: 100% эко, ургамлын гаралтай • Гадаргуу: Элэгдэлд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар			
18	Үртэс сорогч	• Чадал 2.2 квт • Соролтын хурд 20-25 м/сек хэмжээ • 96x56x52м • Бохир жин 55 кг • 3 ш гуурсан хоолой дагалдана.	3	ширхэг	
19	Цахилгаан түрдэг хөрөө	• Хүчдэл: 220-240V~50/60Hz • Оролтын хүч: 2200 Вт • Ачаалалгүй хурд: 3800 эрг / мин • Хутганы диаметр: 235x25.4мм	8	ширхэг	

20	Цахилгаан уран хөрөө	• Хүчдэл: 220-240V~50/60Hz • Оролтын хүч: 400 Вт • Ачаалалгүй хурд: 800-3000 эрг / мин	8	ширхэг	
21	Палеонтологийн олдворт техник боловсруулалт хийхэд ашиглах хаягдал сорогч тоног төхөөрөмж	• Хоолойн диаметр: 20 см • Цахилгааны чадал: 1000 – 2200 Вт • Агаарын урсгал: 60 – 300 л/сек (эсвэл түүнээс их) • Вакуум/сорох хүч: ~200 + mbar Шүүлтүүр: HEPA (0.3 µm-ийн 99.97 %) Савны багтаамж: 20 – 40 л	5	ширхэг	
22	G хавчаар	• G хавчаар 75мм • G хавчаар 100мм • G хавчаар 200см гэсэн 3 өөр төрлийн хэмжээстэй байна.	6	ширхэг	
23	Суурин өрөм	Хүчдэл: 220-240V~50Hz Оролтын хүч: 350 Вт Ачаалалгүй хурд: 580-2650 эрг/мин Хамгийн их өрөмдлөгийн хүчин чадал:13мм	4	ширхэг	
24	Тоос сорогч	Нойтон болон хуурай цэвэрлэгээ Хүчдэл: 220V-240V~50/60Hz Оролтын хүч: 1400 Вт	20	ширхэг	
25	Цахилгаан точил	Хүчдэл: 220-240V~50Hz Оролтын хүч: 150 Вт Ачаалалгүй хурд: 2950 эрг / мин	4	ширхэг	

26	Цохилттой дрилл	Хүчдэл: 220-240V~50/60Hz Оролтын хүч: 800 Вт Ачаалалгүй хурд: 0-1100 эрг / мин	4	ширхэг	
27	Цахилгаан зүлгүүр	Хүчдэл: 220V-240V~50/60Hz Оролтын хүч: 320 Вт Ачаалалгүй хурд: 14000 эрг / мин	8	ширхэг	
28	Цахилгаан харуул	Вольт: 220-240V~50/60Hz Оролтын хүч: 1050 Вт Ачаалалгүй хурд: 16000 эрг / мин	8	ширхэг	
11	Байгууллагын нэр бүхий усан хөшиг, усан толио (байгалийн чулуун хийцлэлтэй, 3D үсэг, гэрэлтүүлэг, усан систем)	**Материал:** Өнгөлсөн боржин чулуу эсвэл байгалийн гантиг чулуу (хар, саарал өнгө давамгайлсан). **Усан толионы хэмжээ:** [Урт] м x [Өргөн] м x [Гүн] м. Урт ~10–15м / өргөн 3–5м / гүн 0.4–0.6м (зураг төслөөр нарийвчилна) **Ус тусгаарлалт:** Суурийн хэсэгт 3-аас доошгүй үе өндөр чанарын полимер суурьтай ус тусгаарлагч (Waterproofing) хийсэн байх. **Бүтэц:** Чулуун хавтангууд нь хоорондоо ямар нэгэн завсаргүй, усны урсгалыг жигд харуулах өнгөлгөөтэй байна. **Б. Байгууллагын нэр (3D үсэг)** **Материал:** Зэвэрдэггүй ган (Stainless Steel 304/316 зэрэглэл). **Хийцлэл:** 3D хэлбэртэй, дотроосоо эсвэл ар талаасаа гэрэлтдэг (Backlit/Halo effect).	ш	1	

		Тогтооц: Усан хөшигний хананд эсвэл усан толионы төвд бат бөх бэхлэгдсэн, зэврэлтээс бүрэн хамгаалагдсан байна. **В. Усан систем (Гидравлик)** **Насос:** Дуу чимээ багатай, эрчим хүчний хэмнэлттэй (Low noise submersible pump). **Усан хөшигний механизм:** Ус нь дээрээс доош жигд, тасралтгүй "хөшиг" мэт урсгал үүсгэх зориулалттай хуваарилагч хошуу (Nozzle) системтэй байна. **Шүүлтүүр:** Усыг цэвэр байлгах зориулалттай элсэн шүүлтүүр эсвэл механик шүүлтүүрийн системтэй байна. **Автоматжуулалт:** Усны түвшин мэдрэгч (автоматаар ус дүүргэх) болон цаг тохируулагчтай байх. **3. Гэрэлтүүлэг болон Цахилгаан** **Гэрлийн төрөл:** Усан доорх зориулалтын LED (IP68 хамгаалалттай). **Өнгө:** Дулаан цагаан (Warm white) эсвэл RGB (удирдах боломжтой). **Аюулгүй байдал:** 12V эсвэл 24V-ийн аюулгүй хүчдэлээр ажиллах транформатортай,			

		газардуулгын системтэй байна.			
13	Нийтийн ариун цэврийн байгууламж (2 хэсэг газарт байгууламж)	Музейн зочдод зориулсан, жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой, эрчим хүчний хэмнэлттэй, аюулгүй ба хүртээмжийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг байгуулах. Тус байгууламж нь эрс тэс уур амьсгалд тэсвэртэй хийц, ус хэмнэх дэвшилтэт сантехникийн шийдэлтэй байж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэнэ. Хавсралт-4	иж	2	
15	Зарлан мэдээлэх / PA систем	Хавсралт-6	иж	3	
16	Гадна хаяг	МатериалХөнгөн цагаан (Alucobond) эсвэл Зэвэрдэггүй төмөр ГэрэлтүүлэгSamsung LED эсвэл түүнтэй дүйцэхүйц, Усны хамгаалалттай тэжээлийн блок Хэвлэлийн чанар1440dpi UV хэвлэл (Гадаа зориулалтын) КонструкциТөмөр карказ (Зэврэлтээс хамгаалсан будагтай)			
17	Ундны усны оргилуур (шугам хоолой зэс байх) (3 цэгт байгууламж)	Хавсралт-5	ш	3	

18	Унадаг дугуйн зогсоол (рек/тохиргоо)	**Хийцлэл:**Зэвэрдэггүй ган (SUS304) эсвэл халуун цайрдсан металл карказ. Олон төрлийн дугуй (MTB, Road, Scooter) байрлуулах зориулалттай. **Дээвэр:** 8-10мм зузаантай поликарбонат эсвэл металл дээвэр. Бороо, цас зайлуулах налуу системтэй. **Суурилуулалт:** Төмөр бетон суурьтай, анкер боолтоор далд бэхлэгдсэн. Салхины ачаалал даах инженерийн тооцоотой. **Нэмэлт:** Шөнийн LED гэрэлтүүлэг, дугуй засварын суурин насос (сонголтоор), мэдээллийн тэмдэгтэй.	ш	1	
19	Харуул, хамгаалалтын жижиг байр + тавилга	**Хийцлэл**Төмөр карказ бүхий иж бүрэн дулаалгатай (150мм эрдэс хөвөн/PU) угсармал байгууламж. Хэмжээ: 5х3м. **Харагдах орчин**3-4 тал руугаа харах боломжтой вакуум цонхнууд. Урд талын цонх нь зочдод мэдээлэл өгөх гүйдэг нээлхийтэй байна. **Тохижилт**Дотор засал (PVC/MDF), ажлын ширээ, сандал, хувцасны шүүгээ. Халаалтын систем (Термостаттай цахилгаан радиатор). **Аюулгүй байдал**Хяналтын камерын төв дэлгэц холбох боломжтой. Гадна талдаа хөдөлгөөн мэдрэгчтэй прожектортой. **Холбоо**Интернэт (LAN) болон дотоод холбооны	ш	2	

		систем (Intercom) суурилуулсан байна. **Хяналтын операторын ширээ:** 120х60см хэмжээтэй, хяналтын камерын дэлгэц (Monitor) байрлуулах зориулалтын тавиуртай. Кабелийн суваг бүхий L-хэлбэрийн эсвэл шулуун загвар. **Эргономик ажлын сандал:** Өндөр нам тохируулдаг, нурууны түшлэгтэй, 360 градус эргэдэг, дугуйтай. Даавуун эсвэл торсон (Mesh) материалтай. **Бичиг баримтын шүүгээ:** Ажлын журналын болон бичиг баримтын А4 хэмжээтэй хавтас орох 2-3 тасалгаатай, цоожтой металл шүүгээ. **Хувцасны шүүгээ (Locker):** Ганц хаалгатай, гадуур хувцас өлгөх хэсэг болон гутал, цүнх тавих тасалгаатай металл шүүгээ. **Амралтын жижиг сандал/буйдан:** Харуул ээлж солилцох үед ашиглах ус чийгт тэсвэртэй арьсан (PVC) өнгөлгөөтэй жижиг сандал. **Гал тогооны хэсэг: (Compact)**Цайны халуун сав, бичил долгионы зуух (Microwave) байрлуулах зориулалтын жижиг тавиур/шүүгээ. **Ариун цэврийн өрөө: Сантехникийн хэрэгсэл:** Шаазан суултуур (хэмнэлттэй ус зайлуулах системтэй),			

		гар нүүрийн угаагуур, толины хамт. **Дагалдах хэрэгсэл:** Зэвэрдэггүй ган эсвэл хатуу хуванцар материалын цаасан тогтоогч, хогийн сав, гар хатаагч (эсвэл цаасан алчуур түгээгч). **Агааржуулалт:** Албадан агааржуулалтын сэнс болон чийгт тэсвэртэй гэрэлтүүлэгтэй.			
20	Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг (3 ширхэг стандартын дагуу шилэн байгууламж)	**Хийцлэл:** Зэвэрдэггүй ган эсвэл хөнгөн цагаан карказ бүхий иж бүрэн шилэн байгууламж. Хэмжээ: 2.5х3.5м-ээс багагүй. **Шилэн фасад:** 10-12мм зузаантай, цохилтод тэсвэртэй Тэмпердсэн шил (Tempered glass). Нарны гэрэл ойлгогч болон аюулгүй байдлын наалттай. **Агааржуулалт:** Албадан агааржуулалтын систем (Exhaust fan) болон агаар сэлгэлтийн нээлхий. Утаа шүүх фильтертэй байж болно. **Тоноглол:** Галд тэсвэртэй, зэвэрдэггүй ган хогийн сав (Үнсний савтай), хагас түшлэг бүхий зогсоо сандал (Perch bench). **Тэмдэглэгээ**: "Тамхи татах цэг" олон улсын стандарт тэмдэг, галын аюулгүй байдлын заавар бүхий UV хэвлэлтэй хаяг.		3	
21	Угтах хаалга	**Зорилго:** Музейн орох хэсэгт архитектурын өвөрмөц шийдэл бүхий портал хаалга (Gate structure) байгуулж, үзэгчдийг чиглүүлэх, аюулгүй байдлыг хангах.	ш	1	

		Гүйцэтгэлийн нөхцөл: Гүйцэтгэгч нь Захиалагчаас өгсөн концепц зураг болон талбайн хэмжээнд тулгуурлан барилгын ажлын зураг төслийг (Construction drawing) боловсруулж, зөвшилцөн батлуулсны үндсэн дээр угсралтын ажлыг гүйцэтгэнэ. **Зураг төсөл:** Эскиз зураг: Гүйцэтгэгч дизайны 3-аас доошгүй хувилбарыг 3D дүрслэлээр танилцуулна. Материал сонголт: Гадна өнгөлгөөний материалын дээжийг захиалагчид биетээр үзүүлж, өнгө болон чанарыг баталгаажуулна. **Дагалдах ажил:** Хаалганы доорх болон эргэн тойрны зам талбайн нөхөн сэргээлт, тэмдэг тэмдэглэгээг иж бүрэн гүйцэтгэнэ. **Баталгаа:** Үндсэн хийцэд 10 жил, өнгөлгөө болон гэрэлтүүлэгт 3 жилээс доошгүй баталгаа гаргана. /Хавсралт 11/			
22	Ажилчдын хэсгийн сандал, сүүдрэвч	**Ерөнхий шаардлага** Зорилго: Музейн ажилчдад зориулсан амрах, гадаа ажиллах тухтай орчин бүрдүүлэх. Дизайн: Музейн ерөнхий концепцтой нийцсэн, орчин үеийн минималист шийдэл бүхий иж бүрдэл. Байршил: Барилгын зүүн хэсэг талбайд (Зураг төслийн дагуу). **Сүүдрэвч**	ш	3	

		Хийц: Ган карказ бүхий, зэврэлтээс хамгаалагдсан (ISO 12944 стандарт) хийцтэй байна. Дээвэр: Нарнаас хамгаалах UV шүүлтүүртэй мембран эсвэл давирхайгаар хүчитгэсэн модон хавтан. Гэрэлтүүлэг: Далд LED зурвас гэрэлтүүлэг болон цэгэн гэрэлтэй байна. Нэмэлт: Гадна орчны USB цэнэглэгч болон цахилгаан залгуурыг (IP66 хамгаалалттай) сууринд шийдэж өгнө. **Сандал ба Ширээ** Материал: Цаг агаарын нөлөөнд тэсвэртэй WPC (мод-хуванцар композит) эсвэл HPL хавтан. Хэлбэр: Эргономик дизайнтай, нурууны тулгууртай вандан сандал болон дугуй эсвэл муруй ширээ. Суурилуулалт: Вандан болон ширээ нь газарт бетон сууриар бэхлэгдсэн, хөдөлгөөнгүй байна. **Стандарт ба Баталгаа** Аюулгүй байдал: EN 1176 стандарт (ирмэг иргүй, аюулгүй холболт). **Баталгаа:** Металл хийц 10 жил, гадна өнгөлгөө 5 жил, гэрэлтүүлэг болон цахилгаан хэрэгсэл 2 жил.			
23	Инженер, дэд бүтцийн зураг төслийн өөрчлөлт, зөвлөх инженер, зөвшөөрөл,	Угтах хаалга, хэрэгцээний цэвэр ус, ариутгах татуурга, харуулын байр, алсын дурангийн цамхаг болон тэжээлийн кабелийн сувагчлалын зураг	ш	1	

	хяналт, анхан шатны судалгаа				
	НИЙТ				

Жич: Энэхүү техникийн тодорхойлолт болон төсөвт өртөгт “Дом театр”-ын дотоод заслын ажил (акустик хана, таазны гүйцэтгэл, шалны бүрээс, интерьер гэрэлтүүлэг г.м) ороогүй болно. Уг ажлуудын материалын тодорхойлолт болон зардлын тооцоог интерьер дизайн, акустикийн нарийвчилсан зураг төсөл батлагдсаны дараа тооцогдох боломжтой

МУЗЕЙН БЭЛГЭДЭЛ БҮХИЙ ЛОГО БАРИМАЛ, БАЙГУУЛАМЖ УГСРАХ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Ерөнхий шаардлага**	Гүйцэтгэлийн нөхцөл: "Түлхүүр гардуулах" (Turn-key) нөхцөлтэй. Үүнд: Зураг төсөл, материалын зардал, үйлдвэрлэл, тээвэрлэлт, суурилуулалт, бетон суурь, гэрэлтүүлэг болон тохижилтын бүх зардал багтсан болно.
		Дизайн: Гүйцэтгэгч нь захиалагчаас өгсөн концепцын дагуу 3D загварыг боловсруулж батлуулна. Захиалагч брендингийн өөрчлөлттэй холбоотойгоор загварт засвар оруулах эрхтэй бөгөөд энэ нь гэрээний үнийн дүнд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.
		Ашиглалтын хугацаа: Иж бүрдэл байгууламж нь гадна орчинд 50-иас доошгүй жил чанар байдлаа хадгалах эдэлгээний шаардлага хангасан байна.
2	**Инженерчлэл ба аюулгүй байдал**	Бэхэлгээ: Газар хөдлөлтийн 8 ба түүнээс дээш баллын чичиргээ, салхины ачааллыг тооцсон инженерийн зураг төслийн дагуу бэхэлгээг хийнэ.
		Үе шатны хяналт: Гүйцэтгэгч нь материалын чанарын сертификат (Mill Test Certificate)-ыг захиалагчид хүлээлгэн өгч, дотор карказын угсралт болон материалын зузааныг үйлдвэрлэлийн явцад шалгуулна.
3	**Нийлүүлэгчид тавих тусгай нөхцөл**	Дээж ирүүлэх: Гүйцэтгэгч нь ажил эхлэхээс өмнө ашиглах үндсэн металл (AISI 316) болон гадаргуугийн өнгөлгөөний дээжийг (30x30 см-ээс багагүй) захиалагчаар батлуулна.
		Маргаан зохицуулалт: Техникийн тодорхойлолтод заасан материалын марк, стандарт зөрчигдсөн тохиолдолд захиалагч ажлыг хүлээн авахаас татгалзаж, гүйцэтгэгч өөрийн зардлаар дахин хийх үүрэг хүлээнэ.
		Баталгаат хугацаа: Иж бүрэн байгууламжид гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 36 сараас доошгүй хугацааны чанарын баталгаа гаргана.

ҮЛЭГ ГҮРВЭЛ, ЭРТНИЙ ХӨХТӨН АМЬТДЫН АНИМАТРОНИК (ХӨДӨЛГӨӨНТ) БАРИМАЛ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Зориулалт**	Эртний амьтдын бодит төрх, хөдөлгөөн, дуу авиаг программчлагдсан хэлбэрээр үзэгчдэд бодитойгоор харуулах зориулалттай.
2	**Хөдөлгөөний төрөл**	Толгой эргэх, ам нээх/хаах, нүд анивчих, амьсгалах (цээжний хөдөлгөөн), сүүл хөдөлгөх зэрэг 5-8 төрлийн үндсэн хөдөлгөөнтэй байна.
3	**Материал (Дотор)**	Зэвэрдэггүй ган карказ (Anti-rust steel frame),дуу чимээ багатай, өндөр нарийвчлалтай сойзгүй мотор (Brushless motor) болон пневматик/электрон удирдлагын системтэй,хөдөлгөөнт үе бүр нь элэгдэлд тэсвэртэй холбоосоор тоноглогдсон байна.
4	**Материал (Гадна)**	Бодит арьс мэт өндөр суналттай эмнэлгийн зориулалттай силикон (High-grade Medical Silicon) олон үе шат бүхий арьсан бүтэц, дүүргэлт нь өндөр нягтралтай зөөлөн хөөсөнцөр (High-density sponge)цаг уурын нөлөөнд тэсвэртэй, дотоод өнгөлгөөтэй байна. Гадаргуу хэт ягаан туяа (UV), ус, чийгний хамгаалалттай.
5	**Дуу авиа**	Тухайн амьтны төрөл зүйлд тохирсон дижитал дуу авианы системтэй IP65 хамгаалалттай, гадна зориулалтын стерео спикер (Built-in Speaker), хөдөлгөөнтэй синхрончлогдсон байна.
6	**Удирдлагын систем**	Интерактив технологи: Хөдөлгөөн болон ойртолт мэдрэгч, дотоод дууны систем, амнаас уур гаргах эффект. Хөдөлгөөн мэдрэгч (Infrared sensor), алсын удирдлага эсвэл цагийн тохируулгаар автоматаар ажиллах программ хангамжтай байна.
7	**Хүчдэл ба Цахилгаан**	110/220V, 50/60Hz хүчдэлд ажиллах бөгөөд гадна зориулалтын усны хамгаалалттай залгуур, удирдлагын хайрцагтай (Control box) байна.
8	**Бодит байдал**	Амьтны арьсны бүтэц, өнгө, шүд, хумс зэрэг нь палеонтологийн олдвор дээр үндэслэгдсэн, гар аргаар будсан (Hand-painted) бодит харагдацтай байна.
9	**Аюулгүй байдал, засвар**	Хөдөлгөөний үед үзэгчдэд аюул учруулахгүй тогтвортой суурь (Metal base) болон аюулгүйн хашлага суурилуулах боломжтой байна.Яаралтай зогсоох систем, цахилгаан хамгаалалт, засвар үйлчилгээний нууц нэвтрэх хэсэг.
10	**Дагалдах хэрэгсэл**	Удирдлагын хайрцаг, спикер, мэдрэгч, чулуун хэлбэртэй шилэн хүвэн (Fiberglass) бүрхүүл бүхий хамгаалалтын хайрцагтай байна.Тээвэрлэлт, угсралт суурилуулалт болон Гаалийн бүрдүүлэлтийг нийлүүлэгч тал хариуцна
11	**Баталгаа**	Бүтээгдэхүүн нь -35°C-аас +45°C температурт ажиллах чадвартай, усны хамгаалалттай (IP67 зэрэглэлтэй) байна. Механик болон электрон эд ангиудад үйлдвэрлэгчийн баталгаа: ≥3 жил. (Засвар үйлчилгээний иж бүрдэл, нэмэлт арьс, цавуу багтсан байна)

ЭРТНИЙ АМЬТДЫН ЧУЛУУН ДАРДАС, РЕПЛИКА (20-30 ТӨРӨЛ)

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Зориулалт**	Палеонтологийн олдворуудыг бодит масштабтайгаар (1:1) харуулсан 20-30 төрлийн үзүүллэгийн иж бүрдэл.
2	**Материал**	Өндөр нягтралтай полиэфир давирхай (Fiberglass) болон чулууны нунтаг холимог бүхий эрс тэс уур амьсгалд тэсвэртэй реплика.
3	**Суурилуулалт**	Байгалийн чулуун (боржин) хавтан дээр зэвэрдэггүй ган зангуугаар далд бэхэлгээ хийж суурилуулна.
4	**Тайлбар самбар**	Зэвэрдэггүй ган дээр лазераар сийлсэн, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Брайль үсэгтэй байна.
5	**Нийцэл**	Олдворын бодит байдлыг 95%-иас дээш нарийвчлалтай харуулсан, палеонтологийн зөвлөхөөр баталгаажуулсан байна.

НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Зориулалт**	Музейн гадна талбайн үзэгч, жуулчдад зориулсан эрүүл ахуйн стандарт хангасан 2 хэсэг газарт байрлах байгууламж.
2	**Хийцлэл**	Төмөр карказ бүхий угсармал (Modular) эсвэл дулаалгатай сэндвич хавтан. Гадна тал металл фасад, дотор тал бүрэн плита байна.
3	**Инженерчлэл**	Төвлөрсөн эсвэл бие даасан био-ариусгах системтэй. Албадан агааржуулалт болон автомат халаалтын системтэй байна.
4	**ХБИ-ийн хүртээмж**	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, бариул, тусламжийн дуудлагын систем бүхий олон улсын стандарт хангасан байна.
5	**Нийцэл**	БНбД 31-04-03 (Олон нийтийн барилга) нормд нийцсэн, усны хэмнэлттэй мэдрэгчтэй тоноглолтой байна.

УНДНЫ УСНЫ ОРГИЛУУР (3 ЦЭГТ) ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Зориулалт**	Музейн гадна талбайн үзэгч, жуулчдад зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан, шууд уух зориулалттай ундны усны 3 иж бүрдэл цэг.
2	**Материал (Их бие)**	Зэвэрдэггүй ган (SUS 304) эсвэл байгалийн чулуун гадаргуутай, гадна орчны эрс тэс уур амьсгал, зэврэлтэд тэсвэртэй байна.
3	**Шугам хоолой**	Дотор ус дамжуулах шугам хоолой нь нянгийн эсрэг шинж чанартай, зэвэрдэггүй Цэвэр Зэс (Copper) материалаар хийгдсэн байна.
4	**Шүүлтүүрийн систем**	Усыг цэвэршүүлэх идэвхжүүлсэн нүүрсэн болон механик шүүлтүүр бүхий 3 шатлалт цэвэршүүлэгч системтэй байна.
5	**Цорго ба Удирдлага**	Ус цацахаас хамгаалсан зориулалтын хошуутай, усны алдагдлыг хязгаарлах автомат хаагчтай хөлийн гишгүүр эсвэл товчлууртай байна.
6	**Хүртээмжтэй байдал**	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд ашиглахад тохиромжтой өндөр, нам хосолсон (Dual-level) дизайнтай байна.
7	**Инженерчлэл**	Бохир ус зайлуулах шугамд холбогдсон, өвлийн улиралд шугам хоолойн усыг юүлэх, хөлдөлтөөс хамгаалах хавхлагатай байна.
8	**Эрүүл ахуй**	Ус хуримтлагдаж тогтохгүй байх аяган хэлбэрийн загвартай, бактери үржихээс сэргийлсэн гадаргуутай байна.
9	**Суурилуулалт**	Төмөр бетон суурь дээр анкер боолтоор бэхлэгдсэн, газар доорх шугамын холболтууд нь ус тусгаарлалттай байна.
10	**Нийцэл**	Ундны усны стандарт MNS 0900:2018 болон Хот байгуулалтын аюулгүй байдлын нормд бүрэн нийцсэн байна.
11	**Баталгаа**	Байгууламжийн угсралт болон шүүлтүүрийн системийн ажиллагаанд үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил байна.

ГАДНА ТАЛБАЙН ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ (PA) СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Зориулалт**	Музейн гадна талбайд зочдод мэдээлэл өгөх, хөгжим тоглуулах, онцгой байдлын үед зарлан мэдээлэх зориулалттай иж бүрэн систем.
2	**Хамгаалалтын зэрэг**	Гадна чанга яригч нь тоос, усны хамгаалалтын IP65-аас багагүй зэрэгтэй, хэт халалт, хөлдөлтөд тэсвэртэй (All-weather) байна.
3	**Чанга яригч (Loudspeakers)**	30W-60W чадалтай, 100V системээр ажилладаг, дууны тод байдлыг алдагдуулахгүй хол зайд дамжуулах чадвартай байна.
4	**Системийн төрөл**	Дижитал (IP-based) эсвэл Аналог хосолсон систем. Алсын удирдлагаар бүсчлэн (Zone control) зарлан мэдээлэх боломжтой байна.
5	**Өсгөгч (Amplifier)**	Системийн нийт чадлаас 20%-ийн нөөцтэй, богино холболт болон хэт ачааллаас хамгаалагдсан, USB/BT/FM оролттой мэргэжлийн өсгөгч.
6	**Микрофон**	Харуул хамгаалалтын байранд байрлах, шуугиан дарагчтай, гол хүзүүт (Gooseneck) зориулалтын операторын микрофонтой байна.
7	**Холболтын кабел**	Гадна орчинд зориулсан, нарны туяа болон чийгэнд тэсвэртэй хамгаалалтын бүрхүүл бүхий (Outdoor-rated) зэс кабел ашиглана.
8	**Бэхэлгээ**	Баганан дээр эсвэл хананд суурилуулах, зэвэрдэггүй ган бэхэлгээтэй, дууны чиглэлийг 180 градус тохируулах боломжтой байна.
9	**Онцгой байдал**	Галын дохиоллын систем болон бусад аюулгүй байдлын системтэй холбогдож, автоматаар зарлан мэдээлэл өгөх (Mute override) функцтэй байна.
10	**Удирдлага**	Төв удирдлагын хэсэгт дууны түвшинг бүс бүрээр тохируулах боломжтой байна.
11	**Баталгаа**	Системийн иж бүрэн ажиллагаа болон тоног төхөөрөмжид үйлдвэрлэгчийн баталгаа: ≥2 жил байна.

ГАДНА ТАЛБАЙН НАРНЫ АЙМГИЙН ҮЗҮҮЛЛЭГ (МАКЕТ, СУУРИЛУУЛАЛТ, ШӨНӨ ГЭРЭЛТЭХ СИСТЕМТЭЙ) ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	Бүтэц	Бөмбөрцөг бүр дотроо 40х40мм эсвэл 60х60мм-ийн харьцаатай ган карказаар
2	Материал	8мм-ээс багагүй зузаантай, 3-аас доошгүй үе шилэн хөвөн (Fiberglass/FRP) давхарлаж хийнэ. Гадаргуу нь гөлгөр, ямар нэгэн нүх сүвгүй байна.
3	Гэрэлтүүлэг	Бөмбөрцөг том тул дотроо 1 биш, дор хаяж 4-8 ширхэг 50W-ийн LED прожектор эсвэл өндөр нягтаршилтай LED туузаар бүх чиглэлд жигд гэрэлтүүлнэ.

НАРНЫ АЙМГИЙН ҮЗҮҮЛЭНГИЙН ХЭМЖЭЭ

Гараг	Диаметр (метр)	Тайлбар
Буд (Mercury)	0.8 м	Хамгийн жижиг гараг гэдгийг харуулна.
Сугар (Venus)	1.4 м	Дэлхийтэй бараг ижил хэмжээтэй харагдана.
Дэлхий (Earth)	1.5 м	СУУРЬ ХЭМЖЭЭ. Далай, тивийг тод дүрсэлнэ.
Ангараг (Mars)	1.0 м	Дэлхийгээс жижиг гэдэг нь тодорхой харагдана.
Бархасбадь (Jupiter)	4.0 м - 5.0 м	Хамгийн том гараг гэдгийг илтгэнэ.
Санчир (Saturn)	3.5 м - 4.5 м	Цагирагтайгаа нийлбэл 8-9 метр өргөн болно.
Тэнгэрийн ван (Uranus)	2.5 м - 3.0 м	Хийн аварга гарагуудын дундаж хэмжээ.
Далайн ван (Neptune)	2.5 м - 3.0 м	Тэнгэрийн вантай ижил түвшинд.
НАР (SUN)	8.0 м - 12.0 м	Бүрэн бөмбөрцөг биш, арк (хаалга) хэлбэрээр хийхэд тохиромжтой.

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ГАДНА ТАЛБАЙН ҮЗҮҮЛЛЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Амьтны мөрний дардас**	**Зорилго:** Монгол орны болон дэлхийн ховор 10 төрлийн амьтны (жишээ нь: Ирвэс, Мазаалай, Хүрэн баавгай, Зэгсний гахай г.м) мөрийг бодитоор таньж мэдэх. **Техникийн шаардлага:** Материал: Байгалийн чулуу эсвэл өндөр нягтралтай полимер бетон (Art-concrete). Гадна орчны чийг, хөлдөлтөд тэсвэртэй. **Хийцлэл**: Мөрийг 1:1 харьцаатай (бодит хэмжээгээр) хонхойлгож сийлэх эсвэл цутгаж гаргана. Мөр бүрийн хажууд тухайн амьтны нэр, тайлбарыг зэвэрдэггүй ган дээр лазераар шивж байршуулна. **Зохиомж:** Үзэгч алхах замын дагуу эсвэл 3-5 метрийн диаметртэй тойрог талбайд "Мөрний эрэлд" тоглоом хэлбэрээр байршуулна.
2	**Амьтдын нүдээр... (Интерактив харааны үзүүллэг)**	**Зорилго:** Амьтдын харааны онцлогийг (жишээ нь: Бүрхэг хардаг, дулаан мэдэрдэг, эсвэл 360 градус хардаг) үзэгчдэд биеэр мэдрүүлэх. **Техникийн шаардлага:** **Бүтэц:** 3 өөр төрлийн амьтны (Бүргэд, Могой, Муур гэх мэт) толгойн загварыг хүүхэд дотор нь толгойгоо хийж харах боломжтой хэмжээтэйгээр (Fiberglass материалаар) хийнэ. **Технологи:** Дотор талд нь тусгай линз (Fisheye, Dichroic filter) эсвэл VR/дижитал дэлгэц ашиглан тухайн амьтны хардаг өнгө, өнцгийг гаргана. **Суурь:** Хүүхдийн өндөрт тааруулан өндөр нь тохируулагддаг эсвэл өөр өөр өндөртэй зэвэрдэггүй ган суурьтай байна.
3	**Нарны цаг (Гномон)**	**Зорилго:** Цаг хугацаа болон одон орны анхны мэдэгдэхүүнийг туршилтаар таниулах. **Техникийн шаардлага:** **Төрөл:** Хэвтээ (Horizontal) эсвэл Глобал (Equatorial) нарны цаг. **Материал:** Гномон (цаг заагч шугам) нь зэвэрдэггүй ган (AISI 316), суурь нь байгалийн боржин чулуу байна. **Нарийвчлал:** Тухайн байршлын газар зүйн өргөрөг, уртрагт нийцүүлэн цагийг үнэн зөв заахаар инженерийн тооцоолол хийсэн байна. Хуваарь нь металл дээр гүн шивэгдсэн, арилахгүй байна.

4	**Бичил цаг уурын станц**	**Зорилго:** Байгаль орчны хэмжилт хийх шинжлэх ухааны чадвар эзэмшүүлэх. **Техникийн шаардлага:** **Иж бүрдэл:** Салхины чиглэл заагч, хурд хэмжигч (Anemometer), хур тунадас хэмжигч, агаарын температур болон чийгшил хэмжигчтэй байна. **Хийцлэл:** Харагдах байдал нь "Analog" буюу механик (хүүхэд хараад шууд ойлгохуйц) байхаас гадна дижитал дэлгэцтэй байна. **Хамгаалалт:** Вандализмын эсрэг хамгаалалттай шилэн эсвэл төмөр торон хайрцагтай, гадна зориулалтын бат бөх хийцтэй байна.
5	**Зөгий (Амьдралын мөчлөг үзүүлэх модель)**	**Зорилго:** Зөгийн бүтэц, үүрний зохион байгуулалт, экологийн ач холбогдлыг таниулах. **Техникийн шаардлага:** **Загвар:** Зөгийн үүрний (hexagonal) томруулсан модель. Нэг хэсгийг нь зүсэлт хийж доторх бүтэц (өнөөх, авгалдай, бал) харагдахаар тунгалаг акрилаар (Plexiglass) хийнэ. **Материал:** Гадна орчинд тэсвэртэй давирхай (Resin) болон полимер. **Интерактив:** Зөгийн бүжгийн хөдөлгөөн эсвэл дуу авиаг сонсгох аудио товчлуур бүхий системтэй байж болно.
6	**Кинетик энерги ба Дуу авианы тоглоом (Musical/Kinetic Forest)**	**Зорилго:** Цохилт, тервэлтээр дамжуулж дуу авианы физик шинж чанарыг ойлгуулах. **Үйлдэл:** Том хэмжээний гадна зориулалтын ксилофон (Xylophone) эсвэл металл хоолойнууд. **Техникийн шаардлага:** **Материал:** Аноджуулсан хөнгөн цагаан хоолой (өнцөг бүр нь өөр нот гаргана), байгалийн хатуу мод. **Хийцлэл:** Хоолойнууд нь гадна орчны нөлөөнд хөг алдахгүй, зэврэхгүй. Цохиур нь дурангийн суурьтай адил ган утсаар бэхлэгдсэн (гэзгдэхээс сэргийлсэн) байна.
7	**Тусгай шаардлага**	**Аюулгүй байдал:** Бүх үзүүллэгүүд нь ирмэг иртэй хэсэггүй, хүүхэд гар хуруугаа хавчуулах, унах эрсдэлгүй "Child-friendly" стандарттай байна. **Тайлбар самбар:** Үзүүллэг бүрийн хажууд "Туршиж үзээрэй", "Та мэдэх үү?" гэсэн агуулга бүхий боловсролын тайлбар самбарыг (Braille буюу харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор үсэгтэй) заавал байршуулна. **Засвар үйлчилгээ:** Бүх эд ангиуд нь солих, цэвэрлэхэд хялбар модулийн бүтэцтэй байна.

“БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХЭСЭГ”-ИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
		ШИРЭЭ БА САНДЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ
1	**Хийцлэл**	Үргэлжилсэн муруй хэлбэртэй (S-curve), ирмэг иргүй, аюулгүй загвартай.
2	**Ширээний материал**	HPL (High Pressure Laminate) хавтан эсвэл Зэвэрдэггүй ган (AISI 304) суурьтай, гадна зориулалтын Corian/Solid surface гадаргуу. Нарны гэрэлд халахгүй, өнгө алдахгүй, зурагдахгүй байна.
3	**Суурь ба хөл**	Зэвэрдэггүй ган эсвэл халуун цайрдсан ган хоолой, нунтаг будгаар (Powder coating) будсан. Газар доор бетон суурьтай бэхлэгдсэн байна.
4	**Сандал**	Ширээний муруйг дагасан салангид дугуй сандал эсвэл үргэлжилсэн вандан. Ширээтэй ижил материалтай, өндөр нь 45-55 см (хүүхдийн өндөрт тохирсон).
5	**Гадаргуугийн зураглал**	Ширээний гадаргуу дээр Байгалийн шинжлэх ухааны мэдлэг олгох (Дэлхийн газрын зураг, элементүүд, амьтны дүрс г.м) мэдээллийг лазераар шивж эсвэл хэвлэж оруулсан байна.
		СҮҮДРЭВЧ
6	**Хүртээмжтэй байдал**	Төрөл: Цайрдсан ган карказ бүхий архитектурын өвөрмөц шийдэлтэй "Tensile structure" эсвэл металл сүүдрэвч.
7	**Дээвэр**	Хэт ягаан туяаны (UV) хамгаалалттай, галд тэсвэртэй мембран эсвэл поликарбонат хавтан. Салхины ачааллыг даах инженерийн тооцоотой байна.
8	**Гэрэлтүүлэг**	Сүүдрэвчний карказ дотор далд суурилуулсан LED зурвас гэрэл (Warm white). Шөнийн цагт сургалт явуулах хангалттай гэрэлтүүлэгтэй байна.
		ТАЛБАЙН ХУЧИЛТ
9	**Материал**	Байгалийн модны бүтэцтэй боловч эдэлгээ даах WPC (Wood Plastic Composite) модон хучилт эсвэл зөөлөн резинэн (EPDM) хучилт.
10	**Дэд бүтэц**	Шалны доор ус зайлуулах системтэй, цахилгааны утаснууд далд монтажтай байна.

11	**Стандарт**	ISO 9001:2015: Үйлдвэрлэлийн чанарын удирдлага. EN 1176 / ASTM F1487: Хүүхдийн аюулгүй байдал (ирмэг, бэхэлгээ, тогтворжилт). EN 438: HPL хавтангийн нар, зурагдалт, цохилтын тэсвэр. ISO 12944 (C4/C5): Металл хийцийн зэврэлтээс хамгаалах дээд зэрэглэлийн будалт. GREENGUARD Gold: Хоргүй, экологийн цэвэр материал (VOC-гүй) стандартуудыг хангах
12	**Баталгаа**	Металл карказ: 10 жил /Бүтээцийн бат бөх байдал, хугарал, зэврэлт/ Ширээ, сандлын гадаргуу: 5 жил /Өнгө алдах, давхарга хуурах, хагарах/ Сүүдрэвчний дээвэр: 3-5 жил /Ус нэвтрүүлэх, урагдах, өнгө гандах/ Цахилгаан ба LED: 2 жил /Гэрэл асахгүй болох, богино холболт/ -ийн үйлдвэрлэгчийн баталгаатай байх.

“МУЗЕЙН УГТАХ ХААЛГА”-НЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Шалгуур	Техникийн шаардлага
1	**Бүтээц**	Өндөр бат бөх чанарын ган карказ (Steel space frame). Салхины ачаалал болон өөрийн жинг бүрэн даах инженерийн тооцоотой байна
2	**Хэмжээ**	Өргөн: ~12-14м (орцыг бүрэн хамарсан), Өндөр: 4.5м-ээс доошгүй (тусгай зориулалтын машин нэвтрэх боломжтой).
3	**Гадна өнгөлгөө**	Архитектурын хөнгөн цагаан композит хавтан эсвэл HPL хавтан. Өнгө: Байгалийн чулуун эсвэл цагаан саарал өнгөтэй.
4	**Гэрэлтүүлэг**	Хаалганы контурын дагуу IP67 усны хамгаалалттай LED зурвас гэрэл (Linear lighting). Музейн нэр болон логог дотор талаас гэрэлтдэг (Backlit) байдлаар шийднэ.
5	**Аюулгүй байдал**	Хаалганы доорх хэсэгт хяналтын камер (CCTV) суурилуулах дэд бүтэц, гэрэлтүүлгийн далд монтажийг шийдсэн байна.
6	**Суурь**	Төмөр бетон цутгамал суурь. Газрын хөлдөлтийн гүн болон хөрсний суултыг тооцсон байна.
7	**Цахилгаан хангамж ба инженер шугам сүлжээ**	Гадна шугам сүлжээ: Гүйцэтгэгч нь угтах хаалганы гэрэлтүүлэг, хяналтын камер болон бусад тоног төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай цахилгаан хангамжийн эх үүсвэрийг хамгийн ойр байрлах цэгээс тооцож, "Цахилгааны гадна шугам татах" ажлыг зураг төслийн дагуу иж бүрэн гүйцэтгэнэ. Монтаж ба хамгаалалт: Цахилгааны бүх кабель болон холболтын шугамыг газар доорх зориулалтын сувагчлал (HDPE хоолой)-аар далд хэлбэрээр татаж, аюулгүй байдлыг хангах бөгөөд угтах хаалганы дотоод карказ доторх монтажийг гадны нөлөөллөөс бүрэн тусгаарласан байна. Төсөвлөлт: Гадна шугам татах болон холболт хийх бүх зардал (материал, ажлын хөлс) нь багц ажлын үндсэн үнийн саналд багтсан байна.

8	**Харуул хамгаалалтын байр**	Архитектур дизайн: Хаалганы баруун талд байрлах харуул хамгаалалтын байрыг угтах хаалганы үндсэн констракшн, материал болон дизайны шийдэлтэй (өнгө, өнгөлгөөний хавтан, гэрэлтүүлэг) нэгдмэл байхаар цогцоор нь төлөвлөж болно. Үйл ажиллагааны нөхцөл: Харуул хамгаалалтын байр нь дулаалгатай, гадна орчныг 360° харах цонхтой, цахилгаан ба холбооны дэд бүтэц нь угтах хаалганы нэгдсэн системтэй холбогдсон байх. Материаллаг чанар: Хаалганы гадна өнгөлгөөнд ашигласан хөнгөн цагаан композит болон LED гэрэлтүүлгийн шийдлийг харуул хамгаалалтын байрны гадна фасадад ижил түвшинд ашиглаж, музейн орох хэсгийг архитектурын нэгдмэл цогц байгууламж болгох.

22. МУЗЕЙН ГАДНА ТАЛБАЙД АШИГЛАХ ЦАХИЛГААН АВТОБУСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Тээврийн хэрэгслийн загвар	Музейн гадна талбайд боловсролын хөтөлбөр болон танилцуулга аялал зориулагдсан.
		Автомашины байдал : Шинэ
		Үйлдвэрлэгдсэн огноо : Сүүлийн 2 жилийн дотор үйлдвэрлэгдсэн
		Автомашины тоо ширхэг : 3 ширхэг
2	Хөдөлгүүр	Шууд цахилгаан мотор (AC synchronous / PMSM эсвэл DC motor)
		Хөдөлгүүрийн чадал : ≥20 kW AC Motor
		Шатахууны төрөл : Цахилгаан
3	Хурдны хязгаар	~25–45 км/ц (замын нөхцөлөөс хамаарна)
4	Баттерей (Battery)	Төрөл: Li-ion (никелийнгүй) эсвэл LFP (LiFePO4) Хүчин чадал: ~60–120 kWh Аяллын зай: ~120–250 км (замын нөхцөл, жингээс хамаарна) Цэнэглэлт: • AC (Std): ~6–8 цаг • DC Fast Charge: ~1–2 цаг (80% хүртэл)
5	Ерөнхий үзүүлэлт	Төрөл: Аялал/экскурсийн автобус
		Хойд тэнхлэг : Хамааралтай / бие даасан түдгэлзүүлэлт
		Суудлын тоо: 14 хүн эсвэл түүнтэй дүйцэхүйц
		Дифференциал цоожлагч : Урд тэнхлэг + Хойд тэнхлэг
		Гэрчилгээ: CE (Европын стандартын шаардлага хангасан)
		Хэрэглээ: Аялал жуулчлал, үзвэр үйлчилгээ, төлөвлөгдсөн маршрутын тээвэр
6	Бусад	• Тав тухтай сунгасан үдэшлэг суудлууд • Таазны агааржуулалт, халаалтын систем Агааржуулалт / Кондиционер • USB цэнэглэгч порт (зорчигч бүрт) • Дуу шүүлтүүр, салхивч • Чимээгүй цахилгаан хөдөлгүүр • Хөл өвөлдөө дулаан, зундаа сэрүүн байлгах систем • Аюулгүй байдлын гар, тулгуур

___o0o___

22. ГАДНАХ ЛЕД ДЭЛГЭЦИЙН/БАРИЛГА/ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Агуулга	Тавигдах шаардлага
1.	Нэр, байршил, хүчин чадал	- Нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н гаднах лед дэлгэц **Байршил:** А блокын хойд гадна талын хана А блокын баруун хойд гадна талын хана **Хүчин чадал:** А блокын хойд гадна талын хана 260 м2 А блокын баруун хойд гадна талын хананд 273.7 м2 талбайд Гүнзгийрэлтэд (Эзлэхүүнтэй) 3D Лед дэлгэц суурилуулах
2.	Нийтлэг шаардлага	Гүйцэтгэгч нь музейн гаднах лед дэлгэцийн иж бүрэн системийг: - зураг төсөл боловсруулах; - нийлүүлэх; - суурилуулах; - турших, тохируулах; - ашиглалтад хүлээлгэн өгөх; ажлыг иж бүрнээр гүйцэтгэнэ. Ажил дараах үе шаттай байна: - Байршлын хэмжилт хийх; - Дэлгэрэнгүй зураг боловсруулах; - Тоног төхөөрөмж нийлүүлэх; - Суурилуулах; - Туршилт, тохируулга; - Сургалт, хүлээлгэн өгөх;
3.	Стандартын шаардлага	Гэрэлтүүлгийн систем дараах стандартуудыг хангасан байна. • IEC – цахилгааны аюулгүй ажиллагаа • CE тэмдэглэгээ • RoHS – хорт бодисын хязгаарлалт • ISO 9001 – чанарын удирдлага Нотлох баримт: үйлдвэрлэгчийн сертификат.
4.	Лед дэлгэцийн	- Гадна орчны архитектур, фасадын шийдэлтэй уялдсан байх; - Дэлгэцийн дүрс нь гүнзгийрэлт, эзлэхүүнтэй 3D эффект үүсгэх боломжтой, харааны гажуудал, анивчилгүй байх;

	ерөнхий шаардлага	- Суурилуулалт нь барилгын хийцэд сөрөг нөлөөгүй, задлах, засварлах боломжтой шийдэлтэй байх;
5.	Техникийн шаардлага	**Цахилгаан тэжээл** - Тэжээл: 220В / 50Гц; - Хэт хүчдэлээс хамгаалалттай; - Газардуулгатай. - Монгол Улсад ашиглагддаг цахилгаан, холбооны стандарттай бүрэн нийцсэн байх; **Удирдлагын систем** Систем нь: - 3-in-1 буюу түүнтэй дүйцэхүйц нэгдсэн удирдлагын шийдэлтэй. - контент менежментийн систем (CMS)-тэй байх; - Программ хангамжийн албан ёсны лицензтэй, шинэчлэлт хийх боломжтой байх; - Өдөр/шөнийн горимын тохиргоотой; - Төвлөрсөн хяналтын автоматжуулалтын функц RS232 болон RS485 протокол **Суурилуулалт** Гүйцэтгэгч: - Кабель татах; - Бэхэлгээ хийх; - Турших; **Туршилт ба хүлээлгэн өгөх** Дараах шалгалтыг хийж хүлээлгэн өгнө: - Суурилуулалт, туршилтын акт; - Аюулгүй ажиллагаа; - Удирдлагын ажиллагаа;
6.	Сургалт ба хүлээлгэн өгөх	Нийлүүлэгч дараах ажлыг гүйцэтгэнэ: - Туршилт, тохируулга, угсралт суурилуулалт - Сертификат, шинжилгээний үр дүнг баталгаажуулсан акт - 3–4 ажилтанд практик сургалт - Тээвэр, гааль, нөөц эд анги

____o0o____

ГАДНАХ ЛЕД ДЭЛГЭЦ

Шалгуур	Техникийн шаардлага
Ерөнхий шаардлага:	Шинэ, ашиглагдаагүй, үйлдвэрийн гаралтай.
А блокын баруун хойд гадна талын Гүнзгийрэлтэт (Эзлэхүүнтэй) 3D Лед дэлгэц	1. Төрөл: А блокын баруун хойд гадна талын Гүнзгийрэлтэт (эзлэхүүнтэй) 3D LED дэлгэц; 2. Хэмжээ: 273.7м² (Г хэлбэртэй); 3. Пикселийн алхам: ≥P5 мм; 4. Нягтрал: 4K (3840×2160) болон түүнээс дээш контентыг боловсруулах чадвартай; 5. Гэрэлтүүлэг: ≥5,500 cd/m² (Орчны гэрлээс хамаарч автоматаар тохируулах боломжтой); 6. Хамгаалалтын зэрэг: IP65 / IP66 (Бороо, цас, шороо, чийгний бүрэн хамгаалалт); 7. Ажиллах температур: -40°C ~ +60°C (Монголын уур амьсгалд зориулсан); 8. Тодролтын харьцаа: ≥ 10,000:1; 9. Харах өнцөг: Хэвтээ 160°, Босоо 140°; 10. Булангийн заадасгүй холболттой (Seamless Corner Technology) 11. Шинэчлэгдэх хурд: ≥ 3840 Hz (Гар утсаар бичлэг хийхэд зураас үүсэхгүй, нүд ядрахгүй); 12. Оролт / Гаралт: 3HDMI 2.0 Optical 1Optical, Gigabit Ethernet, RS232/485 интерфейс; 13. Аудио систем: IP66 хамгаалалттай ,≥ 200W гадна зориулалтын спикер систем; 14. Үйлдлийн систем: Android 9.0 ба түүнээс дээш эсвэл дүйцэхүйц үйлдлийн систем CPU: 2 ×

	Cortex-A72 + 4 × Cortex-A53 RAM: 4 GB,ROM: 32 GB; 15. Сүлжээний холболт: Wi-Fi 2.4G / 5G (Dual band), LAN 4G / 5G-ээр зайнаас удирдах боломжтой; 16. Хөргөлтийн систем: Хэт халалтаас хамгаалсан, гадна агаарын урсгалаар хөргөх автомат систем; 17. Эрчим хүч хэмнэлт: Динамик эрчим хүч хэмнэх функцтэй; 18. Нэгдсэн удирдлага: 3-in-1 буюу түүнтэй дүйцэхүйц нэгдсэн удирдлагын шийдэлтэй.
А блокын хойд гадна талын LED дэлгэц	1. Төрөл: А блокын хойд гадна талын LED дэлгэц; 2. Хэмжээ: ≥200W буюу түүнээс дээш хүчин чадалтай; 3. Пикселийн алхам: ≥P5 мм; 4. Нягтрал: 4K болон түүнээс дээш нягтралтай видеог сааталгүй боловсруулах чадвартай байх; 5. Гэрэлтүүлэг: ≥5,500 cd/m² (Орчны гэрлээс хамаарч автоматаар тохируулах боломжтой); 6. Хамгаалалтын зэрэг: IP65 / IP66 (Бороо, цас, шороо, чийгийн бүрэн хамгаалалт); 7. Ажиллах температур: -40°C ~ +60°C (Монголын уур амьсгалд зориулсан); 8. Тодролтын харьцаа: ≥ 10,000:1; 9. Харах өнцөг: Хэвтээ 170°, Босоо 170°; 10. Шинэчлэгдэх хурд: ≥ 3840 Hz (Гар утсаар бичлэг хийхэд зураас үүсэхгүй, нүд ядрахгүй); 11. Оролт / Гаралт: HDMI 2.0 ×3, Optical ×1, Gigabit Ethernet, RS232/485 интерфейс;

	12. Аудио систем: IP66 хамгаалалттай ,≥ 200W гадна зориулалтын спикер систем; 13. Үйлдлийн систем: Android 9.0 ба түүнээс дээш CPU: 2 × Cortex-A72 + 4 × Cortex-A53 RAM: 4 GB,ROM: 32 GB; 14. Сүлжээний холболт: Wi-Fi 2.4G / 5G (Dual band), LAN болон 4G / 5G-ээр зайнаас удирдах боломжтой; 15. Хөргөлтийн систем: Хэт халалтаас хамгаалсан, гадна агаарын урсгалаар хөргөх автомат систем; 16. Эрчим хүч хэмнэлт: Динамик эрчим хүч хэмнэх функцтэй; 17. Нэгдсэн удирдлага: 3-in-1 буюу түүнтэй дүйцэхүйц нэгдсэн удирдлагын шийдэлтэй.

Тайлбар:

Нийлүүлэх LED дэлгэцийн эцсийн загвар, бүтэц, суурилуулалтын шийдлийг зураг, техникийн шийдэл боловсруулах шатанд захиалагчтай зөвшилцөн баталгаажуулна.

Санал болгож буй тоног төхөөрөмж нь дээрх техникийн шаардлагыг хангасан буюу түүнтэй дүйцэхүйц байна.

____o0o____

Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

23. ЗОГСООЛЫН ЦАХИЛГААН АВТОМАШИН ЦЭНЭГЛҮҮР СУУРИЛУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. АЖИЛЧИД БОЛОН ҮЗЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЦАХИЛГААН АВТОМАШИН ЦЭНЭГЛҮҮР

Тендерийн өгөгдлийн хүснэгтэд бичигдсэн техникийн үзүүлэлтийг хангах, эсвэл түүнтэй дүйцэхүйц загвар, хийц, үзүүлэлттэй тоног төхөөрөмж санал болгохыг зөвшөөрнө. Хурдан цэнэглэгчийг гадна талбайн хамгийн олон машин зогсох хэсэгт байрлуулах бол 2 ширхгийг дотор зогсоолд, 3 ширхгийг гадна зогсоолд байрлуулна.

Манай улсад импортоор орж ирж буй цахилгаан тээврийн хэрэгсэл (EV)-ийг зогсоолын цэнэглэгч (AC 220V 3.5-22 кВт 32 A Level 2) болон хурдан цэнэглэгч (DC 380V 60-120 кВт 120-240A) гэсэн үндсэн хоёр төрлийг сонгох боломжтой бол автомашин үйлдвэрлэгчийн онцлогоос хамаарч доорх 4 төрлийн хошууны сонголт байдаг. Гэсэн хэдий ч манай улсад импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн 95 орчим хувь нь (GB/T 20234.2-2015) ашиглаж байна.

1. Евро стандарт (62196-3 IEC2011 CCS-2)
2. Америк стандарт (62196-3 IEC2014 CCS-1)
3. Япон стандарт (CHAdeMO: JEVS G 105)
4. Хятад стандарт (GB/T 20234.2-2015)

(DC 380V 60-120 КВТ 120-240А) ХУРДАН ЦЭНЭГЛЭГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага	Тоо хэмжээ, ш	Жишээ зураг
1	Цэнэглэгчийн төрөл	DC хурдан цэнэглэгч, 2 хошуутай	1	Цэнэглэгчийн суурилуулсан байдал
2	Нэрлэсэн чадал	7–22 кВт		
3	Оролтын хүчдэл	380–480 В		
4	Гаралтын хүчдэл	200–1000 В DC		
5	Залгуурын төрөл	(GB/T 20234.2-2015)		
6	Цэнэглэх хугацаа	20–60 минут (20–80%)		

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага	Тоо хэмжээ, ш	Жишээ зураг
7	Суурилуулалт	Ил зогсоолын талбайд		 Хошууны оролтын төрөл
8	Хамгаалалтын зэрэг	IP54–IP65		
9	Ажиллах температур	-30°C – +50°C		
10	Стандарт	IEC 61851-1 IEC 62196-2		
11	Усны хамгаалалтын түвшин	IP54		
12	Дуу чимээний хяналт	60 дБа-аас ихгүй		
13	Удирдлага	OCPP 1.6J / 2.0.1		
14	Баталгаат хугацаа	≥ 2 жил		
15	Хэрэглэгч төлбөр төлөх нөхцөл	QPay болон бүх төрлийн банкны карт		
16	Суурилуулах болон дагалдах сургалт багтсан эсэх	Тийм		

(AC 220В 3.5-22 кВт 32 А-2) ЗОГСООЛЫН ЦЭНЭГЛЭГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага	Тоо хэмжээ, ш	Жишээ зураг
1	Цэнэглэгчийн төрөл	AC зогсоолын цэнэглэгч, 1 хошуутай	5	
2	Нэрлэсэн чадал	60 / 90 / 120 кВт		

№	Үзүүлэлт	Техникийн шаардлага	Тоо хэмжээ, ш	Жишээ зураг
3	Оролтын хүчдэл	220В		Цэнэглэгчийн суурилуулсан байдал Хошууны оролтын төрөл
4	Гаралтын хүчдэл	220–380 В AC		
5	Залгуурын төрөл	(GB/T 20234.2-2015)		
6	Цэнэглэх хугацаа	8–12 цаг (20–80%)		
7	Суурилуулалт	Ил зогсоолын талбайд		
8	Хамгаалалтын зэрэг	IP54–IP65		
9	Ажиллах температур	-30°C – +50°C		
10	Стандарт	IEC 61851-23/24, ISO 15118		
11	Усны хамгаалалтын түвшин	IP54-аас багагүй		
12	Дуу чимээний хяналт	45 дБа-аас ихгүй		
13	Удирдлага	OCPP 1.6J / 2.0.1		
14	Баталгаат хугацаа	≥ 2 жил		
15	Хэрэглэгч төлбөр төлөх нөхцөл	RFID / Mobile app / Remote monitoring		
16	Суурилуулах болон дагалдах сургалт багтсан эсэх	Тийм		

23.ЗОГСООЛЫН ХААЛТ СУУРИЛУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Агуулга	Тавигдах шаардлага
1.	Нэр, байршил, хүчин чадал	- Нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н гадна авто зогсоолын талбайд - Байршил: o Байгууллагын эзэмшил хашаа руу орох, гарах хэсэгт, мөн нийтийн эзэмшлийн задгай хэсгүүдэд авто машины хөдөлгөөн хязгаарлах хэсэгт
2.	Нийтлэг шаардлага	Гүйцэтгэгч нь музейн нийтийн авто машины ил зогсоолын бүрэн автомат хаалт суурилуулах бөгөөд автомашины дугаар болон үйлдвэр, өнгө, загварыг хиймэл оюун ухаан ашиглан автоматаар таньж системд бүртгэх, улсын дугаар таних үйлдлийг 1-2 секундийн дотор өндөр нарийвчлалтай гүйцэтгэх, орсон, гарсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг 3 сарын хугацаанд хадгалах, төлбөрийн бүхий л хэлбэрийг (бүх төрлийн олон улсын болон дотоодын банкны карт, Qpay, Socialpay, Toki гэх мэт) ашиглах боломжтой байхыг шаардана. Мөн нэмэлтээр ажилчдын автомашины бүртгэлийг таниулах замаар төлбөрийн уян хатан байдлыг бий болгоно.
3.	Стандартын шаардлага	Авто зогсоолын хаалт нь дараах стандартуудыг хангасан байна. - Авто зогсоолын ерөнхий шаардлага — MNS 5342:2025
4.	Автомат хаалтын ерөнхий шаардлага	- Олон улсын чанарын шаардлага хангасан зөвшөөрөлтэй байх; - Оюуны өмчийн зөрчилгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх; - Интерьерийн зурагтай уялдуулан хэмжээ, хийцийг захиалагчтай тохирон өөрчлөх боломжтой байна. - Систем нь музейн үзмэр хамгаалалтын шаардлагад нийцсэн байна. Үүнд: - Эрчим хүчний хэмнэлттэй байх;
5.	Техникийн шаардлага	**Дугаар таних камерын шаардлага**: 1. Дугаар таних түвшин > 99% 2. Дугаар таних хурд > 80/км цаг 3. Материал: Ган 4. TCP-IP харилцаа холбоо 485 5. Хүчдэл: 220 в/110в±10% 6. Ажиллах температур: -40°C ~ +50°C

		Автомат хаалтын шаардлага: 1. Нээх, хаах хугацаа ≤6 секунд 2. Цахилгаан хангамж: AC 220V 3. Хөдөлгүүрийн хүчдэл: 200в 4. Ажиллах температур: -40°C ~ +50°C 5. Хэмжээ: 95x35x30 **Автомат цилиндр хэлбэрийн хаалт** 304 маркийн ган материалаар хийгдсэн буюу зэвэрдэггүй, өргөгдөх, буух өндөр 60 см-ээс богиногүй, удирдлага болон цахилгааны системийг бүрэн шийдсэн байна. Хүчдэл: 220 в/110в±10%
6.	Авто хаалтын нэмэлт техникийн үзүүлэлт	- Зогсоолын төлбөрийн уян хатан нөхцөлийг бий болгосон байх бөгөөд музейгээр үйлчлэх тасалбар, ажилчдын автомашины дугаар танилтыг нэмэлтээр уян хатан нөхцөлөөр шийдэх
7.	Авто зогсоолын нэмэлт стандарт	- MNS 5342:2025 стандартын дагуу авто зогсоолын талбай, зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг хангах, - Бусад музейн аюулгүй байдалтай холбоотой баримт бичгийн шаардлагыг хангасан байна
8.	Дагалдах ажил, үйлчилгээ	Нийлүүлэгч дараах ажлыг гүйцэтгэнэ: - Туршилт, тохируулга, угсралт суурилуулалт - Сертификат, шинжилгээний үр дүнг баталгаажуулсан акт - 3–4 ажилтанд практик сургалт - Гүйцэтгэгч нь зөвлөх Lord Cultural Resources LLC -ийн тайланд тулгуурлан интерьерийн шийдэл, тохижилтын зураг төсвийг зохиож, эрх бүхий этгээдээр батлуулсан зургийн дагуу угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэх. - 24 сарын үйлдвэрлэгчийн баталгаа

ГАДНА ЗОГСООЛ РУУ НЭВТРЭХ, ГАРАХ АВТОМАТ ХААЛТ

Санал болгож буй бүтээгдэхүүн нь авто зогсоолын бүрэн автомат тоног төхөөрөмж байх бөгөөд төлбөрийн систем, хяналтын камер, программ хангамж, суурилуулалт болон ажиллуулах сургалт багтсан байна.

Нийтлэг шаардлага: Автомашины дугаар болон үйлдвэр, өнгө, загварыг хиймэл оюун ухаан ашиглан автоматаар таньж системд бүртгэх, улсын дугаар таних үйлдлийг 1-2 секундийн дотор өндөр нарийвчлалтай гүйцэтгэх, орсон, гарсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг 3 сарын хугацаанд хадгалах, төлбөрийн бүхий л хэлбэрийг (бүх төрлийн олон улсын болон дотоодын банкны карт, Qpay, Socialpay, Toki гэх мэт) ашиглах боломжтой байхыг шаардана. Мөн нэмэлтээр ажилчдын автомашины бүртгэлийг таниулах замаар төлбөрийн уян хатан байдлыг бий болгоно.

Бүрэн автомат авто зогсоолын техникийн тодорхойлолт

№	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Техникийн шаардлага	Тоо, хэмжээ	Жишээ зураг
1	Дугаар таних камер	1. Дугаар таних түвшин > 99% 2. Дугаар таних хурд > 80/км цаг 3. Материал: Ган 4. TCP/IP болон RS485 интерфэйс 5. Хүчдэл: 220 в/110в±10% 6. Ажиллах температур: -40°C ~ +50°C	4	
2	Металл мэдрэгч		2	
3	Автомат хаалт (хашаатай)	6. Нээх, хаах хугацаа ≤6 секунд 7. Цахилгаан хангамж: AC 220V 8. Хөдөлгүүрийн хүчдэл: 200в 9. Ажиллах температур: -40°C ~ +50°C 10. Хэмжээ: 95x35x30см	4	

№	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Техникийн шаардлага	Тоо, хэмжээ	Жишээ зураг
4	Свитч		2	
5	Цахилгааны хайрцаг		2	
6	Сат 6 сүлжээний утас		200 метр	
7	Программ хангамж	Бүртгэлийн программ хангамж, төлбөрийн систем	2	
8	Удирдлага	Оператор шаардлагатай тохиолдолд алсаас удирдах гар удирдлага болон цахилгаангүй үед механикаар онгойх боломжтой байх	6	
9	Бусад	Таних тэмдэг, хурд сааруулагч- 6 м урттай	2	
10	Ажлын хөлс	Суурилуулалт болон программ хангамжийн сургалтын хөлс	1	
11	Автомат цилиндр хэлбэрийн хаалт	304 маркийн ган материалаар хийгдсэн буюу зэвэрдэггүй, өргөгдөх, буух өндөр 60 см-ээс богиногүй, удирдлага болон цахилгааны системийг бүрэн шийдсэн байна.	2 иж бүрдэл	

№	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Техникийн шаардлага	Тоо, хэмжээ	Жишээ зураг
				

Хавсралтаар ажлын ерөнхий төлөвлөгөөний схем зургийг хавсаргав



Төрийн нарийн бичгийн даргын 2026
оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/15 тушаалын 2 дугаар хавсралт

24. НИЙТИЙН ТАЛБАЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД НИЙЛҮҮЛЭХ ТАВИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МУЛЬТИМЕДИА ИЖ БҮРДЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Агуулга	Тавигдах шаардлага
1	Байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	Байгууламжийн нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н Нийтийн эзэмшлийн талбай нийлүүлэх тавилга, тоног төхөөрөмж, мультимедиа иж бүрдэл нийлүүлэх, түүний дагалдах ажил, үйлчилгээ. - Байршил: • А блок- 1 дүгээр давхарт 1 орон зай; • В блок- 1 дүгээр давхарт 1 орон зай; • А блок- 2 дугаар давхарт 2 орон зай; • А блок- 3 дугаар давхарт 1 орон зай; - Хүчин чадал: • А блок- 1 дүгээр давхарт (Урсдаг шатны хажуу хэсгийн сул орон зай)-153 м^2; • В блок- 1 дүгээр давхарт (Хүний үүсэл хөгжлийн танхимаас ШУ-ны танхим руу шилжих хэсгийн сул орон зай)- 74,5 м^2; • А блок- 2 дугаар давхарт (Орчлонгийн үүсэл хөгжлийн танхимаас геологийн танхим руу шилжих орон зай) -134 м^2 • А блок- 2 дугаар давхарт (Кофе шопын хажуугийн амрах хэсгийн орон зай)-168м^2; • А блок- 3 дугаар давхарт (хурлын танхим байгуулах хэсэг)-150 м^2;
2	Ажлын хамрах хүрээ	**2. Ажлын хамрах хүрээ** Гүйцэтгэгч дараах ажлыг иж бүрнээр гүйцэтгэнэ. **2.1 Интерьер зураг төсөл** • Орон зайн интерьер концепц боловсруулах; • 3D визуал зураг гаргах; • Материал, өнгөний шийдэл боловсруулах; • Ажлын зураг боловсруулах; **2.2 Тавилга, интерьер хийц** • Хүлээлгийн болон амрах бүсийн тавилга;

		• Сандал, буйдан, модуль суудлууд; • Ханын чимэглэл, декоратив хийц; • Чулуу болон тусгай материалтай интерьер хийц; **2.3 Интерактив болон мультимедиа элемент** • LED болон интерактив дэлгэцийн шийдэл; • Мэдээллийн болон чиглүүлэх систем; • Гэрэлтүүлгийн орчны шийдэл; **2.4 Инженерийн уялдаа** • Цахилгаан хангамж; • Кабелийн далд суурилуулалт; • Удирдлагын болон хамгаалалтын систем; • Барилгын дотоод инженерийн системтэй уялдуулах; **2.5 Суурилуулалт ба ашиглалтад оруулах** • Тээвэрлэлт; • Угсралт суурилуулалт; • Туршилт тохируулга; • Ашиглалтад хүлээлгэн өгөх;
3	Зорилго	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн зочдын урсгал, амрах, хүлээлгийн болон олон нийтийн ашиглалтын дотоод зам талбайг иж бүрэн интерьерийн шийдлээр төлөвлөх, үйлдвэрлэх, нийлүүлэх, угсрах, суурилуулах, ашиглалтад хүлээлгэн өгөхөд оршино.
4	Ерөнхий шаардлага	**Дизайн ба концепцийн шаардлага** Орон зайн шийдэл нь: • Музейн үзүүлэг дэглэлттэй уялдсан • Орчин үеийн, минимал хэв маягтай • Байгалийн хэлбэр, материалд суурилсан • Зочдын урсгалыг саадгүй чиглүүлэх • Амрах, түр саатах орчныг бүрдүүлэх **Аюулгүй байдал ба хүртээмж** Бүх хийц нь: • Хүүхдэд аюулгүй • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй • Галын болон хөдөлмөр хамгааллын стандарт хангасан байна. **Стандартын шаардлага**

		Ашиглах материал, тоног төхөөрөмж нь: EN / ISO / CE эсвэл түүнтэй дүйцэх стандарт хангасан байна.
5	Техникийн шаардлага	**Материалын шаардлага** Ашиглах бүх материал нь дотор орчны зориулалттай байна. • Галын ангилал: B1 буюу түүнээс дээш галд тэсвэртэй • Элэгдэл, зураас, механик нөлөөлөлд тэсвэртэй • Засвар үйлчилгээ бага шаарддаг • Байгальд ээлтэй, хоргүй, үнэр ялгаруулахгүй **Тавилга, интерьер тоноглол** Амрах болон суух тавилга • Бат бөх, тогтвортой хийцтэй • Модуль хэлбэрийн шийдэлтэй байж болно • Галд тэсвэртэй дүүргэгч материалтай • Шал зурахаас хамгаалсан суурьтай • Олон нийтийн өндөр ашиглалтад тохирсон • Цэвэрлэх, арчлахад хялбар байна **Интерактив элемент** • Touch screen, LED, проекцийн төхөөрөмж ашиглах боломжтой • Хөдөлгөөн мэдрэгчтэй болон автомат идэвхжих системтэй • Монгол болон Англи хэлний интерфэйс дэмждэг байх • Контент шинэчлэх, удирдах боломжтой байна **Гэрэлтүүлгийн шийдэл** • Ерөнхий болон орчны (ambient) гэрэлтүүлгийн хослолтой • LED гэрэлтүүлэг ашиглана • Дулаан шаргал өнгийн температуртай (ойролцоогоор 3000–4000K) • Интерактив болон чимэглэлийн гэрэлтүүлгийг тусад нь удирдах боломжтой байна **Цахилгаан ба мультимедиа систем** • 220V тэжээл, газардуулгатай • Кабелийг далд суурилуулна • Тоног төхөөрөмж бүр тусдаа автомат хамгаалалттай

		• Контент USB болон offline хэлбэрээр шинэчлэх боломжтой байна.
6	Нэмэлт	Гүйцэтгэгч дараахыг гүйцэтгэнэ: • Ашиглалтын гарын авлага • Техникийн баримт бичиг • Ажилтнуудын сургалт • Хамгийн багадаа 24 сарын баталгаа

“НИЙТИЙН ОРОН ЗАЙ”-Н ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ТҮҮНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Дүйцэхүйц зураг
1	Хүлээлгийн модуль буйдан	Хийц: Амрах хэсэгт байрлах, 10 сегментээс бүрдэх модуль буйдан Материал: Хатуу модон карказ, даавуун бүрээс, өндөр нягтаршилтай хөөс дүүргэлт Хэмжээ: Суудлын өндөр 400-450 мм, өргөн: 700-800 мм, суурийн өндөр: 200-500 мм Даац: Нэг суудал ≥120–150 кг Байршил: А блок - 1-р давхар - 6 багц	6	Багц	
2	Хүлээлгийн сандал	Материал: Өндөр нягтаршилтай хөөсөнцөр, гадна тал даавуун бүрээс Хэлбэр дүрс: Геометрийн олон дүрс Хэмжээ: Өндөр: 450-500мм, өргөн: 450-600мм (Хэлбэрээсээ хамаарч) Байршил: В блок - 1-р давхар-ШУ-ны танхимд - 120ш	120	Ширхэг	
3	Модель бүтээх	Талбайн хэмжээ: 8500х9000мм Агуулга: Хүний хөгжлийн хувьслыг харуулсан орчин бүрдүүлэх, хүмүүс хүрч болох, бодит мэдрэмж төрүүлэхүйц бат бөх хийцтэй, модель байна. Бүтээлийн зохиомжийг гаргаж захиалагчид танилцуулах материал дээр зөвлөлдөх Байршил: В блок-1-р давхар-1 багц	1	Багц	

4	Чулууны тохижилттой хана	Агуулга: Геологийн давхарга бүхий талстжсан хүрхрээт дотоод орчины тохижилтыг дэмжих ханын чимэглэл Хэмжээ: Урт: 12,000мм Өндөр: 5,700мм Далд хийц бүтэц: Зэврэлтээс хамгаалагдсан металл каркас, өндөр даацын бэхэлгээ бүхий бүтэц Дизайн хяналт: 3D эскиз, материалын дээж болон угсралтын төлөвлөгөөг захиалагчаар албан ёсоор батлуулна. Байршил: А блок - 2-р давхар- амрах хэсэгт - 1 багц	68.4	м.кв	
5	Чулуу хэлбэртэй зөөлөн сандал	Гадаргуугийн материал: Даавуу Дүүргэгч: Өндөр нягтаршилтай хөөсөнцөр эсвэл зориулалтын зөөлөвч полиэстер Дизайн: Байгалийн голын болон уулын чулууны хэлбэр, өнгө зэргийг дуурайлган хийсэн. Оёдол нь мэдэгдэхээргүй далд байх Хэмжээ: 500-700 мм Байршил: А блок - 2-р давхар-Амрах хэсэгт - 10 ш	10	Ширхэг	

